

**ЭРДЭС БАЯЛАГ ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ЭРЧИМ ХҮЧНИЙ ГАЗАР**



**БАГИЙН ТӨВИЙГ ХЯМД НАЙДВАРТАЙ ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ
“БУЦАХ ГАЗАРДУУЛГАТАЙ НЭГ ДАМЖУУЛАГЧИЙН СИСТЕМ” БГНДС-ИЙГ
СУДАЛЖ НЭВТРҮҮЛЭХ (Эрдэм шинжилгээний ажлын тайлан)**

Төслийн удирдагч: Техникийн ухааны доктор, зөвлөх инженер: Ц.Санчин

З.Шагдар

Гүйцэтгэгчид: Зөвлөх инженер: С.Жамьянжав

Инженер: Б.Эрдэнэбилэг

Улаанбаатар хот 2012

Багийн төвийг хямд, найдвартай эрчим хүчээр хангах “Буцах газардуулгатай нэг дамжуулагчийн систем / БГНДС/ - ийн цахилгаан дамжуулах шугамыг судлан нэвтрүүлэх”

Нэгдүгээр бүлэг. Буцах газардуулгатай нэг дамжуулагчийн систем (БГНДС)-ийн тухай ерөнхий ойлголт

- 1.1 Буцах газардуулгатай нэг дамжуулагчийн систем /БГНДС/-ийн онолын үндэслэл, үндсэн онцлог
- 1.2 Буцах газардуулгатай нэг дамжуулагчийн систем /БГНДС/-ийг гадаад орнуудад хэрэглэж буй туршлага
- 1.3 Багийн төв, жижиг суурин хэрэглэгчдийн цахилгаан хангамжийн өнөөгийн байдалд хийсэн судалгаа, үр дүн
- 1.4 Монгол орны нөхцөлд БГНДС-ийг туршин нэвтрүүлэх судалгааны ажлын үндсэн зорилго, зорилт

Хоёрдугаар бүлэг. Багийн төв, жижиг суурин хэрэглэгчдийн цахилгаан хангамжид Буцах газардуулгатай нэг дамжуулагчийн систем БГНДС-ийг туршин нэвтрүүлэх судалгааны ажлын арга зүй боловсруулах

- 2.1 Буцах газардуулгатай нэг дамжуулагчийн системийн үндсэн тоног төхөөрөмжүүд, технологийн шаардлага тэдгээрийн онцлог
- 2.2 Багийн төв, жижиг суурин хэрэглэгчдийг БГНДС-ээр хангах туршилт судалгааны үндсэн обьектод шаардагдах техник хэрэгслийг сонгож авах
- 2.3 Монгол улсын байгаль цаг уурын онцлог нөхцөл болон хөрсний эсэргүүцлийг тодорхойлох хэмжилт судалгааны ажлын хэсэгчилсэн арга зүй
- 2.4 Монгол орны нөхцөлд хөрсний эсэргүүцлээс хамааруулан хангай, говь, хээрийн бүсэд чадлын урсгал, газардуулгын тооцоо хийж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг сонгох арга зүй боловсруулах

Гуравдугаар бүлэг. Монгол улсын нөхцөлд БГНДС-ийг туршин нэвтрүүлэх ажлын судалгааны үр дүн

- 3.1 Говийн бүсийг төлөөлүүлэн сонгон авсан Увс аймгийн Тэс сумын Таван-Улиас багийн төвийг 20,2кВ-ын өндөр хүчдлийн /БГНДС/-ээр цахилгаан эрчим хүчээр хангах судалгааны ажлын үр дүн
- 3.2 Хээрийн бүсийг төлөөлүүлэн сонгон авсан Баян-Өлгий аймгийн Баян-Нуур сумын Цэцэгт багийн төвийг 20,2кВ-ын өндөр хүчдлийн /БГНДС/-ээр цахилгаан эрчим хүчээр хангах судалгааны ажлын үр дүн
- 3.3 Хангайн бүсийг төлөөлүүлэн сонгон авсан Хөвсгөл аймгийн Жаргалан сумын Цэцүүх багийн төвийг 20,2кВ-ын өндөр хүчдлийн /БГНДС/-ээр цахилгаан эрчим хүчээр хангах судалгааны ажлын үр дүн

Дөрөвдүгээр бүлэг. Буцах газардуулгатай нэг дамжуулагчийн систем БГНДС-ийг туршин нэвтрүүлэх судалгааны ажлын техник эдийн засгийн үр дүн, ач холбогдол

4.1 Говийн бүсийг төлөөлүүлэн сонгон авсан Увс аймгийн Тэс сумын Таван-Улиас багийн төвийг 20,2кВ-ын өндөр хүчдлийн БГНДС-ээр цахилгаан эрчим хүчээр хангах болон уламжлалт шугамын системтэй харьцуулан судалгааны ажлын техник эдийн засгийн тооцооны үр дүн.

4.2 Хээрийн бүсийг төлөөлүүлэн сонгон авсан Баян-Өлгий аймгийн Баян-Нуур сумын Цэцэгт багийн төвийг 20,2кВ-ын өндөр хүчдлийн БГНДС-ээр хангах болон уламжлалт шугамын системтэй харьцуулсан судалгааны ажлын техник эдийн засгийн тооцооны үр дүн

4.3 Хангай бүсийг төлөөлүүлэн сонгон авсан Хөвсгөл аймгийн Жаргалан сумын Цэцүүх багийн төвийг 20,2кВ-ын хүчдлийн БГНДС-ээр цахилгаан эрчим хүчээр хангах судалгааны ажлын техник эдийн засгийн тооцооны үр дүн

5. Дүгнэлт

Ашигласан ном хэвлэл

Хавсралт материалууд

УДИРТГАЛ

Сүүлийн жилүүдэд Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн үеэс эхлэн хөдөө орон нутгийг цахилгаанжуулах өргөн цар хүрээтэй бодлогыг хэрэгжүүлсэний үр дүнд манай орны хот, аймаг, ихэнх сум, суурин газрууд эрчим хүчний төвлөрсөн эх үүсгэвэрт холбогдож хөдөө орон нутгийн эрчим хүчний хангамжийн хөгжилд чанарын томоохон өөрчлөлт гараад байна. Энэ бүхний үр дүнд өнөөдрийн байдлаар төвийн эрчим хүчний системийн зэрэгцээ, баруун, зүүн, хангайн бүсийн эрчим хүчний төвлөрсөн системүүд бие даан хөгжиж, ихэнхи сумын төв суурин газрууд надвартай эрчим хүчээр хангагдаад байна. Улсын хэмжээнд байгаа нийт малчин айл өрхийн 70 гаруй хувь нь “100 000 нарны гэр” төслийн хүрээнд хамрагдан нарны эх үүсгүүрээс эрчим хүчээр хангагдаж, цаашдаа нийт малчин айл өрхийг ойрын хугацаанд эрчим хүчээр хангах нөхцөл бололцоо бүрдээд байна.

Сумын төвөөс ойролцоогоор 30-40 км зайд алслагдсан багийн төв болон фермерийн аж ахуй, сүү-тосны тасаг, хилийн цэргийн отряд, гаалийн боомтууд ба түүнтэй адилтгах хоёр мянга орчим тооны хэрэглэгчдийг эрчим хүчээр хангах асуудал өнөөдөр бараг шийдвэрлэгдээгүй байгаа бөгөөд хямд аргаар найдвартай эрчим хүчээр хангах арга зам, техникийн шийдэл бүрэн тогтоогдоогүй өнөөдрийг хүрсэн байна. Ялангуяа багийн төв нь малчин айл өрхийн үйлдвэрлэл, соёл ахуйн үйлчилгээний үндсэн нэгж болохынхоо хувьд эрчим хүчээр хангагдах зайлшгүй шаардлагатай юм. Энэ талаар саяхан болсон Улсын Их Хурлын 2008 оны сонгуулийн үеэр хэд хэдэн улс төрийн намын бодлогын мөрийн хөтөлбөрт багийн төвийг хөдөө аж ахуйн засаг захиргаа, үйлдвэрлэл үйлчилгээний үндсэн нэгж болгон өргөтгөж хөгжүүлэх, үүний тул юуны өмнө цахилгаан эрчим хүчээр хангах тухай онцлон авч үзсэн билээ.

Төр, засгаас дэвшүүлэн тавьсан энэхүү зорилтыг шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэрлэх, гадаад орны туршлагыг өөрийн орны нөхцөл байдалд судлан үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилгоор ТЭХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн дэргэд Буцах газардуулгатай ганц дамжуулагч бүхий цахилгаан дамжуулах агаарын шугам /БГГД /-ын онол- практикийн асуудлыг судлах ажлын хэсгийг байгуулж 2003 оноос судалгааны ажлыг хийж эхлээд байна. Үүний үр дүнд энэхүү шугамын системийг хэрэглэж байгаа улс орнуудын мэргэжлийн байгууллага, холбогдох мэргэжилтэнүүдтэй нь холбоо тогтоон энэ чиглэлээр хийгдэж буй олон улсын хурал зөвлөлгөөнд оролцох, зарим шаардлагатай газар туршлага судлах ажлыг хийж эхлээд байна.

Өнөөдөрийн байдлаар төвлөрсөн эрчим хүчний системээс алслагдсан хөдөө аж ахуйн бага чадлын хэрэглэгчдийг эрчим хүчээр хангахад Буцах газардуулгатай ганц дамжуулагч бүхий цахилгаан дамжуулах агаарын шугам /БГГД/-ыг Канад, Шинэ Зеланд, Австрали, Швед, Африкийн улс орнуудад өргөн дэлгэр хэрэглэж хямд аргаар найдвартай цахилгаан эрчим хүчээр хөдөө аж ахуйн хэрэглэгчдийг хангаж тодорхой амжилтанд хүрээд байна.

Гадаадын улс орнууд өөрсдийн газрын хөрс, цаг уур, газар зүйн онцлогт тохируулан энэхүү шугамын системийг хэрэглэсэн байдаг. Тухайлбал Өмнөд

Африкийн хөдөө орон нутгийн тосгон бүрд айлууд өөр хоорондоо нилээд зайтайгаар жижиг суурин бүлэг болон тархсан байдаг бөгөөд газар зүйн байдал нь маш халуун хуурай цөл эсвэл хотгор гүдгэртэй тал нутаг зонхилсон байдаг.

Шинэ Зеландад Өмнөд Африкаас өөр нөхцөлтэй бөгөөд газрын байдал нь ерөнхийдээ дов толгод ихтэй, зарим газарт хүчтэй салхилдаг бөгөөд хүйтэн чийглэг, улирлын чанартай цас ордог нь цахилгаан шугамын дамжуулагч сонгож авахад хүндрэл учруулдаг. Фермерүүд нь хоорондоо их зайтай бөгөөд цахилгааны ачаалал харьцангуй бага байдаг онцлогтой.

Австралид БГНД-г говь цөл, дов толгод ихтэй, тариа ногоо их тариалдаг, хүйтэн чийглэг төрөл бүрийн нөхцөл байдалд ашиглаж байхад Шинэ Өмнөд Уэльсэд хүчтэй аянга цахилгаантай, салхи шуурга их болдог газар ашиглаж байна.

Хойд болон Баруун Австралид газрын байдал нь ерөнхийдээ цөлөрхүү, элсэн шуургатай, температурын өөрчлөлт маш их бөгөөд аж ахуйнууд нь хоорондоо 100 км түүнээс ч хол зайд оршдог. БГНД-г зарим газарт 500 км зайд сунган татасан тохиолдол ч байна. Зарим газарт хар шороон хөрс нь маш нунтаг учир хөрсний эсэргүйцэл ихтэй, хамгаалалтын системийг зөв хийхэд нэмэлт газардуулга хийх шаардлага гардаг.

Гэтэл Малайз улсад БГНД-г уулархаг, халуун орны ширэнгэ ойн нөхцөл бүхий маш их чийглэг, харьцангуй халуун бүс нутгийг цахилгаан эрчим хүчээр хангахад ашиглаж байна. Зуны улиралд аянга цахилгаантай бороо их ордог нь газардуулгын асуудлыг хүндрүүлдэг онцлогуудтай байна.

Анхны хөдөө орон нутгийн цахилгаан түгээх сүлжээ – Буцах газардуулгатай ганц дамжуулагч /БГНД /-ийг Шинэ Зеландын зөвлөх инженер Ллойд Мандено 1924 онд фермийн суурь болон тархай бутархай суурьшсан хөдөө нутагт цахилгаан эрчим хүч түгээх зорилгоор сэджээ.

Энэхүү шийдлийн үндсэн санаа нь гурван фаз дээр үндэслэсэн фидерийг төвлөрсөн цэгт суурилуулаад түүнээсээ зүг бүр тийш нь фаз салаалуулж авах явдал байлаа. Анхны энэ санаанд нэг хүндрэл байсан нь салаалсан фаз тус бүр дээрхи ачааллын баланс байлаа. Өөрөөр хэлбэл баланс байхгүй үед газардуулгын буцах гүйдлийг дэд станц дээрхи хамгаалалтын төхөөрөмж газардлага гарснаар мэдэрч байв. Энэхүү анхны санааны үндсэн дутагдлыг трансформаторт изоляцийг нэмж ашигласнаар хожим шийдвэрлэсэн юм. Цахилгаан эрчим хүч хувиарлах БГНД-ийн үндсэн зарчим нь гурван фазын үндсэн сүлжээнээс ЦЭХ-ийг ганц дамжуулагчаар дамжуулан алс зайд байрласан тэжээлийн трансформаторт өгөх явдал юм

Нэгдүгээр бүлэг. Буцах газардуулгатай нэг дамжуулагчийн систем (БГНДС)-ийн үндсэн хувилбаруудын тухай ерөнхий ойлголт

1.1 Буцах газардуулгатай нэг дамжуулагчийн систем /БГНДС/-ийн онолын үндэслэл, үндсэн онцлог

Цахилгаан түгээх сүлжээнд газрыг буцах хэлхээнд ашиглах зарчим нь үндсэн гурван төрөл байдаг.

1. “Тусгаарлагдсан” нэг утастай систем-тусгаарлах трансформатор ба нэг утасыг хэрэглэдэг.
2. “Хосолсон” систем - тусгаарлагч трансформаторын хоёрдогч ороомгийн дунд талын цэг нь газардуулагдсан байдаг ба гол хоёр шугам гарч түүнээс нэг фазын утаснууд салаалан холбогдоно.
3. “Тусгаарлагдаагүй” систем-ердийн гурван фазын гол шугамыг хэрэглэдэг бөгөөд тэдгээрээс нэг утасыг салаалан авдаг. (тусгаарлах трансформатор хэрэглээгүй учраас тусгаарлаагүй систем гэж нэрлэсэн байна.)


Газраар буцах системийн гол асуудал бол газраар буцах гүйдэлд тохирох газардуулгыг бий болгох явдал юм. Энэ танилцуулганд дурьдсан ёсоор энэ асуудал бүхлээрээ шийдэгдэж болох болов ч онцгой тохиолдолд шаардлага хангасан зөв үр дүнд хүрэхэд эдийн засгийн үр ашгийн хувьд нарийвчилсан тооцоо хийх шаардлага гарч болох талтай.

БГНД системийн зарчмыг бусад системтэй хослуулсан олон төрлийн систем хэрэглэгддэг. Эдгээрийн заримыг дор дурьдав. Үүнд:

- (А). Газардуулсан нейтральтай 3 фазын үндсэн шугамаас салбарлуулан авсан тусгаарлах трансформаторгүй БГНД систем.
- (Б). Газардуулсан нейтральтай, тусгаарлагдсан 3 фазын үндсэн шугамаас салбарлуулан авсан тусгаарлах трансформаторгүй БГГД систем.
- (В). 2 утас ба түүнээс салбарлуулан авсан БГНД, хөндийрүүлсэн нейтральтай 2 утас бүхий 3 фазын систем
- (Г). 2 утас ба түүнээс салбарлуулан авсан БГНД, газардуулсан нейтральтай 2 утас бүхий 3 фазын систем
- (Д). “Хосолсон” буюу тусгаарлагдсан трансформаторын төвийн цэгийг газардуулсан, 2 утастай үндсэн шугам, түүнээс салбарлуулан авсан БГНД систем.
- (Е) 3 фазын системтэй бараг ижил систем

Эдгээр арга бүр нь тус тусын сайн талтай бөгөөд эцсийн шийдэл гаргахынхаа өмнө сайтар судлан шинжлэх хэрэгтэй. Дээр дурьдсан (А) ба (Б) системүүд нь харгалзан Төв Баруун ба Хартлеи мужид суурилуулагдсан. Дээрх системүүдийн үндсэн хэлхээний дэлгэрэнгүй тайлбарыг дараах байдлаар Зураг1-6-д үзүүлсэн байдлаар хийлээ. Үүнд:

(А) Тусгаарлагдаагүй 3 фазын систем



Зураг 1.

Энэ систем нь гүн газардуулсан нейтральтай, хэвийн тусгаарлагдсан 3 фазын үндсэн шугамаас тогтдог. Хөдөө орон нутаг дахь трансформаторыг тэжээхээр үндсэн шугамнаас газраар буцах ганц дамжуулагчтай шугамыг салбарлуулан авдаг.

Давуу тал

Энэ систем нь 3 фазын шугамын төгсгөл дээрх томоохон ачааллыг цахилгаанаар хангах шаардлагатай үед хамгийн тохиромжтой. Хэрэв шугаманд холбогдсон трансформаторын үзүүлэлт ба шугамын урт (багтаамжын гүйдэл)–ийг харгалзан үзэж, нэг утастай салаалсан шугамын тоог шугамын бүх уртын дагууд зохистой хэмжээнд нь барьж чадвал, үндсэн шугамын трассын дагуух газраар буцан гүйх гүйдэл бага байх болно. Энэ нь ердийн БГНД шугамын боломжоос ч илүү олон тооны хэрэглэгчийг холбон тэжээх боломжтой юм. Учир нь үндсэн ба салаалсан шугамуудын хооронд тусгаарлах трансформатор байхгүй тул хүчдэлийн тохируулгын ба хамгаалалтын үзүүлэлтүүд сайжирна.

Дутагдалтай тал

Австралийн Цахилгаан холбооны газар ба Эрчим хүч хангамжийн холбоо хоорондын гэрээний нөхцөл ёсоор үндсэн шугам нь БГНД шугамын тусгаарлалтанд тавигдах шаардлагуудыг хангах ёстой. Нейтраль ба газар нь хоорондоо холбоотой, анх баригдаж буй дэд станцид энэ шаардлага нь мөн тавигдана. New South Wales-дахь энэ төрлийн дэд станцуудын ихэнх нь Цахилгаан Эрчим хүчний хорооны мэдэлд байдаг бөгөөд томоохон хэрэглээг хангадаг. Энэ нь БГНД шугамыг судалж, ашиглаж эхлэхээс нилээд олон жилийн өмнө баригдсан байдаг.

Цахилгаан Эрчим хүчний хороо нь гол зангилаа цэгүүд дээр газардлагын нэвчилтийн гүйдлийн хамгаалалтыг суурилуулахаар зорьж байна. Нэг фазын хэлхээний урт их буюу газраар буцах хэлхээ нь тусгаарлагдаагүй тул газраар гүйх гүйдлийн хэмжээг ихэсгэж, газардлагын гэмтлийн хамгаалалтын мэдрэмжийг


бууруулдаг. Гэсэн хэдий ч, салбарласан шугамын урт ба ачаалал нь 3-н фазын системийн хувьд симметр байж чадвал газраар зөвхөн гуравдугаар гармоникийн гүйдэл гүйх тул зөвхөн 50 Гц-ийн давтамжтай гүйдлийг мэдрэх релей ашиглан газардлагын гэмтлийн хамгаалалтын мэдрэмжийг сайжруулж болно. Харамсалтай нь БГНД салаа шугам буюу нэг фаз дээр гал хамгаалагч ажилласан тохиолдолд, энэхүү систем нь ялгаж мэдэрч чадахгүй бөгөөд системийг тогтворгүй байдалд оруулна.

Энэ бүх дурьдсан зүйлсийг анхааран үзсэний үндсэн дээр Цахилгаан эрчим хүчний хороо нь өөрийн томоохон хэрэглээний зангилаа дэд станцууд дээр газраар буцах системийг шууд холбон хэрэглэхгүй байхыг чухалчлан үзэж байна. Трансформаторын соронзлох гүйдэл ба газраар буцан гүйх багтаамжын гүйдлийн баланслан барьснаар газраар гүйх үндсэн давтамжтай гүйдлийг үндсэндээ устгаж чадах боловч гуравдугаар зэргийн (гуравдугаар ба гурваар үржсэн) гармоникүүдыг устгаж чадахгүй.

Энэ гуравдугаар гармоникүүд нь арифметикаар нэмэгдэж үүсгэсэн гүйдэл нь харилцаа холбооны шуаманд ихээхэн саад учруулж болзошгүй юм. Гэхдээ Австралийн зах зээлээс олдох боломжтой, нам гармоникийн трансформаторыг хэрэглэснээр энэ сул талыг багасгаж болох бөгөөд ингэснээр трансформаторын анхдагч ороомог дээрхи синусиодын хэлбэр нь сайжирдаг.

Хэрэв синусиодын хэлбэр гажилттай, муу байвал шугамын хүчдэлийг 12,7 кВ-оос хэтрүүлж болохгүй. 3-н фазын шугамыг гурвалжин-од холболттой тусгаарлах трансформатораар секцлэн холбосноор гуравдугаар зэргийн гармоникийг устгаж болно.

(Б) 3 фазын тусгаарлагдсан систем



Зураг 2

Энэ систем нь дээр өгүүлсэн (А)-тай төстэй. Гол ялгаа нь 3 фазын үндсэн хэлхээг үндсэн системээс тусгаарласан явдал юм. Өсгөх трансформатор (жишээ нь 11 кВ-ыг 22 кВ болгох) эсвэл давхар ороомогтой тохируулгагч ашиглан тусгаарлалыг хийнэ.

Энэ 2 аргын эхнийх нь дараахи давуу талуудтай: Ижил дамжуулагчтай 22 кВ-ын систем нь 11 кВ-ын системтэй харьцуулахад 4 дахин их ачаалал даах чадвартай, барилга угсралтын ажил нь бага зэрэг илүү үнэтэй болно. Мөн 22кВ-ын шугамын түгээх трансформаторт 12.7кВ-ын БГНД стандарт трансформаторыг хэрэглэх боломжтой. Түүнчлэн 33 кВ-ын тусгаарлагдсан системийг хэрэглэж болох боловч ердийн дэд станцыг өөрчлөхөд гарах зардлыг тооцон үзэх хэрэгтэй.

Үүнээс дээшх хүчдэлийг ашиглахаар бол 22 кВ-ын хүчдэлийнхтэй харьцуулахад зардал үлэмж нэмэгдэх болно. Ихэнх тохиолдолд эдгээр дэд станцид гарах нэмэлт зардал ба тусгаарлалтанд тавигдах нэмэлт зардал нь шугамын хүчин чадлыг ихэсгэснээр гаргасан хэмнэлтээсээ илүү байдаг. 11 кВ/22 кВ-н хоёр ороомогтой трансформатор хэрэглэдэг энэ төрлийн системийг Хартлей мужид, мөн 22кВ/33 кВ-ын хоёр ороомогтой нэг трансформаторыг Маккуар сумын Нянганд ашиглаж байна.


Давуу тал

Энэ системийн тусгаарлагдаагүй 3 фазын системээс ялгарах давуу тал нь өндөр хүчдлийн хэлхээн дэхь газраар буцах гүйдлийн байрлалыг шаардлагатай бол тодорхойлох боломжтой бөгөөд урьдахь системийг бодвол хязгаарлалт бага тавигддаг.

Дутагдалтай тал

Ихэвчлэн чадал өндөртэй тусгаарлах трансформатор шаардлагатай болдог. Газраар буцах гүйдлийн замыг тодорхойлох боломжтой болон хүчдэлийн түвшинг сонгох боломжтой зэргээс бусад талаараа тусгаарлагдаагүй 3-н фазын системтэй адилхан дутагдалтай талтай.

(В) Хөндийрүүлсэн нейтральтай 2 утас бүхий 3 фазын Систем



Зураг 3.

Энэ систем нь шугамын 2 утас болон газраар буцах хэлхээнээс тогтсон 3 фазын 3 утастай систем юм. Тусгай хийцийн тусгаарлах трансформатор ба 3-н фазын түгээх трансформатор шаардлагатай.

Шаардлагатай бол бүрэн тусгаарлагдсан (газартай холбогдоогүй) нэг фазын трансформаторыг агаарын шугамын 2 дамжуулагчид холбон тэжээж болно. Энэ 3 фаз нь уламжлалт 3 фазын системийнхтэй төстэй байдлаар өөр хоорондоо 120 градус өнцгөөр байрлана. Салаа хэлхээ нь голдуу ганц утастай байдаг. Энэ системийг Орос болон Румынд ашигладаг.

Давуу тал

3 фазын тэжээлээр хангах боломжтой. 3-н фазын түгээх дэд станц дээрх тусгаарлалыг үнэлэх зорилгоор задгай "гурвалжин" ороомогтой трансформаторуудыг ашиглаж болно. Хамгаалалтын хэрэгслийн тоо 33% буурдаг.


Дутагдалтай тал

Газартай харьцуулсан хөндийрүүлгийн түвшин өндөр. 22 кВ 3 фаз дээр үндсэн системд 28.2 кВ-н эквивалент хөндийрүүлэг шаардагдана. Агаарын шугамын 2 дамжуулагч утсанд холбогдон тэжээгдэн ажиллаж байгаа ямар ч дэд станцийн трансформаторын ороомогт энэ нь хамаарна.

Газраар буцан гүйх гүйдлийг бүрмөсөн алга болгож чадахгүй бөгөөд энэ системийн 1 фазын хэлхээний нэвтрүүлэх чадвар нь адил хүчдэлтэй (газартай харьцангуй шугамын хүчдэл нь адилхан) ердийн БГНД шугамтай харьцуулахад, дөнгөж 2 дахин их ба энэ шугам нь зөвхөн 3-н фазын хэрэглээг хангаж байгаа тохиолдолд нэг утастай шугамын нэвтрүүлэх чадвараас 1,73 дахин их байдаг.


Бусад 3 фазын хосолсон системүүдтэй харьцуулбал, шугамын болон трансформаторын өртөг, зардал нь өндөр болно. Бусад системүүдтэй харьцуулахад газраар гүйх багтаамжийн гүйдэл нь их бөгөөд үүнийг реактор эсвэл өндөр соронзлолтын гүйдэлтэй трансформаторын тусламжтайгаар дарах арга хэмжээ авах шаардлагатай болдог. Ердийн шугамтай харьцуулахад холбооны шугаманд шуугиан үүсгэх нөлөөлөл нь илүү байдаг. 3 фазын болон БГНД трансформаторын аль аль нь стандарт бус хүчдэлийнх байдаг. Шугам хооронд бус шугам - газрын хооронд трансформатор холбох нь симметр бус систем үүсэх нөхцөл болдог.

(Г) Газардуулсан нейтральтай 2 утас бүхий 3 фазын Систем



Зураг 4.


1:1:1 гэсэн харьцаатай ороомгууд дахь гүйдлийн хуваарилалт болон хоёрдогч ороомог дээрх баланслалдсан 3 фазын гүйдэл



Зураг 4.

(Д). “Хосолсон” буюу тусгаарлагдсан трансформаторын төвийн цэгийг газардуулсан, 2 утастай үндсэн шугам, түүнээс салбарлуулан авсан БГНД систем.

17



Зураг 6.

Төвийн цэг нь газардуулагдсан тусгаарлах трансформатораас авсан үндсэн 2 шугамаас тогтдог. Хөдөө орон нутгийн групп хэрэглэгчдийг тэжээхийн тулд нэг утастай шугамыг 2 утастай шугамнаас салбарлуулан авдаг. 2 утастай буюу хосолсон шугамын шугам хоорондын хүчдэл нь газартай харьцангуй хүчдэлээсээ хоёр дахин их байдаг. Энэ системд газартай харьцангуй хүчдэл 19,1 кВ буюу шугам хоорондын хүчдэл нь 38,2 кВ байхыг хүлээн зөвшөөрдөг. Энэ хүчдэлийн хэмжээ нь хэвийн 33 кВ-оос илүү хэдий ч илүү нэмэгдэл тусгаарлага шаардлагагүй бөгөөд нэг фазын 33 кВ-ын системтэй харьцуулахад шугамын үзүүлэлт нь 34% ихэсдэг байна.

Өндөр хүчдэлийн нэвтрүүлэх изолятор ба давхар тусгаарлалтай ороомог зөвхөн нэг байдаг тул трансформаторын хийц энгийн болж хямдарна. Харьцуулан үзэхэд,

19,1 кВ-ын 10 кВА-ын трансформатортай БГНД дэд станц нь \$1,252 үнэтэй байдаг бол яг ийм үзүүлэлттэй бүрэн тусгаарлалтай трансформатор \$3,291 үнэтэй байдаг байна.

Зураг №2 –д үзүүлсэн график дээр энэ давуу талыг харуулав.

Дэд станц ба шугамын уртыг зөвөөр балансалж чадвал, газраар гүйх ачааллын ба багтаамжын гүйдлийг хамгийн бага хэмжээнд барьж чадна.

Энэ системийн ердийн БГНД системтэй харьцуулсан давуу талыг Зураг № 13 ба 14 – д харуулав. Соронзлолтын гүйдэл өндөртэй трансформатор ба реакторыг ашиглан багтаамжын гүйдлийг хамгийн бага хэмжээнд барьж болно. Харин Харилцаа холбооны шугамтай ойр явах тохиолдолд үүнийг хэрэглэх шаардлагагүй юм.

Ердийн БГНД шугам хэрэглэхэд харилцаа холбооны шугаманд үзүүлэх нөлөөлөл ихтэй эсвэл нэг утастай шугамын ачаалалд тавигдах шаардлага өндөр байгаа зэрэг тохиолдолд хосолсон системийг ихэвчлэн хэрэглэнэ.

БГНД шугамын газардуулгыг хийхэд хэцүү эсвэл нэг утастай харилцаа холбооны шугам байгаа болон хэрэглэгчид ойрхон газардуулга хийхийг хориглож байгаа тохиолдолд энэ асуудлыг шийдэхийн тулд гарах нэмэлт зардлыг тооцон үзэж 2 утастай ердийн тэжээлийг хэрэглэнэ.

Давуу тал

Баланслалтыг сайн хийсэн нөхцөлд, газраар гүйх гүйдлийг хамгийн бага хэмжээнд байлгаснаар газраар буцах системийн урт ба хүчин чадлыг хангалттай хэмжээнд ихэсгэж болно. Тусгаарлал дээр 1%-ийн уналт гардгийг тооцон үзэж, 19,1 кВ-ын хосолсон системийг адил дамжуулагч утастай гурван фазын 22 кВ-ын шугамтай харьцуулахад үзүүлэлт (нэвтрүүлэх чадвар) нь 20% илүү байдаг. Мөн энэ нь 7% хямд өртөгтэй байдаг. 5кВА-гийн дэд станц бүрт ойролцоогоор \$467 хэмнэлт гарна.

Хэрэв салаалсан шугамын урт их байх эсвэл ачаалал тэгш хэмтэй бус байгаагаас шалтгаалж багтаамжын гүйдэл их байгаа бол энэ гүйдлийг соронзлох гүйдэл өндөртэй трансформатор эсвэл реакторыг хэрэглэн дарна. Ачааллыг балансалснаар өндөр гармоникийн гүйдэл ба газраар гүйх үндсэн ачааллын гүйдлийг устгана. Ингэснээр фазын хүчдэл нь ижил ердийн БГНД шугамтай харьцуулахад харилцаа холбооны шугаманд үзүүлэх шуугиан 10% багасна.

Сул тал

Энэ систем нь зөвхөн нэг фазын хэрэглээг хангана. Гэсэн хэдий ч нэг фазын хөдөлгүүр ашиглаж болох учраас энэ нь тийм ноцтой асуудал биш юм. Тэжээл талын байж болох хамгийн их баланслагдаагүй (нэг фазын) ачааллаас хамааран системийг цааш нь өргөтгөх боломж нь хязгаарлагдана. Соронзлох гүйдэл өндөртэй трансформатор хэрэглээгүй тохиолдолд шугам – шугамын хооронд гүйх багтаамжын гүйдэл нь ердийн БГНД шугамтай харьцуулахад их байдаг тул $I^2 R$ (актив) алдагдал ихэснэ.

Ерөнхий зүйл

80 км хүртэлх урттай шугам сүлжээнд ердийн БГНД системийг хэрэглэх нь илүү дээр байдаг. Хэрэв шугам сүлжээний урт нь 50 км-ээс их байх эсвэл ачааллын гүйдлийн чадлын коэффициент нь багтаамж талдаа байвал соронзлох гүйдэл өндөртэй трансформатор эсвэл реактор хэрэглэх хэрэгтэй. БГНД системийг 80 км-ээс илүү сунгах шаардлагатай бөгөөд хэрэглэгчийн байрласан газар зүй нь тохиромжтой, шугамын төгсгөлд томоохон хэрэглээ эсвэл 3-н фазын хэрэглээ шаардлагагүй тохиолдолд 3-н фазын тусгаарлагдсан систем бүхий хосолсон системийг хэрэглэх нь зүйтэй.

Буцах газардуулгатай нэг дамжуулагч бүхий систем (БГНДС)-ийн онцлог талууд:

Давуу тал

1. Энгийн хялбар хийц. Хийц нь энгийн учраас маш түргэн хугацаанд барих боломжтой. Ялангуяа ганц утас татахад унжилтыг тэнцүүлэх шаардлагагүй.
2. Засвар, үйлчилгээ: Ганц утастай тул засвар үйлчилгээний зардал багасна.
3. Хөрөнгө оруулалтын зардал бага: Зөвхөн нэг дамжуулагч хэрэглэсэн учраас түгээх трансформаторын хөндийрүүлэх зэрэглэл, таслах залгах аппарат, хамгаалах хэрэгслийн тоо багасч нийт зардлыг үлэмж багасгана. Энэ бол газраар буцах ганц дамжуулагчтай системийн хамгийн чухал эдийн засгийн давуу тал юм. Энэ үзүүлэлт нь уламжлалт систем үр ашиггүй байж болох орон нутагт тус системийг хэрэглэх тооцоо хийхэд эдийн засаг санхүүгийн хувьд ашигтай болгож чадна.
4. Хэмжих: Ачааллын өсөлт гэх мэт үзүүлэлтийг тусгаарлах болон түгээх дэд станцууд дээр газардуулгын үзүүрт нам хүчдэлийн хэмжүүр тавин хялбархан шалгаж болно. Гэхдээ ажиллагсад систем хүчдэлтэй байхад газардлагын хэлхээг таслах нь аюултай гэдгийг мэдэж байх ёстой.
5. Хээрийн түймэр гарах аюулгүй: Систем зөвхөн ганц дамжуулагч хэрэглэдэг тул хүчтэй салхи шуурганы үед дамжуулагч хавирах асуудал гарахгүй. Хүчдэлтэй дамжуулагч утаснууд хавиралдснаас цахилгаан нум үүсч, хээрийн түймэр гарах шалтгаан болдог тул энэ үзэгдэл ганц дамжуулагчтай системд боломжгүй юм.

Дутагдалтай тал

1. Шилжүүлэх: Хэрэв тус системийг гурван фазад шилжүүлэх болбол тохиромжтой алгасалтын давуу тал нь ашиглагдахгүй.
2. Газардуулга: Газрын гадарга дээрх хүчдэлийн тархалтыг аюулгүй хэмжээнд барихын тул газардуулгын эсэргүүцлийг сайтар шалгах шаардлагатай. Энэ нь ашиглах үед үүсэх бага зэргийн хүндрэл юм.
3. Тусгаарлах дэд станц: Тусгаарлах трансформатор хэрэглэх нь системийн нэмэлт алдагдал ба барьж байгуулах нэмэлт зардлыг бий болгоно.
4. Анхдагч түгээх сүлжээн дэхь ачааллын баланс: Нэг фазын бүх системтэй адилаар анхдагч гурван фазын хувиарилах сүлжээний үр ашиг /АҮК/ буурна. Хамгийн их ачааллын хэмжээ нь симметр бус нэг фазын ачааллыг хангаж чадах гурван фазын анхдагч түгээх сүлжээний чадвараас маш их хамаарна.

1.2 Буцах газардуулгатай нэг дамжуулагч бүхий систем (БГНДС)-ийг гадаад орнуудад хэрэглэж буй туршлага

1924 онд Шинэ Зеландын зөвлөх инженер Лойд Мандено фермийн болон хөдөө орон нутагт тархай бутархай суурьшсан суурингуудыг Цахилгаан эрчим хүч (ЦЭХ)-ээр хангах зорилгоор анхны техникийн шийдлийг гаргажээ.

Буцах газардуулгатай нэг дамжуулагч бүхий систем /БГНДС/ -ын үндсэн зарчим нь гурван фазын сүлжээнээс нэг утастай шугамаар цахилгаан эрчим хүчийг алс зайд дамжуулж, хөдөөгийн жижиг хэрэглэгчийг цахилгаанаар хангахад оршино. Энэхүү системийн технологи нь зөвхөн хөрөнгө оруулалтыг ч, ашиглалтын зардлыг ч хэмнэх боломжийг бүрдүүлдэг, барьж байгуулах болон ашиглалт үйлчилгээний ажлыг хөнгөвчилж өгсөн их давуу талтай байна.

БГНДС -ын цахилгаан дамжуулдаг агаарын шугам нь нэг утастай, газрыг цахилгааны буцах зам болгож ашигладаг учир энэ системийг буцах газардуулгатай нэг дамжуулагч бүхий систем, ангилаар SWER шугам гэж нэрлэжээ. Энэ системийг 1930–аад онд анх Шинэ Зеландад, 1940 оноос Австралид нэвтрүүлжээ.

Шинэ Зеланд, Австрали Улсад БГНДС-ыг Хөдөө орон нутгын тархай бутархай суурьшсан, зах хязгаарын суурингуудыг ЦЭХ-ээр хангахад хамгийн тохиромжтой, гол технологи гэж үзээд Шинэ Зеланд Улс хөдөө аж ахуйн орон байхдаа 1970 он, Австрали Улс 2000 он гэхэд хөдөө орон нутгийнхаа бүх хэрэглэгчдийг БГНДС -ээр бүрэн цахилгаанжуулсан байна.

Австрали улсын 7 мужид 12,7 кВ ба 19,1 кВ хүчдэлтэй, 200 мянга гаруй км (Монгол улсын бүх шугамын нийт уртаас даруй 5 дахин их) буцах газардуулгатай нэг дамжуулагч бүхий шугам барьж ашиглалтанд оруулсан ба ашиглалтын маш баялаг туршлага хуримтлуулжээ.

Канад улс энэхүү шугамын системийг 1929 оноос эхлэн хэрэглэж ирсэн бөгөөд өнөөдрийн байдлаар 155 мянган км урт буцах газардуулгатай ганц дамжуулагч бүхий цахилгаан дамжуулах агаарын шугамаар хөдөө аж ахуйн фермер, газар тариалангийн үтрэм, үр цэвэрлэгээний пунктуудыг эрчим хүчээр хангасан байна.

БГНДС -ыг Канад, Өмнөд Африк, Зүүн өмнөд Ази, Америк зэрэг дэлхийн олон оронд хөдөө орон нутгийн бага чадлын хэрэглэгчдийг цахилгаанжуулах технологи болгож өргөн ашигласан байна.

Шинэ Зеланд, Австрали улсын туршлагауудыг судалж үзэхэд БГНДС-ыг цахилгааны хэрэглээ маш бага, хэрэглэгчдийн хоорондын зай хол, нягтрал багатай хөдөөгийн хэрэглэгчдийг цахилгаанжуулахад хөрөнгө санхүү хэмнэх хамгийн тохиромжтой, үндсэн арга технологи болгож өргөн хүрээтэй нэвтрүүлсэн байна.

Хойд болон баруун Австралийн газрын байдал нь ерөнхийдээ цөлөрхүү, элсэн шуурга болон температурын өөрчлөлт маш ихтэй, зарим тохиолдолд хоорондоо 100км түүнээс хол зайд байрласан хөдөөгийн жижиг хэрэглэгчдийг бүрэн

цахилгаанжуулсан нь манай хөдөө нутгийн баг, жижиг сууринг цахилгаанжуулах асуудлыг шийдвэрлэх боломжтойг харуулна.

Австралийн дов толгод, тариа ногоо ихээр тариалдаг, хүйтэн чийглэг, аянга цахилгаан, салхи шуурга их гардаг Шинэ Өмнөд Уэльсийн нурагт ч БГНДС-ыг ихээхэн хүрээтэй нэвтрүүлжээ. Ингэж БГНДС-ыг өргөн нэвтрүүлснээр Шинэ Зеланд, Авсрали улсын хөдөөгийн алслагдсан хэрэглэгчид эрчим хүчээр бүрэн хангагдаж амьдралынх нь түвшин хот газрынхтай бараг адилхан болжээ. БГНДС-ээр хамгийн их туршлага хуримтлуулсан, одоо хүртэл маш их судалгаа хийж, улам сайжруулах ажил хийж байгаа газар нь Австрали улс юм.

Гадаадын өндөр хөгжилтэй орнуудад ачааллын болон шугамын хүчдлийн уналтын компенсатор зэрэг орчин үеийн төхөөрөмжүүдийг бүтээж, БГНДС -ын үйлчлэх хүрээг өргөтгөж, эрчим хүчний чанарын үзүүлэлтүүдийг дээшлүүлсэн туршлага ч байна. Энэ бүх асуудлыг шийдвэрлээд, байгаль цаг уур, хөдөө аж ахуйн ижил төстэй дээрхи орнуудад энэ системийг олон жил ашиглаж ирсэн нь манай орны нөхцөлд ул суурьтай судалж нэвтрүүлэх нь өндөр ач холбогдолтой болохыг харуулж байна.

Шинэ Зеланд улсын Auckland хотод байрладаг Буцах газардуулгатай ганц дамжуулагчийн систем "SWER"-ийн нийгэмлэг, "MAUNSELL AECOM"-д "Буцах газардуулгатай ганц дамжуулагчийн систем"-ийн шугамын ажил хийдэг бөгөөд энэ талаар хийж буй ажлын талаар доорхи зураг 7-12-д үзүүлэв.



"SWER"-ийн төрөл бүрийн хүчин чадалтай трансформаторын үйлдвэрлэл. Зураг 7.



Газардуулгын утсыг сонгох тухай инженер Тони Холларт зөвлөлгөө өгч байгаа нь Зураг8.



30кВт-ын хүчин чадалтай трансформаторын хийцийн онцлог Зураг 9.



Реклюзорыг лабораторийн нөхцөлд хэрхэн шалгах тухай Зураг 10



Цахилгаан дамжуулах зэс утасны сонголт хийх онцлогийн тухай Зураг-11.



Цахилгаан дамжуулах хөнгөн цагаан утасны сонголт хийх онцлогийн тухай Зураг-12

Энэхүү нийгэмлэгийн тусламжтайгаар Лаос, Камбойж, Тажикстан улсуудад “Буцах газардуулгатай ганц дамжуулагчийн систем”-ийн шугамыг барьж байгуулах ашиглаж байна.

Шинэ Зеландын эрчим хүчний байгууллагын тусламжтайгаар Auckland хотоос Тикути, Таумарнюд тосгон, Үндэсний парк, Виллингтон, Марлборын шугамын компанийн харьяа хөдөө орон нутгийн онцлог нь ой мод ихтэй чийглэг, цаг ууртайгаараа ихээхэн онцлог юм. Шинэ Зеланд улсад энэ шугамын системийг өргөн хүрээтэй ашиглаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 160 гаруй мянган км урт “SWER”-ийн шугам ашиглаж байна.

Шинэ Зеландын хөдөө орон нутагт ажиллаж байгаа “SWER”-ийн шугамын тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн бодит байдлыг дараах 13-16 зурагт үзүүлэв.



Нэг фазын шугамын салаалсан байдал зэрэгцээ хоёр тулгуур дээр холбогдсон байгаа нь. Зураг-13



Тусгаарлагч трансформаторыг байрлуулсан байдал ба шугам хамгаалах хэрэгслэл Зураг14.



Өндөр уулын бүсэд ” SWER”-ийн шугамыг 500м-ээс хол зайд татасан байдал Зураг 15



” SWER”-ийн шугамыг фермерийн аж ахуйд өргөн хэмжээгээр хэрэглэж байна. Зураг 16.

Австрали улсын Queensland мужийн Brisband хотын “ERGON ENERGY” компанид ” SWER”-ийн шугам сүлжээний төлөвлөлтийг үндсэндээ 3 аргаар гүйцэтгэж байна. Нэгдүгээрт тусгаарлагч трансформатортой түгээх сүлжээ энэ нь түгээх сүлжээг хувиарлах сүлжээгээр тусгаарлаж байна гэсэн үг юм. Хоёрдугаарт хувиарлагч трансформатортой шугам сүлжээ, гуравдугаарт хосолмол шугам сүлжээг хэрэглэж байна. Тус улсад 11кВ, 12,7кВ,19,1кВ, 14,2кВ-ын хүчдлийн” SWER”-ийн шугам сүлжээ, 11кВ, 22кВ, 33кВ, 66кВ, 110кВ, 132кВ, 175кВ, түүнээс дээш хүчдлийн гурван фазын шугам сүлжээг үндсэн хүчдэл болгон сонгон авсан бөгөөд нам хүчдлийн гурван фазд 415В, ”SWER“-т 240В байна. Энэхүү шугам сүлжээ нь алслагдсан чадлын нягтрал багатай газруудад ихээхэн үр дүнтэй байгаа бөгөөд 200 000км шугамын 70 гаруй хувь нь “ERGON ENERGY” компанийн мэдэлд харяалагддаг байна. Сүүлийн 10 жилд хөдөө аж

ахуйдаа өргөн дэлгэр хэрэглэж байгаа бөгөөд энэхүү шугам сүлжээ нь барилга угсралтын зардлыг 30 хувь багасгахын зэрэгцээ ашиглалтын зардал нь эргэлтийн хөрөнгийн дөнгөж 2 хувийг эзэлдэг байна.

Дутагдалтай тал нь газардуулга хийхэд төвөгтэй, холбооны шугамд нөлөөлдөг бөгөөд 3 фазын чадлын хувиарлалтанд нөлөөлж, хүчдэл хянахад төвөгтэй. Авсрали улсад 89МВт чадалтай тусгаарлагч трансформатор, 256МВт чадалтай хувиарлагч трансформатор ажиллаж байгаа бөгөөд нэг трансформаторуудын дундаж чадал нь 100кВА байна. Шугам сүлжээндээ ихэвчлэн бетонон зарим тохиолдолд модон тулгуур ашиглаж байгаа бөгөөд тулгуур хоорондын зайг 300м хүртэл татах боломжтой. Хамгийн өргөн дэлгэр хэрэглэгддэг утас нь голдоо ган голчтой хөнгөн цагаан утсыг ихэвчлэн хэрэглэж байна. "SWER"-г газардуулга маш их чухал бүрэн ачааллын үед газар дээр 20В –оор эсэргүүцлийг хэмжиж тооцно. Трансформаторт газардуулгын хоёр зам хийх бөгөөд нөгөө тал дээр нь нам хүчдлийн газардуулгыг 30м/ зөвхөн тусгаарлагч трансформаторт хамаарна/ ухаж хийх ба хувиарлах трансформаторт өндөр нам тал дээр нь газардуулана.

Хүчдлийн тохируулга нь "SWER"-г хэрэглэх нэг чухал хэрэгслэл нь хүчдэл тохируулагч регуляторыг зөв сонгож ашиглах явдал юм. Австралийн баруун хойд хэсэгийн элсэрхэг хуурай цагуурын нөхцөл нь монгол орны нөхцөл байдалтай ихээхэн төстөй учраас энэ талаар сонирхож холбогдох мэдээллийг авлаа. Шугамын төгөсгөлд хүчдлийн хэмжээ 10 хувиас хэтрэх ёсгүй бөгөөд энэ үед заавал арга хэмжээ авах ёстой. Сүүлийн жилүүдэд "SWER"-н шугамын моделийг зохиож програмчлах, найдваржилт болон дамжуулах чадварыг дээшлүүлэх асуудалуудад онцгой анхаарал тавьж байна. Энэ үүднээс "SWER"-н шугамын үр ашгийг дээшлүүлэхэд шинэ технолги нэвтрүүлэх, сэргээгдэх эрчим хүчтэй хослон ажиллуулах асуудлуудыг судлах ажиллагааг эрчимжүүлж байна.

Австрали улс 1970 оноос "SWER"-н анхны шугамыг барьж эхэлсэн бөгөөд 1970 - 1990 онд 65 000км урт шугамыг барьж, 26 000 хэрэглэгчдийг эрчим хүчээр хангасан байна. Энэ үед "SWER"-н хэрэглээ 3 дахин өссөн байна. Канад улсад хэрэглэж байгаа БГНДС-ийн шугам, тусгаарлах ба түгээх трансформаторуудыг дараахи зураг 17-21-д үзүүлэв.



Канад улсад хэрэглэж байгаа "Буцах газардуулгатай ганц дамжуулагч /БГНД /-тай 15 кВ-ын цахилгаан түгээх шугамын байдал. Зураг-17



Нэг фаз газардуулгын шугамын системийн техник хэрэгслэлийн үйлдвэрлэлийн ажиллагаатай танилцаж байгаа байдал. Зураг 19.

Канад улс энэхүү шугамын системийг 1929 оноос эхлэн хэрэглэж ирсэн бөгөөд өнөөдрийн байдлаар 155.000 мянган км урт буцах газардуулгатай ганц дамжуулагч бүхий цахилгаан дамжуулах агаарын шугамыг хэрэглэж хөдөө аж ахуйн фермер, газар тариалангийн үтрэм, үр цэвэрлэгээний пунктуудыг эрчим хүчээр хангаж байна.



Ердийн гурван фазын цахилгаан дамжуулах агаарын шугамнаас ганц дамжуулагчаар хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүч түгээж байгаа байдал. Зураг 20.

Энэхүү шугамын хэрэглээ Канад улсад жил бүр өсөх хандлагатай байгаа бөгөөд бие биенээсээ ихээхэн алслагдсан газар тариалангийн фермерүүдийн эрчим хүчний хангамжинд онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Хэрвээ тухайн хэрэглэгчийг гурван фазын шугамд холбох зайлшгүй шаардлага гарвал нэг юмуу хоёр фазыг гурван фазд хувиргадаг конвертор гэдэг тусгай төхөөрөмжийг хэрэглэгч нь өөрөө дэлгүүрээс худалдан авч хэрэглэх бөгөөд энэ үед нийт чадлынхаа 80 орчим хувийг ашигладаг байна.

Тус улсад 230kV, 138 kV, 72 kV, 34,5kV, 22kV, 14,4 kV-ийн стандарт өндөр хүчдлийн шугам, 230V, 110V –ийн нам хүчдлийн стандарт хүчдэл хэрэглэж байна.



Канад улсын хөдөө аж ахуйн фермерүүдэд 3- 50 кВт түүнээс дээш хүчин чадалтай бага оврын нэг фазын трансформаторуудыг хэрэглэгчдийн эрчим хүчний хэрэгцээнд нь тохируулан үйлдвэрлэж байна. Зураг 21.

Шинэ Зеландын хөдөө орон нутагт тархай бутархай суурьшсан хүн ам, суурингуудыг Цахилгаан эрчим хүч (ЦЭХ) -ээр хангах зорилгоор анхны техникийн шийдлийг гаргаж, ердийн гурван фазын системийн оронд БГНДС-ыг ашигласан байна. Энэ системийг Буцах газардуулгатай ганц дамжуулагч систем (БГНДС) гэж нэрлэжээ.

Монгол орны нөхцөлд энэхүү шугамыг хэрэгжүүлэхийн тулд өөрийн орны хөрсний бүтэц, хөрсний эсэргүүцлийн судалгааг хэмжилт судалгааны үндсэн дээр судлан тогтоох шаардлагатай бөгөөд үр дүнг нь Буцах газардуулгатай ганц дамжуулагч бүхий шугамын хамгаалалт, автоматик, хэт хүчдлийн хамгаалалт,

газардуулгын тооцоо хийж, цоо шинэ аргачлалаар цахилгаан дамжуулах шугам, дэд станц, түүний барилга байгууламж барих техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагтай юм.

Буцах газардуулгатай ганц дамжуулагч бүхий шугам (БГНДС) –ыг Монгол орны нөхцөлд хэрэглэх асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй иж бүрэн шийдвэрлэснээр онол-практикийн хувьд шинэлэг, эдийн засгийн хувьд ихээхэн үр ашигтай техник технологийн шийдэл болохын зэрэгцээ хөдөө орон нутгийн иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд ч онцгой чухал ач холбогдолтой юм.

1.3.Багийн төв, жижиг суурин хэрэглэгчдийн цахилгаан хангамжийн өнөөгийн байдалд хийсэн судалгаа, үр дүн

1.3.1 Багийн талаарх мэдээлэл

Баг, хорооны Засаг дарга нь Үндсэн хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар төсвийн эрх захирагч биш зөвхөн Засаг захиргааны нэгжийн үүргийг гүйцэтгэж, төр засгийн бодлого шийдвэрийг ард иргэдэд хүргэж, хүн амд бүх төрлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг гардан зохион байгуулах үүрэгтэй.

1923 оны Ардын Засгийн газрын баталсан “Монгол Улсын нутгийн захиргааны дүрэм”-ээр 50 өрх тутамд нэг баг байгуулахаар анх удаа тогтоож байсан бөгөөд түүнээс хойш 1933 оны Сайд нарын Зөвлөлийн 10 дугаар хурлын болон Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 23 дугаар тогтоолоор баталсан “БНМАУ-ын багийн дүрэм”-ээр 30-100 өрх, 1954 оны Сайд нарын Зөвлөлийн “Баг, сум, хороо, хорьдын хэмжээг нарийвчлан тогтоох журмын тухай” 395 дугаар тогтоолоор /аж ахуйтны тоог/ 50-иас доошгүй өрх, 1957 оны Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 33 дугаар зарлигаар “Багийн Хөдөлмөрчдийн Депутатын хурал, тэдгээрийн гүйцэтгэх захиргааны дүрэм”-ээр хөдөөд 50-иас доошгүй өрх, төв, суурин газарт 100-аас доошгүй өрх байхаар тогтоож байжээ. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 1992 онд батлагджээ. Энэ тогтоолыг үндэслэн Засгийн газар 1992 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар “Баг, хороо байгуулахад баримтлах үндэслэлийн тухай” асуудал хэлэлцэж дараах чиглэлийг тогтоожээ. Үүнд:

а. Хөдөөд баг байгуулахдаа хүн амын тоо, нягтрал, эдийн засгийн бүтэц, байгаль газар зүй, зам харилцааны онцлогийг харгалзан тогтоох.

б. Аймгийн төв, хот/сум/-ын нэг хороо/баг/-д дундажаар 5000 хүн байхаар зохион байгуулах.

в. Сумдад нэгтгэн харьяалагдах Тосонцэнгэл, Зүүнхараа хотод тус бүр 2 баг, бусад сумдад нийлж нэгдсэн хороодод нэг баг байхаар бодож зохион байгуулах.

г. Нийслэлд дүүргийн харъяа хороог гэр хорооллын хороо нь 1,0 мянга хүртэл, орон сууцны хороо нь 2,0 мянга хүртэл өрхтэй байхаар, Гацуурт, Багахангай, Туул, Жаргалант дүүргүүдэд тус бүр 2 хороо байхаар бодож зохион байгуулахаар тус тус тогтоосон байна.

1.3.2 Баг, суурин бусад газрын өнөөгийн байдал эрчим хүчний хангамж, цаашидын хөгжлийн чиглэл

Цахилгаан эрчим хүчний хангамжийн байдлыг авч үзэхдээ одоогийн “Эрчим хүчний нэгдсэн систем” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн ажлын гүйцэтгэлд тулгуурлан хэтийн хөгжлийг өнөөгийн төр, засгаас авч хэрэгжүүлэхээр явуулж байгаа төсөл хөтөлбөрүүдэд тусгалаа олсон объектуудыг цахилгаанаар хангах асуудлын авч үзлээ.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Монгол Улсад нийт 1544 баг, үүний дотор хөдөөгийн 1066 баг үйл ажиллагаагаа явуулж байна.

Хөдөөгийн нэг багт дунджаар 250 орчим өрх айл, хөдөлмөрийн насны 489 хүн, сургуулийн насны 274 хүүхэд, сургуулийн өмнөх насны 143 хүүхэд ажиллаж, амьдарч байна.

Хөдөөгийн багийн 80,0 орчим хувь нь эрчим хүчний ямар нэгэн эх үүсвэргүй, 66,6 хувь нь холбоотой боловч дийлэнх хэсэг нь тогтмол ажиллахгүй болсон, багийн Засаг дарга нарын 41,3 хувь нь ажиллах байргүй, 32,6 хувь нь иргэддээ хүрч үйлчлэх унаагүй байна.

Багийн Засаг дарга нарын 19,1 хувь нь дээд боловсролтой, 30,5 хувь нь тусгай дунд, 30,9 хувь нь бүрэн дунд, 19,5 хувь нь бага боловсролтой байна.

Ихэнх баг нь Засаг дарга, эмчийн цалингаас өөр төсөвгүй тул бие даан үйл ажиллагаа явуулах боломж хязгаарлагдмал байна.

Баг өөрийн хэмжээнд төрийн үйлчилгээ явуулах байргүй, албан хаагчдын ажиллах нөхцөл муу зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан засаг захиргааны анхан шатны нэгжийн ажлын үр дүн өнөөгийн шаардлагад хүрэхгүй байна.

Хөдөөгөөс суурин газарт чиглэсэн шилжилт хөдөлгөөн нэмэгдэж, хотжих үйл явц эрчимтэй явагдаж байгаа нь багийн хөгжлийн өнөөгийн дүр төрхтэй холбоотой байна.

Засаг захиргааны анхан шатны нэгж багийн хөгжлийг дэмжих замаар төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг шуурхай, чанартай болгох, багийн чадавхийг бэхжүүлэх, баг, иргэд хоорондын харилцааг идэвхжүүлэн тэдгээрийн эрэлт хүсэлтийг шуурхай шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх явдал юм.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Багийн хөгжлийн дэмжих тухай” хөтөлбөрийн зорилтууд:

1. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.
2. Багийн үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх.
3. Багийн удирдлага, иргэд хоорондын харилцааг идэвхжүүлж тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, эрэлт хүсэлтийг шуурхай шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх.

Багийн хөгжлийг дэмжих гол арга хэмжээ:

-Багийн эмчийг үйл ажиллагаа явуулах байртай болгох, эмнэлгийн анхан шатны тусламжийг чанартай хүргэх, эм, эмнэлгийн хэрэгсэл, эмчилгээ-оношилгооны багаж, тоноглолын хангамжийг сайжруулах;

- Хөдөөгийн багийн Засаг дарга, хүний эмч багийн төвд байршин ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

-Багт улирлын сургалт зохион байгуулах, явуулын багш ажиллуулах замаар багийн хүүхэд, залуучуудын бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх, сургуулийн насны хүүхдийг сургууль завсардуулахгүй байх, малчдыг эрүүл мэндийн болон нийгмийн даатгал, малын даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах ;

- Багийн хүн амын тоог харгалзан улирлын чанартай гэр-цэцэрлэг ажиллуулах зэргээр сургуулийн өмнөх насны хүүхдийн сургуульд орох бэлтгэлийг хангах арга хэмжээ авах;

-Сум, багаас багийн иргэдэд соёл, урлагийн үйлчилгээ явуулах нөхцөл боломжийг бүрдүүлж, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг тэдний эрэлт хэрэгцээнд тулгуурлан явуулах.

-Багийг соёл, хүмүүжил, мэдээлэл сурталчилгааны ажил зохион байгуулахад шаардагдах байр, техник хэрэгсэлээр хангах;

- Багийг холбоожуулах, ашиглалтгүй байгаа холбооны хэрэгслийг засч сэлбэн ажилд оруулах.

-Малтай өрхийн малчидтай хөдөлмөрөө хорших гэрээ, түрээсийн хэлбэрийг нэвтрүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зэрэг замаар малгүй буюу цөөн малтай багийн өрхийг орлогын эх үүсвэртэй болгож, ядуурлыг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

-Багт нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг томилон ажиллуулах зэргээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх гол нөхцлийг нэг нь боломжтой цахилгааны эх үүсвэрээр багийн төвийг хангах асуудал болж байгаа юм.


Багийн цахилгаан эрчим хүчний байдлын судалгааг товчоолон гаргаж хүснэгт 1-д үзүүлэв.

Аймгийн багуудын судалгааны товчоо / Хүснэгт 1/


№	Аймаг	Сумын тоо	Бүх баг	Үүнээс:		
				Аймгийн төвд	Сумын төвд	Хөдөөд
1	Архангай	19	102	5	18	79
2	Баян-Өлгий	13	84	9	17	58
3	Баянхонгор	20	99	8	19	72
4	Булган	16	72	4	15	53
5	Говь-Алтай	18	83	6	23	54
6	Говьсүмбэр	3	9	5	2	2
7	Дархан-Уул	4	24	16	4	4
8	Дорноговь	14	57	5	14	38
9	Дорнод	14	58	10	14	34
10	Дундговь	15	64	9	6	49
11	Завхан	24	113	6	31	76
12	Орхон	2	19	16	1	2
13	Өвөрхангай	19	104	9	20	75
14	Өмнөговь	15	54	5	4	45
15	Сүхбаатар	13	66	9	13	44
16	Сэлэнгэ	17	49	5	18	26
17	Төв	27	103	6	31	66
18	Увс	19	89	7	19	63
19	Ховд	17	91	12	17	62
20	Хөвсгөл	23	121	10	22	89
21	Хэнтий	17	83	8	17	58

	Дүн	329	1544	170	325	1049
	Эзлэх хувь		100	11.0	21.0	67.9


Нийт багийг байршлаар нь авч үзвэл:



Нийт багийн 13 орчим хувь цахилгааны ямар нэг эх үүсвэртэй байгаа бөгөөд түүний бүтэц нь:



Багийн бүтэц зохион байгуулалт:



Зураг 22

Хөдөөгийн багийн үйлчилгээний хэлбэрийн судалгаа

Хүснэгт 2

№	Аймаг	Хөдөөгийн баг	Эрчим хүч			Үйлчилгээний төрөл				
			өндөр хүчдэлтэй	дизельтэй	СЭХ	холбоо	сургууль	хүн эмнэлэг	халуун ус	багийн төв
1	Архангай	79	40	8	1	68	10	4	1	66
2	Баян-Өлгий	58	27	2		58	15	5	6	38
3	Баянхонгор	72	11	17	2	68	4	2		55
4	Булган	53	28	3		48	7	10	2	34
5	Говь-Алтай	54	23	9	3	78	8	7	5	25
6	Говьсүмбэр	2	2			1	1	1	1	
7	Дархан-Уул	4	3			3	3	3	3	1
8	Дорноговь	38		1	1	38	1			28
9	Дорнод	34	24			22	5	9		21
10	Дундговь	49	8	4	1	47	11	11	12	35
11	Завхан	76	29	27	3	83		4	18	49
12	Орхон	2	1			1	1	1	1	1
13	Өвөрхангай	75	30	3	3	63	2	2	2	37
14	Өмнөговь	45		2	3	45		9	2	44
15	Сүхбаатар	44	22		2	34	4	27	3	31
16	Сэлэнгэ	26	24			17	9	8	3	18
17	Төв	66	26	1		58	7	12	3	37
18	Увс	63	26		1	57	3	2	1	42
19	Ховд	62	29	11	4	55		2	2	36
20	Хөвсгөл	89	14	15	1	76	4	4	3	82
21	Хэнтий	58	25		1	58	7	14	3	21
	Дүн	1049	392	103	26	978	102	137	71	701
	Эзлэх хувь		37.4	9.8	2.5					

Тайлбар: 97 сумын хүн эмнэлэг сэргээгдэх эрчим хүчинд холбогдсон.

Багийн үйлвэрлэл, үйлчилгээ:

Экспортын болон дотоодын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх үүднээс эрдэс,

түүхий эдийг боловсруулах, түүхий эд, бараа, бүтээгдэхүүний бөөний худалдааны сүлжээний объектыг цахилгаанжуулах чиглэлийг баримтлах шаардлага гарч байгаа юм.

Баг, ферм, жижиг суурингийн хөгжлийн төлөв /загвар баг/

ЗГХЭГ-ын зарим референтүүдтэй зөвлөж ярилцсаны дагуу Төв аймгийн “Эрдэнэ” суманд байгуулж байгаа загвар баг, мөн аймгийн “Алтанбулаг” суманд бий болгохоор төлөвлөж байгаа “Кибэр баг”-ийн зураг төсөлтэй танилцаж, цаашид багийг ийм загвараар төрийн үйлчилгээ явуулах ажлын байрыг авч үзэж, цахилгааны цаашдын хэрэглээг тооцсон болно.

Багийн төвийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ:

Судалгаанаас үзэхэд бодит байдалд багийн төв нь 3-10 айлтай байна. Нэг өрхийн цахилгаан тоног төхөөрөмжийн хүчин чадал 1500-1600 Вт, ажлын байрны цахилгаан хэрэгслэлийн суурилагдсан хүчин чадал 5500-6000 Вт орчим байна (тоног төхөөрөмжийн хүчин чадлыг хавсралтаар гаргав). Багийн төвийн цахилгаан эрчим хүчний тойм хэрэглээг Өвөрхангай аймгийн “Туяа” багийн жишээн дээр гаргалаа. Хэрэглээг цахилгаан дамжуулах агаар шугам холбоно гэж үзэж, математик-статистикийн туршилтын Монта-Карлогийн аргаар тооцоолсон бөгөөд 2023 он хүртэлх цахилгаан эрчим хүчний дундаж хэрэглээний прогнозыг тооцоолж гаргав.


Цахилгаан эрчим хүчний багийн ачаалал, кВт-аар

Хүснэгт 2

Цаг	Ачаалал, кВт	Их ачаалалд харьцуулсан хувь
1	12,7	33,3%
2	9,3	24,4%
3	5,7	15,0%
4	7,3	19,0%
5	9,9	25,8%
6	11,9	31,2%
7	15,9	41,6%
8	19,7	51,6%

9	18,1	47,3%
10	13,9	36,5%
11	12,3	32,2%
12	14,8	38,7%
13	16,4	43,0%
14	19,0	49,8%
15	21,6	56,4%
16	24,3	63,6%
17	27,2	71,3%
18	33,2	87,0%
19	38,2	100,0%
20	35,0	91,7%
21	29,9	78,3%
22	25,0	65,3%
23	18,9	49,3%
24	14,6	38,2%

Багийн цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийн хүчин чадлыг “Номег” гэсэн эрчим хүчний программ хангамжийн дагуу сонголоо. Эх үүсвэрийн сонголтоос үзэхэд өдөрт 451 кВт*ц эрчим хүч хэрэглэх бөгөөд оргил үед 66 кВт байхаар байна.



Зураг 23. Өвөрхангай аймгийн “Туяа” багийн цахилгаан ачаалал

Тухайн орон нутгийн онцлог, цаг агаар, эрчим хүчний нөөцийн өгөгдлийг уртраг, өргөргийн дагуу сонголт хийн өгөгдлийг гаргаж авав.

Улс орны хэмжээнд эхний ээлжинд ач холбогдол өгч цахилганжуулах баг, жижиг сууринг дараах шалгуур үзүүлэлтээр авч үзэв. Үүнд:

1. Хүн амын нягтрал, суурьшил,
2. Эдийн засгийн бүтэц, нийгэм-соёлын эрэлт хэрэгцээ,
3. Байгаль газар зүй, зам харилцааны хөгжил,
4. Хөгжлийн хэтийн төлөв,
5. Багт байгаа үйлдвэрлэл, үйлчилгээ,
6. Төв нь тогтвортой, хөдөлгөөнгүй байх зэргийг харгалзан үзнэ.

Багийн хөгжлийг дэмжих, цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлэхдээ дараах боломж нөхцлийг авч үзсэн байх. Үүнд:

1. Загвар баг байгуулах боломж,
2. ЦДАШ-д холбогдох боломж,

3. СЭХ-ний аль нэг эх үүсвэрийг барих боломж.
4. Фермер хөгжүүлэх боломж,
5. Тариалангийн усалгаат сиситем бий болгох зэрэг боломж нөхцлүүдийг харгалзан үзнэ.

1.3.3 БАГИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН СУУРИН ОБЪЕКТУУДЫГ ЦАХИЛГААНААР ХАНГАХ ЧИГЛЭЛ Газар тариалангийн хөгжлийг дэмжих

Дэлхийн зах зээл дээр гурил, буудайны эрэлт хэрэгцээ нэмэгдэж үнэ нь жилээс жилд өсөж байгаа өнөө үед газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх шаардлага бий болсон байна.

Дээрх байдалтай уялдуулан Монгол Улсын Засгийн газраас 2008 оныг “Хүнсний хангамж, аюулгүй байдлын жил” болгон зарласан ажлын хүрээнд дотоодын улаан буудайн гурил болон төмс, гол нэрийн хүнсний ногоогоор хэрэгцээгээ бүрэн хангах зорилго бүхий “Атрын гурав дахь аян”-тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг боловсруулсан байна.


Хөтөлбөрийн хүрээнд дараах объектыг цахилгаанжуулах шаардлагатай байна. Үүнд:

1. Багийг засвар үйлчилгээний газар;
2. Багийн өрхийн тариалан эрхлэгчдэд техникээр үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжүүд;
3. Үр тариа цэвэрлэх байгууламж, нөөцлөх зориулалтын механикжсан агуулах;
4. Усалгаатай тариалангийн талбай (2008 оны байдлаар 219 худаг сэргээн засварлах, шинээр 662 худаг гаргах);
5. Услалтын хуучин системийг сэргээх, шинээр ашиглалтад оруулах, усны нөөц бүхий усан сан бий болгох;
6. Хамгаалагдсан хөрсний тариалангийн талбайг нэмэгдүүлж дуслын усалгаа;
7. Зоорийн аж ахуй.

Эрчимжсэн мал аж ахуй

Засгийн газрын 2003 оны 160 дугаар тогтоолоор цахилгаанжуулах шаардлагатай багийн төвүүдийн жагсаалтыг аймаг, сумаар нь гаргасан байна. Энэ жагсаалтын дагуу тухайн сумын аль багт ямар аж ахуйг байгуулах вэ? Ямар хэмжээний цахилгаан хэрэглээтэй байхыг тооцох боломжтой юм.

Монголын улсын засаг захиргааны үндсэн нэгжүүдийн цахилгаанжуулалтын бүтцийг дараахи байдлаар илэрхийлж болох юм. Зураг 24.



Манай улсын стандарт хүчдэл: 0.4, 6, 10, 15, 35, 110, 220 кВ

Манай улсад шаардлагатай SWER шугамын нийт уртыг ойролцоогоор тооцоолбол: 50 000 км болж байна бөгөөд багийн төвтэй адилтгах аялал жуулчны бааз, хилийн цэргийн отряд, гаалийн үйлчилгээний цэгүүд, фермрүүдийг тооцоолж үзвэл энэ үзүүлэлт ихээхэн өсөх хандлагатай байна.

Хоёрдугаар бүлэг. Багийн төв, жижиг суурин хэрэглэгчдийн цахилгаан хангамжид БГНДС-ийг туршин нэвтрүүлэх судалгааны ажлын арга зүй боловсруулах

2.1 Буцах газардуулгатай нэг дамжуулагч бүхий систем /БГНДС/-ийн тоног төхөөрөмжийн судалгаа, технологийн шаардлага тэдгээрийн онцлог

Буцах газардуулгатай нэг дамжуулагч бүхий систем /БГНДС/-ийн үндсэн тоног төхөөрөмжүүд нь тусгаарлах ба түгээх трансформатор, шугамын дамжуулагч, тулгуур, аянга хамгаалалт, газардуулгын төхөөрөмж, хөндийрүүлэгчүүд, хүчдэл тохируулах болон хамгаалах хэрэгслэлүүдээс бүрдэнэ.

Трансформатор. Трансформаторын стандарт үзүүлэлтүүд. Трансформаторыг тодорхойлохдоо Австралийн Эрчим хүчний хорооноос гаргасан "5кВА-1000кВА-ын чадалтай түгээх трансформаторын үзүүлэлтүүдийн гарын авлага"-ыг ашиглахыг зөвлөж байна. Тусгаарлах дэд станцад стандарт болгон 25 кВА-ын оронд 50 кВА-ийн тоног төхөөрөмжүүдийг сонгон авах хэрэгтэй. 50 кВА-ийн тоног төхөөрөмжийн 25 кВА-ынхаас илүү гарах өртөг нь бага бөгөөд илүү чадалтай тоног төхөөрөмж

ашигласнаар ачааллыг өсгөх боломжтой ба гэмтлийн үеийн гүйдэл ихэссэнээр хамгаалалтыг хялбар болгох давуу талтай юм. Мөн илүү чадлын тоног төхөөрөмж хэрэглэснээр хүчдэлийн тохируулга илүү сайжирдаг. Илүү чадалтай трансформатор хэрэглэснээр хүчдэлийн тохиргоог сайн хийх болотжтой болж дамжуулагч утасны зардал буурдаг гэдгийг анхааран үзэх хэрэгтэй.

Трансформаторын сонголтод дүн шинжилгээ хийх. Сонголт хийхийн өмнө санал болгож буй бүх саналыг шинжилж, техникийн үзүүлэлтүүд нь тавигдах шаардлагыг хангасан (ялангуяа соронзлох гүйдэл нь шаардлага хангасан байх) трансформаторыг сонгох нь зүйтэй.

Өндөр гармоник. Хүчдэл эсвэл гүйдэл өөрчлөгдөхөд эсэргүүцлээ тогтмол барьж чаддаггүй (ачаалал нь огцом хувирч байдаг гагнуур, хувиргах техник г.м.) тоног төхөөрөмжөөс хамаарч шугамын хүчдэлийн (синусиод) хэлбэрт гажилт үүсдэг. Долгионы хэлбэрийн (синусиодын) гажилтын ихээхэн хэсгийг дэд станцын трансформаторын соронзлох гүйдэл үүсгэдэг. Төмөр зүрхэвчин дээрх хэт их ханалтаас шалтгаалан гажилт үүсдэг байна. Энэ нь трансформатор дахь төмрийн хэмжээг багасгаснаар зөвхөн төмрийн жин багасахаас гадна түүнийг ороох зэсийн урт багасч, улмаар үйлдвэрлэлийн зардлыг бууруулна гэсэн өмнө нь баримталж байсан логик ойлголтоос үүдэн зүрхэвчний хэмжээг багасгаж байснаас үүдэлтэй юм. Трансформаторын зүрхэвчинд өндөр гармоник үүсэх өөр нэг шалтгаан нь үйлдвэрлэгчдийн зардлаа бууруулах гэсэн идэвх зүтгэлээс дахиад л болдог. Учир нь зүрхэвчний нимгэн хуудсуудыг давхарлан наахдаа, нэг зэрэг 7 хүртэлх тооны олон хуудсуудыг зэрэг нийлүүлж наадаг бөгөөд тэдгээрийн барьцалдах гадаргуугийн хооронд бий болдог бага боловч агаарын завсрыг анхаардаггүй. Үүний улмаас агаарын завсар үүссэн хэсэгт соронзон гүйдэл өнгөрөх хөндлөн огтлолын талбай багассанаас илүү ханалтанд орох нөхцөл бүрддэг байна. Трансформаторын зүрхэвчийг нэг нэгээр нь нягт барьцалдуулж нааж хийснээр, гармоникын агуулгыг ихээхэн хэмжээгээр багасгаж чадна. Нийтлэг үзэл баримтлалын эсрэг сонирхолтой зүйлийг тэмдэглэж хэлэхэд, дугуй зүрхэвчтэй трансформатор нь өндөр гармоникийг хамгийн ихээр үүсгэдэг байна. Ерөнхийдөө үйлдвэрлэгчид нь агаарын завсар байхгүй бол 50 Гц-д үзүүлэх соронзон эсэргүүцэл багасдаг гэсэн давуу талыг баримтлан зардлаа бууруулахын тулд дугуй зүрхэвчийг хийдэг бөгөөд соронзлох гүйдэл хамгийн их хязгаараасаа хэтрээгүй (ханалтанд ороогүй) үед ч гэсэн ердийн зүрхэвчтэй харьцуулахад өндөр гармоникийн агуулга нь их байдаг байна.

Хөдөө орон нутагт өндөр гармоник үүсгэдэггүй трансформаторуудыг ашигласнаар холбооны утсанд үзүүлэх шуугианыг мэдэгдхүйц багасгаж болно. Энэ шаардлага нь голдуу түгээх трансформаторуудад хамаарна. Үүнтэй холбоотойгоор БГНД-ийн системийн түгээх трансформаторт дараахи шаардлага тавигдана. Үүнд: Шуугианы хэмжээг хэмжигч псофометр багаж ба цуваа индукцлэлээр хэмжээд гарсан шуугиан үүсгэх эквивалент гүйдэл нь 250 В-ын хэвийн хүчдэл өгөхөд кВА бүрд 2.0 мА-аас ихгүй, 10%-иар их хэвийн хүчдэл өгөхөд кВа бүрд 5,0 мА-аас ихгүй байна. Харин 5 кВА-гийн трансформаторын хувьд, өмнө дурьдсан 2 нөхцөл тус бүрд харгалзан 2.5 мА ба 6.5 мА-аас ихгүй байна.

Соронзлох гүйдэл өндөртэй трансформатор. Багтаамжийн гүйдэл нь шугамын алдагдал болон хүчдэлийн хэлбэр гажилт үүсгэх шалтгаан болж байгааг анхааран үзэж (Бүлэг 9-г үз), соронзлох гүйдэл өндөртэй трансформатор, эсвэл реактор хэрэглэх нь зүйтэй. Эдгээрийг хэрэглэснээр 50 Гц багтаамжийн гүйдлийг устгаж болох ба үүний үр дүнд 3 фазын үндсэн хэлхээтэй шугамын 1 фазын ачаалал бууж, шугамын алдагдал багасна. Багтаамжийн гүйдлийг компенсациалж устгах 2 арга бүрийн нэг тохиолдолд нь соронзлох гүйдэл өндөртэй трансформаторыг ашиглаж болно.

Хэрэв багтаамжийн гүйдлийг хамгийн бага түвшинд барьж байхыг хүсвэл, нэг км тутам дахь хэрэглэгчдийн трансформатор нь тодорхой хэмжээтэй соронзлох гүйдлийг үүсгэж байхаар төлөвлөх хэрэгтэй. Энэ нөхцөлд, хэрэв 19,1 кВ-ын хүчдэлтэй шугамын 6 км тутамд нэг хэрэглэгч байдаг бол нэг хэрэглэгчид оногдох багтаамжийн гүйдэл нь, $0,037 \times 6 = 0,22$ А байх болно. Багтаамжийн гүйдлийг дарахад шаардлагатай энэ хэмжээ нь 4,2 кВар болох бөгөөд 5 кВар чадалтай трансформаторын бүрэн ачаалалтай тэнцэх хэмжээ юм. Дээр дурьдсан схемд маш олон янзын соронзлох гүйдэлтэй трансформаторуудыг ашиглах шаардлагатай болно. 5 кВар чадалтай соронзлох гүйдлийн стандарт трансформаторуудыг ашиглан энэ асуудлыг шийдэж болно. Эдгээрийг 19,1 кВ шугамын хувьд 7 км тутамд, 12,7 кВ шугамын хувьд 10,5 км тутамд байршуулбал практикт хамгийн их ойртож байна. Бусад төрлийн стандарт трансформаторуудыг шугаманд холбон ашиглавал үүсэх соронзлох гүйдэл нь бага байх (5 кВА трансформаторын хувьд ойролцоогоор 1/8 кВар үүсгэнэ) ба бага нөлөө үзүүлэх болно. Эдгээр трансформаторуудын алдагдал нь ердийн хийцийн трансформаторынхаас их байх хэрэгтэй болно. 19,1 кВ-ын шугамын 5кВар хэмжээтэй багтаамжийн гүйдлийг компенсациалж дарах зориулалттай 10 кВА-ын трансформаторын ачаалалгүй үеийн алдагдлыг ойролцоогоор 45 Вт-аас 120 Вт болтол нэмэгдүүлэх ба үүссэн нэмэлт гүйдлийг даахын тулд анхдагч ороомгийн хөндлөн огтлолыг 2 дахин ихэсгэдэг. 5кВар/10кВА трансформаторын бүрэн ачаалалтай үеийн алдагдал нь 1,0 пкФ-д 350 Вт, 0,8 пкФ-д 430 Вт байна. Гэсэн хэдий ч багтаамжийн гүйдлийг багасгаснаас шугам дээрх актив алдагдал буурах тул энэ алдагдал нь тодорхой хэмжээгээр нөхөн төлөгдөнө.

Өндөр соронзлолтой гүйдлийг үүсгэх зориулалттай трансформатор нь уламжлалт хийцийнхээсээ илүү үнэтэй байх ба харин 80%-иас илүү үнэтэй байх ёсгүй. 5 кВар багтаамжийн гүйдлийг дарах зориулалттай 5 кВА трансформаторын нэмэлт өртөг нь км шугам тутамд 57\$ байна.

Зүрхэвчний хооронд агаарын завсар үүсгэснээр илүү их соронзлох гүйдлийг гаргаж авдаг. Соронзлох гүйдлийг ихэсгэхийн тулд зүрхэвчийг өөрчлөх, хөдөлгөх нь өндөр гармоникийг ихэсгэж, үүний улмаас холбооны шугаманд хортой нөлөөг үзүүлэхэд хүргэж мэднэ. Энэ талаараа өндөр соронзлолтой трансформатор нь дутагдалтай бөгөөд дуу чимээ ихтэй байдаг. Энэ трансформаторыг ихэвчлэн хэрэглэгчтэй ойр байрлуулдаг тул үүсгэх ихээхэн шуугианыг байнга мэдэрч байдаг. Нөгөө талаас авч үзвэл реакторыг хэрэглэгчээс зайтай байрлуулж болох тул хэрэглэгчид ийм түвэг учруулахгүй.

Реакторууд. Их хэмжээний багтаамжийн гүйдлийг дарахад соронзлох гүйдэл өндөртэй трансформаторын оронд салангид реакторыг хэрэглэж болно. Гэхдээ эдгээрийн нэгжийн чадал нь 25 кВар-аас хэтрэх ёсгүй. Үүнээс их чадалтай бол багтаамжийн гүйдлийн хэмжээг хэт ихэсгэх магадлалтай. 25 кВар-ын чадалтай




реакторын өртөг нь 5 кВар чадалтай соронзлох гүйдэл өндөртэй таван ширхэг трансформаторын нэмэлт зардлаас ихэвчлэн бага байдаг. Трансформатортай адил тал нь зүрхэвчний хэмжээг хамгийн бага байлгах хэрэгтэй бөгөөд агааран завсрыг хэрэглэн соронзлох гүйдлийг ихэсгэнэ. Өөр аргаар соронзлох гүйдэлд нөлөөлвөл ихээхэн хор нөлөөтэй өндөр гармоникүүд үүсч мэднэ.

Хүчдэл тохируулагчууд. БГНД шугаманд хүчдэл тохируулагчийг хэрэглэх шаардлага гарч болно. Хүчдэл тохируулагчийг тусгаарлах трансформаторын өөрийнх нь дэргэд байрлуулах нь хамгийн тохиромжтой байрлал юм. Тусгаарлах трансформаторын гуравдагч ороомогт холбоотой автотрансформатораас тэжээгддэг гэдрэг өсгөх трансформаторыг тусгаарлах трансформаторын анхдагч тал руу буцаан холбох аргаар хүчдэлийг тохируулах нь харьцангуй хямд зардалтай байдаг. Гэдрэг өсгөх трансформаторын чадал нь тусгаарлах трансформаторын чадлын 5%-тай ойролцоогоор тэнцүү байх шаардлагатай. 100 кВА, 22/12,7 кВ тусгаарлах трансформаторын хувьд, гэдрэг өсгөх трансформатор нь 250 В-ыг 1100 В хүртэл (22 кВ-н 5%) өсгөдөг ба чадал нь 5 кВА байх нь тохиромжтой байдаг. Анхдагч хүчдэлд тавигдах шаардлагын хэмжээнд нийцүүлэн хоёрдогч ороомгийг бүрэн хөндийрүүлсэн байна. Автотрансформатор нь 250 В-ын ороомгийн нийт уртад нь хүрэлцэн өнхөрдөг контакт ба төмөр зүрхэвчинд нэг үеэр ороосон спираль ороомгоос тогтоно. Хүчдэл мэдрэгч релегээр удирдагддаг цахилгаан хөдөлгүүрээр дамжуулан өнхөрдөг контактыг удирдана. Дээр дурьдсан схем болон өөр хоёр төрлийн хувилбарыг Зур. 16-д үзүүлэв.

Хэрэв автотрансформаторыг өндөр хүчдлийн тоног төхөөрөмжөөс хол тулгуурын доор байрлуулсан бол хөдөлгөөнтэй эд ангийг нам хүчдэлийн байрлалд нь тавиад хүчдэлийг салгалгүйгээр техникийн засвар, үйлчилгээ хийх боломжтой ийм төрлийн тохируулагчийн давуу тал юм. Техник үйлчилгээ хийхийн өмнө өнхөрдөг (хүчдэл тохируулах) контактыг хамгийн бага хүчдэлийн байрлалд тавих ба гэдрэг өсгөх трансформаторын үзүүрүүдийг богино холбох шаардлагатай.

Гэдрэг өсгөх нь трансформатор нь гүйдлийн трансформаторын зарчмаар ажилладаг тул энэ трансформаторын үзүүрүүдийг задгай орхивол үзүүрүүдийн хооронд өндөр хүчдэл үүснэ гэдгийг анхаарах хэрэгтэй.

Ирээдүйд статик түлхүүр (таслуур) илүү боловсронгуй болж хөгжих нь эргэлзээгүй тул засвар, үйлчилгээ шаарддаггүй тохируулагч хийх боломжтой юм. Ирээдүйд хийгдэх өргөтгөлийг төлөвлөхдөө энэ боломжийг анхаарахгүй байж болохгүй.



Зураг 16.

Буцах газардуулгатай нэг дамжуулагч бүхий систем (БГНДС)-ийн хүчдэлийн сонголт

Австралийн Цахилгаан Эрчим Хүч Хангамжийн холбоо нь 12,7 кВ ба 19,1 кВ-ын хүчдэлийн хэмжээг газраар буцах системийн хувьд стандарт гэж хүлээн зөвшөөрдөг. Дараах үзүүлэлтүүдээс хамаарч хүчдэлийг сонгон авдаг. Үүнд:

1. Зардал: Өгөгдсөн чадлыг дамжуулахад хүчдэл өндөр байх тутам шугамын зардал хямдрах боловч дэд станцууд нь их үнэтэй болдог. Нийт эдийн засгийн үзүүлэлт хангагдаж байхаар шугамын зардал ба дэд станцын зардлын балансыг авч үзэх хэрэгтэй.
2. *Хүчдэлийн тохируулга*: Хүчдэл хэдий чинээ өндөр байх тусам хүчдэлийг тохируулах нь төдий чинээ сайн байдаг. Урт шугамаас бусад тохиолдолд хүчдэлийг өндөрсгөх нь цорын ганц хангалттай хүчин зүйл биш юм. Зарим тохиолдолд холбооны шугамтай зохицуулах гэх мэт бусад шаардлагад нийцүүлэх үүднээс их хөндлөн огтлолтой дамжуулагч, эсвэл нам хүчдэл хэрэглэх нь ашигтай байдаг.
3. Багтаамжийн гүйдэл: Хүчдэл өндөр байх тусам багтаамжийн гүйдэл ихсэж, анхдагч системийг хэт ачааллаж, шугамын алдагдлыг ихэсгэж болно.
4. Холбооны шугамтай зохицуулах: Холбооны шугам дахь нөлөөлөл нь газраар гүйх багтаамжийн гүйдлийн гармоникоос ихээхэн хамаардаг. Гэтэл газраар гүйх багтаамжийн гүйдэл нь хүчдэл ихсэхээр дагаж ихэсдэг. 19,1 кВ-ын систем нь хүчдэлийн ижил хэлбэртай 12,7 кВ-ын системтэй харьцуулахад холбооны шугаманд нөлөөлөл нөлөөлөл нь 50% илүү байдаг.

Эрчим хүчний байгууллага нь эдгээр хоёр стандарт хүчдэлийг хатуу мөрддөг. Учир нь 12,7 кВ ба 19,1 кВ нь 22кВ ба 33 кВ-ын гурван фазын системийн газартай харьцангуй ажлын хэвийн хүчдэл учраас энэ хүчдэлийн стандарт тусгаарлагч, цэнэг шавхагч ба хуваарилах байгууламжийг хэрэглэх боломжийг олгодог. Эдгээр хүчдэлүүдийг нам хүчдэлтэй харьцуулахад нэвтрүүлэх чадвар өндөртэй бөгөөд системийн ихэнх хэсэгт ган дамжуулагч хэрэглэх боломжтой байдаг.

Зарим инженерүүд нь 11 кВ шугамын хүчдэлийн стандартыг газраар буцах ганц дамжуулагчтай системд хэрэглэх хэрэгтэй гэсэн үзэл бодлыг баримталдаг. Гэсэн хэдий ч 11 кВ-ын газраар буцах ганц дамжуулагчтай системд гэдэг нь ердийн системийн $11\text{kV} \cdot \sqrt{3}$ буюу 19,1 кВ шугамын хүчдэлтэй ердийн системийн нэг фаз юм. Хөндийрүүлгийн түвшинг хадгалахын тулд 22кВ-ын тоноглолыг ашиглах ёстой болдог нь түүний давуу байдлыг бүрэн хадгалахад сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай.

Нөгөө талаар 11 кВ-ын газраар буцах ганц дамжуулагчтай систем нь 12,7 кВ-ын буцах ганц дамжуулагчтай системийн шугамын үзүүлэлтүүдийн зөвхөн 75%-тай тэнцдэг нь түүний ноцтой сул тал юм. 11 кВ газраар буцах ганц дамжуулагчтай системийг дэмжигчид энэ хүчдэлийг сонгох нь уламжлалт 11 кВ хүчдэлийн трансформаторыг буцах ганц дамжуулагчтай системд ашиглах боломж олгоно гэж үздэг. Тэгвэл энэхүү харилцан орлох чадварыг хангахын тулд нэг бол хүлээн зөвшөөрөгдсөн тусгаарлалын түвшинг бууруулах (энэ нь холбооны шугаманд шуугиан үүсгэх эх үүсвэр болж, техник үйлчилгээний зардлыг нэмэгдүүлнэ), эсвэл БГНД системийн тоноглолуудад нэмэлт тусгаарлалыг бий болгоно. Сүүлийн тохиолдолд хэрэв эдгээр тоноглолууд ердийн системд хэрэглэгдэх зориулалттай бол нэмэлт зардал гаргах шаардлагатай болно.

БГНД системийг ашиглах санал дэвшүүлж буй Эрчим хүчний байгууллага нь энэ системд зөвхөн тусгай зориулалт, хийцийн тоног төхөөрөмж хэрэглэх нь баталгаатай байх болно гэдгийг зөвшөөрч дэмжих ёстой. Уламжлалт изоляцийн түвшнээс хазайх нь шугам байнга тасрах, эсвэл холбооны шугаманд шуугиан үүсэх гэм мэтээр ашиглалтанд гэмтэл, саатал учруулах эрсдэлтэй.

Иймээс тухайн орон нутагт БГНД системийг нэвтрүүлэх тохиолдолд, түгээх болон тусгаарлах бэлтгэл трансформаторуудыг суурилуулах шаардлагатай болох ба үүнийг БГНД системийн эдийн засгийн давуу талуудыг тооцохдоо анхаарч үзсэн байх ёстой.

Шинэ Өмнөд Уэльсын Баруун нутаг гэх мэт алслагдсан суурин газруудад илүү өндөр хүчдэлийн шугам ашиглах шаардлагатай бөгөөд энэ тохиолдолд 19,1 кВ-ыг хэрэглэх нь боломжийн юм.

Өргөн уудам нутагт цахилгаан эрчим хүч түгээх шаардлагатай эдгээр тохиолдолд 19,1 кВ-ын "Хосолсон" системийг хэрэглэх нь тодорхой давуу талтай, хамгийн ашигтай гэж үзсэн юм.

Буцах газардуулгатай нэг дамжуулагч бүхий систем (БГНДС)-ийн цахилгаан үзүүлэлтүүд:


Хуурмаг эсэргүүцэл: Газраар буцах гүйдлийн гүйх дундаж гүн нь ерөнхийдөө газрын түвшнээс доош 1500 м байдаг. Харин буцах гүйдэлд металл дамжуулагч ашиглаж байгаа тохиолдолд буцах гүйдэл нь фазаар гүйх гүйдлээсээ ойролцоогоор 1 м-ийн зайнд тусгаарлагддаг. Газраар буцах ганц дамжуулагчтай системийн фазаар гүйх гүйдэл ба буцах гүйдлийн хоорондын тусгаарлал ингэж ихэссэний улмаас газраар буцах хэлхээний хуурмаг эсэргүүцэл нь нэг километр 0.46 Ом (50 Гц) буюу ердийн металл утастай шугамтай харьцуулахад их байдаг. Бодит эсэргүүцэл: Газраар буцах хэлхээний актив эсэргүүцэл нь агаарын шугамын дамжуулагчийн эсэргүүцэл болон газраар буцах гүйдлийн хэлхээний зөвшөөрөгдөх эсэргүүцэл буюу $0.001 \cdot f = 0,05 \text{ Ом/км}$ -ийн нийлбэрээр тодорхойлогдоно. Шугамын үзүүлэлтүүдийг харуулсан хүснэгтэнд тусгаарлах болон түгээх дэд станцууд дээрх газардлагын эсэргүүцлийг тооцоогүй болно. Аюулгүй ажиллагааны үүднээс газардуулгын эсэргүүцлийг тодорхой хязгаарын утганаас доогуур барих ёстой тул энэ эсэргүүцэл дээр унах хүчдлийн уналт нь хүчдэлийн тохируулганд мэдэгдэхүйц нөлөө үзүүлж чадахгүй. Жишээ нь: 25 кВА, 12,7 кВ-н тусгаарлах дэд станцын бүрэн ачаалал нь ойролцоогоор 2 А байхад, хүчдэлийн уналтыг 60 В буюу 0,5% дээр барихын тулд газардлагын эсэргүүцлийг 30 ом байлгах хэрэгтэй. 12,7 кВ-н хүчдэлтэй, 0,4 А орчим бүрэн ачаалалтай, 5 кВА-н түгээх дэд станцын хувьд хүчдлийн уналтыг ижил хэмжээнд барихын тулд газардлагын эсэргүүцлийг 150ом байлгах хэрэгтэй.

Хүчдэлийн тохируулга: Нийлбэр ачааллын болон багтаамжийн гүйдлийн фазын өнцөг, чадлын коэффициентийн янз бүрийн утга дахь хүчдэлийн уналтын утгуудад шугам ба тусгаарлах трансформатор, кВА.км шугамын нэвтрүүлэх чадлаас хамааруулан хүчдлийн уналтыг хурдан хугацаанд тооцон гаргах боломжыг олгохын тулд тусгай номограммуудыг ашиглана. 19,1 кВ-ын урт шугамын хувьд багтаамжийн гүйдлээс хамаарсан хүчдэлийн өсөлт болон алдагдлын хэмжээ нь шугамын хэвийн үр

дүнтэй ажиллагаанд хэт их нөлөө үзүүлэхээргүй байх талаар онцгой анхаарах хэрэгтэй. Ган шугамын дагууд гүйх багтаамжийн гүйдлээс шалтгаалан үүсэх хүчдэлийн өсөлт нь маш бага (хамгийн их. 0,6%) тул тооцохгүй байж болно. Харин тусгаарлах трансформатор болон ган голчтой АС дамжуулагч утас хэрэглэсэн тохиолдолд, эдгээр нь мэдэгдэхүйц хуурмаг шинж чанартай байдаг тул, багтаамжийн гүйдлээс шалтгаалан хүчдэлийн өсөлт бий болно гэдгийг анхаарах хэрэгтэй. Багтаамжийн гүйдлээс үүссэн хүчдэлийн өсөлт нь хүчдэлийн тохируулганд зарим сөрөг нөлөөг үүсгэдэг бөгөөд үүнийг өндөр соронзлолтой трансформатор, эсвэл реактор ашиглан залруулж болно. Багтаамжийн гүйдлийг компенсацилахад зориулагдсан тусгай өндөр соронзлолтой трансформатор, реакторуудыг ашиглана. Бүрэн ачаалалтай нөхцөлд суурин дэд станцын трансформаторын бүрэн эсэргүүцлийн улмаас ердийн хэрэглэгч дээр ойролцоогоор 3,5%-ын хүчдлийн уналт үүсч болно. Хэрэв нам хүчдэлийн шугамын хувьд хүчдэлийн зөвшөөрөгдөх уналтын хэмжээ нь 0,5% бол хэрэглэгч дээрх нийт уналт 4% байх болно. Хүчдэлийн тохируулгын зөвшөөрөгдөх нийт хэмжээ $\pm 6\% - \pm 12\%$. Энэ нь шугамын өндөр талд 8% уналт байхыг зөвшөөрнө. Хэрэв хамгийн ойр орших хүчдэлийн тохируулга хийгдэх тэжээлийн эх үүсвэр ба БГНД шугамын эхлэлийн хоорондох шугамын уналтыг 3%-иар сонгож авсан бол нийт БГНД шугамын хувьд зөвшөөрөгдөх уналтын хэмжээ 5% болно.

Хэрэв энд тусгаарлах трансформатор ашигласан бөгөөд бүрэн ачааллана гэж үзвэл түүн дээр 2% -ын уналт гарна гэж тооцох бөгөөд, тэгвэл БГНД шугамын нийт боломжит хэмжээ нь зөвхөн 3% байх болно. Гэсэн хэдий ч энэ нь, илүү их чадалтай тусгаарлах болон түгээх трансформаторыг суурилуулахад гарах нэмэлт зардал нь илүү их хөндлөн огтлолтой дамжуулагч утас ашигласнаас хямд гэдгийг баталж байна. Илүү чадалтай трансформатор ашиглавал хүчдлийн тохиргоо хийх хязгаар нь багасах боломжтой болно. 10 кВА дэд станцын өртөг нь 5 кВА-гийнхаасаа дөнгөж 108 \$-оор илүү байдаг ба энэ өртөг нь 3/2,75 ган голчтой 77 м утасны үнэтэй дүйж байна. Илүү их чадлын түгээх трансформатор ашиглах нь БГНД шугамын ашиглах боломжит кВА.км үзүүлэлтийг 3%-5% нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж байна. Эдгээр үзүүлэлтийг тодорхойлоход тусгай номограммыг ашиглана. Түгээх трансформатор болон нам талын шугам дээр нийлээд зөвхөн 2%-ын уналт үүснэ гэж үзвэл БГНД шугам дээрх хүчдэлийн уналтыг 5% байхаар тооцон зураг төслөө хийхийг зөвлөж байна.

БГГД шугамын максимум хэрэглээ: БГНД орон нутгийн системийн хувьд тулгуурын орой дахь штырийн өндрөөс хамааруулан тулгуур хоорондын хамгийн их алгасалтыг олох үүрэгтэй хүчдэл тохируулгын тооцоог хийхдээ хамгийн их хэрэгцээг тооцохдоо чадлын коэффициент нь 0.9 утгатай, хоцрох талдаа байна гэж авч үзэх хэрэгтэй. Чадлын коэффициент нь энэ утганаас бага байх хэвийн бус тохиолдлуудад боломжийн үнэтэй конденсаторуудыг цуваа холбон суурилуулж болох ба ингэснээр шугамын үзүүлэлтүүдийг хэвийн утганд нь барина. Санал болгож буй хэрэглээний нягтралын муруйг Зураг 25-д үзүүлэв. Энэхүү муруй нь аливаа тооцоолсон ачаалалд үндэслэнэ. Хэрэв тухайн орон нутгийн нөхцлийн өгөгдлүүдийг тодорхойлж чадвал ачааллын прогнозыг илүү нарийвчлалтай гаргаж болно. Салаалсан шугам болон гол шугам тус бүрийг өөрсдийнх нь үүрэг, ач холбогдлоор нь ялган салгаж үзэх хэрэгтэй.



Зураг

25.

Буцах газардуулгатай нэг дамжуулагч бүхий систем (БГНДС)-ийн хөндийрүүлгийн түвшин. 12,7 кВ-ын газраар буцах хэлхээтэй нэг утаст системийн хөндийрүүлгийн түвшин нь 22 кВ-ын 3 фазын ердийн сүлжээтэй адил бөгөөд, ALP22/445 маягийн штырь изолятор эсвэл 254 мм-ын хоёр ширхэг тавган (гирлянд) изолятор хэрэглэнэ.

19,1 кВ-ын газраар буцах хэлхээтэй нэг утаст системийн хөндийрүүлгийн түвшин нь 33 кВ-ын 3 фазын ердийн сүлжээтэй адил бөгөөд ALP33/534 маягийн штырь изолятор эсвэл 254 мм-ын гурван ширхэг тавган (гирлянд) изолятор хэрэглэнэ.

Газраас дээш 9,3 метрийн өндөртэй модон тулгуурын орой дээр бэхлэгдсэн шаазан тусгаарлагчтай нэг дамжуулагчтай шугаманд маш их хэмжээний импульс үүсдэг. Иймээс дэд станц, таслах, залгах төхөөрөмжүүд нь шугамаар чөлөөтэй дамжих хэт хүчдэлд өртөж байдаг тул эмзэг байдаг. Иймээс хэт хүчдэлд өртөмтгий цэгүүдийг онцгой анхаарч хамгаалах хэрэгтэй.

БГНД шугамын модон тулгуур дээр өндөр хүчдэлийн импульс үүсэх магадлалтай тул татлагат бэхлэгээний төмөр утас болон бусад газардсан метал эд ангиудыг 12,7 кВ ба 19,1 кВ –ын хүчдэлтэй тулгуурын хувьд шугамын штырь изоляторын арматураас харгалзан 0,45 м ба 0,68 м-ээс хол зайтай хийнэ. Ингэснээр модон тулгуурын нум унтраах шинж чанарыг хадгална.

Буцах газардуулгатай нэг дамжуулагч бүхий систем (БГНДС)-ийн газардуулах байгууламжид тавигдах шаардлага, аюулгүй ажиллагаа.

Ердийн тохиолдолд өндөр хүчдэлийн системийн хувьд газардуулга нь зөвхөн хамгаалалтын үүргээр хэрэглэгддэг бөгөөд зөвхөн гэмтэл гарсан үед газардлагын хэлхээгээр гүйдэл гүйдэг. Гэхдээ БГНДС системийн хувьд газардуулгын байгууламж нь ачааллын гүйдэл болон аливаа газардлагын гэмтлийн гүйдлийг өөрөөрөө гүйлгэж байдаг. Энэ үүднээс авч үзвэл БГНД шугамын газардуулгын систем нь уламжлалт шугамынхтай харьцуулбал илүү ач холбогдолтой байдаг.

Аюулгүй байдал ба газардуулгын системийн шаардлага:

Аливаа цахилгаан түгээх системийн аюулгүй ажиллагааг хангах, аваарийн нөхцөлд хамгаалах хэрэгслүүд нь найдвартай ажилладаг байхын тулд газардуулгын хэлхээний эсэргүүцлийг бага хэмжээнд барих шаардлагатай байдаг.

Иймээс тодорхой хязгаарын дотор ачааллын гүйдэл газраар гүйснээс эсэргүүцэл ихсэх болон ингэснээр орчны хөрсийг халаах үйлчлэл үзүүлэх зэрэг сөрөг нөлөө байдаггүйгээрээ БГНД систем нь ердийн системийг бодвол хүндрэл бага юм. Орчны нөхцөл нь туйлын хүнд байхаас бусад тохиолдолд, түгээх дэд станц дээрх газардуулгыг зөвшөөрөгдөх утгын хамгийн их хэмжээнд хийх нь тийм хэцүү биш бөгөөд харин тусгаарлах дэд станц дээр газардуулга хийх өртөг нь өндөртэй байдаг.

1962 оны Агаарын Шугамын Байгууламж ба Ашиглалтын Дүрмийн 19(4) -д "Түгээх сүлжээний БГНД систем зэрэг газардлагын хэлхээгээрээ цахилгаан гүйдлийг байнга дамжуулж байх тусгай зориулалттай системийн хувьд газардлагын системийн бүрдүүлэгч хэсгүүд болох газардуулгын дамжуулагч, электрод, хавчаар зэрэг нь газрын потенциалтай байнга харилцаж, аливаа цаг агаар, байгалийн улирлын бүхий л нөхцөл дор байнга оршдог тул эдгээр нөхцлийг харгалзан үзэж зураг төсөл нь хийгдсэн, суурилуулагдсан байх ёстой" гэжээ. Дүрмийн 36(2) -д "Дүрмийн 19(4) -д заасан Түгээх сүлжээний БГНД систем зэрэг газардлагын хэлхээгээрээ цахилгаан гүйдлийг байнга дамжуулж байх тусгай зориулалттай системийн хувьд, газардлагын системийн бүрдүүлэгч хэсгүүд болох газардуулгын дамжуулагч, электрод, хавчаар зэрэг нь газрын потенциалтай байнга харилцаж, аливаа цаг агаар, байгалийн улирлын бүхий л нөхцөл дор байнга оршдог тул механик болон цахилгаан талаас нь засвар, үйлчилгээг хийж ашиглах ёстой" гэж шаардсан байдаг.

БГГД шугамын нэн тэргүүний бас нэг шаардлага нь хүн, мал, амьтны аюулгүй байдлыг хамгаалахад чиглэгдсэн байдаг.

Мал сүргийн тайван байдлыг алдагдуулан, нөлөөлж эхлэх хүчдлийн тархалтын хэмжээг дор үзүүлэв:

Үнээ – 1 метр дутамд 45 В

Эр ухэр- 1 метр дутамд 13 В

Хонь- 1 метр дутамд 25 В

Энд дурьдсан болон бусад нотолгооноос харахад ерөнхийдөө 40 В-оос хэтэрсэн хүчдэлийн уналтыг эрсдэлтэй гэж үзнэ. Иймээс БГНД системийн бүх дэд станцуудын хувьд хэвийн ажлын нөхцөлд газардлагын үзүүр дээрх зөвшөөрөгдөх хамгийн их хүчдэл 20В-оос хэтрэх ёсгүй (өөрөөр хэлбэл, дээр дурьдсанаар аюултай хэмжээ нь 40В байхад аюулгүй ажиллагааны коэффициент "2"-той тэнцүү байна).

Ийм хязгаартай байхад амь насанд аюулгүй гэж үзэж болно. Хамгийн муу нөхцлөөр тооцон үзэж энэхүү хязгаарлалтын хэмжээг эсэргүүцэл рүү шилжүүлэн үзвэл, хамгийн их газардуулгын эсэргүүцэл нь дараахи утгатай тэнцүү байна:

Түгээх дэд станц

5 кВА 30 Ом (газардуулгын дүрмийн дагуу тавигдах хязгаар)

10кВА 25 Ом

Тусгаарлах дэд станц

20 кВА 5 Ом

50 кВА 5 Ом

100 кВА 30м

Газардуулгын эсэргүүцлээс үүссэн хүчдэлийг тохируулах

Хэрэв дээр тодорхойлсон хамгийн их газардлагын эсэргүүцлийг тооцон авч үзвэл, газрын контактын эсэргүүцлээс үүсэх хүчдэлийн уналтын нөлөөг тооцохгүй байж болно. 20В гэдэг нь 12,7 кВ системийн хувьд, хүчдлийг тохируулахын тулд хүчдлийг дөнгөж 0.16% өсгөх шаардлагатай юм. Эндээс харахад газардуулгын контактын эсэргүүцлийн тухай ярих тохиолдолд гол шалгуур нь хүчдэлийн уналтаас илүү аюулгүй байдал юм.

Газардуулгын системийн ачаалал даах чадвар:

Газардуулгын системээр ачааллын гүйдэл гүйж байхад эсэргүүцэл дээр алдагдал үүсч, үүний улмаас газардуулгын электродуудын ойролцоохи хөрсийг халааснаас үүдэн чийг нь ууршиж байдаг.

Тусгаарлах ба түгээх трансформатруудын хувьд ачааллын алдагдлын коэффициент нь харгалзан 0,25 ба 0,1 байдгийг тооцвол, дээр тодорхойлсон хамгийн их газрын эсэргүүцэлтэй газардуулгын систем дэхь өдөр тутмын эрчим хүчний алдагдал дараахи байдалтай байна:

Түгээх дэд станц (12,7 кВ)	5 кВА	11,2 Вт.цаг
	10 кВА	37,2 Вт.цаг
Тусгаарлах дэд станц (12,7 кВ)	25 кВА	116 Вт.цаг
	50 кВА	465 Вт.цаг
	100 кВА	1120 Вт.цаг

Х.Г. Тэйлор шаварлаг хөрсөнд булсан электродууд кв.м тутамд 3-5 кВт чадлыг байнга сарниаж, харин эсэргүүцлийг бага багаар өсгөж байдгийг олж баталсан байна. /Шаварлаг хөрсөнд илүү их энерги ялгаруулах боломжтой, гэвч сөрөг тал нь ялгарсан энергийн улмаас хөрсний эсэргүүцлийг нэмэгдүүлдэг байна/

1,6 м урт, од хэлбэрээр байрласан 3 ширхэг электродоос тогтох газардуулгын системийн хувьд, газартай харьцах талбай нь ойролцоогоор 0,7 кв.м байдаг бөгөөд үүний улмаас 2,1 – 3,5 кВт буюу өдөрт 50 – 84 кВт.цаг энергийг байнга ялгаруулах боломжтой бөгөөд хөрсний эсэргүүцлийг мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдүүлдэггүй байна.

Эндээс харахад, практик дээр ачааллын гүйдэл гүйсний улмаас эрчим хүч ялгардаг бөгөөд ачааллын гүйдлийн нөлөөгөөр хатах процесс явагдаж газардуулгын эсэргүүцэл нэмэгддэг гэдэг нь магадлал багатай юм. Бүх төрлийн практик туршилт үүнийг нотолдог бөгөөд БГНД түгээх дэд станцын хувьд газардуулгын системээр гүйх ачааллын гүйдэл нь ямар нэг асуудал үүсгэхгүй, хэвийн хэмжээнд байх ёстой.

Тусгаарлах дэд станцууд урт шугам ялангуяа 19,1 кВ-ын урт шугамыг тэжээж байгаа тохиолдолд багтаамжийн гүйдэл нь байнгын үргэлжлэн үйлчилж байх тул орчны газрыг хатааж улмаар ган гачиг, хуурайшил үүсгэж болзошгүй. Гэхдээ 4,8 м урттай электродыг хөрсөнд зоож ашигласнаар, газрын гадаргад нөлөө үзүүлэхгүйгээр энэ асуудлыг нааштайгаар шийдэж болно.

Үндсэн шаардлага бол тулгуурын орчимд нух ухах, газар хагалах гэм мэтээр үйлдлээр тулгуурт бэхэлсэн газардуулгын дамжуулагчийг гэмтээж системийн ажиллагаанд механик гэмтэл учруулахаас зайлсхийх явдал юм. Хатуу мод, нийлэг хавтан, эсвэл цайрдсан труба зэргээр гадуур нь механик хамгаалалт хийн 2 тусдаа

дамжуулагчаар тулгуурыг газардуулгатай дамжуулан холбох, газардуулгын гурван электродыг одоор холбосноор шаардлага хангах хэмжээнд энэ асуудлыг шийдэж болно.

"Гурвалжин" маягийн байршуулалтыг хийхдээ, 1 электродыг тулгуураас 0,3 м зайд (гэхдээ булсан шорооноос биш), нөгөө электродыг тулгуурын эсрэг талд тулгуураас 3 м зайтай, 3-р электродыг эдгээр газардуулгын электродуудыг газардуулгын утсаар холбоход тэнцүү талт гурвалжин үүсгэж байхаар тус тус байрлуулна. Энэхүү байршил нь цуваа хэлхээний хэлбэртэй газардуулгын системийг бий болгож байгаа бөгөөд 1 эсвэл 2 тэр ч байтугай 3 газардуулгын электрод гэмтсэн тохиолдолд ч хувьсах гүйдэл гүйх зам хадгалагдан үлдэнэ.

Их эсэргүүцэлтэй хөрсний хувьд, газардуулгын эсэргүүцлийн шаардлагатай утга гаргаж авахын тулд нэмэлт электрод байрлуулах шаардлагатай байж болно.

Газардуулгын дамжуулагчийн булагдсан хэсэг нь наад зах нь газрын гадаргаас доош 0,45 м байх ба электродуудын холбоосыг чигжиж булахаас өмнө битумын төрлийн бодисоор хангалттай хэмжээнд бүрж өгсөн байна.

Электрод зэврэх

Цайрдсан электрод нь хүчил ихтэй хөрсөнд зэвэрч магадгүй бөгөөд шүлтлэг хөрсөнд өндөр эсэргүүцэлтэй болж болзошгүй. Саяхан хийсэн туршилтаас харахад, өндөр эсэргүүцэл үзүүлж байсан давслаг давхарга нь 250 В хүчдэл өгөхөд хагарч, үгүй болж байсан байна. Яг ийм адил электродуудтай системийн хэмжүүрийн багажаар хэмжиж гаргасан газардлагын эсэргүүцэл нь хөрсний хувийн эсэргүүцлийг хэмжээнд тооцон гаргасан газрын эсэргүүцлээс 10 дахин эсвэл түүнээс ч илүү их байж болно.

Гэсэн хэдий ч 240В-ын хүчдэл өгөхөд тооцоолсон эсэргүүцэлд харгалзах гүйдэл гүйж байсан болно. Газардлагын гэмтлийг зориудаар үүсгэн 240 В-ын хүчдэлийг электрод руу өгсний дараа нь шууд газардлагын эсэргүүцлийг тестерээр хэмжихэд гарсан үр дүн нь тооцоолсон утгуудтай тохирч байсан байна.

Цайрдсан электродуудтай гадаад хэлхээг холбоход зэс дамжуулагч утас хэрэглэж байгаа бол цайрдсан электродтой электролитийн зэврэлтэнд орохоос хамгаалах үүднээс бүрээстэй дамжуулагч ашиглах нь зүйтэй юм. Зэвэрдэггүй ган, зэс болон зэсээр бүрсэн ган электродууд нь байгалийн зэврэлтэнд өртдөггүй болох нь тогтоогдсон.

Газрын эсэргүүцэл улирлаас хамааран өөрчлөгдөх нь

Газрын эсэргүүцлийн утга улирлаас хамааран өөрчлөгдөж буйг ялангуяа зуны саруудад хянаж байх хэрэгтэй. Хэрэв газардуулгын системийг өвөл угсарсан бол зөвшөөрөгдөх эсэргүүцэл нь өмнө өгүүлсэн хамгийн их утгуудаас бага зэрэг доогуур байх ёстой. Хэдийгээр хөрсний эсэргүүцэл нь боломжийн цөөн тооны электрод хангалттай байгаа хэдий ч урьдчилан сэргийлэх арга хэмжээ болгож газардуулгын системийг 1,6 м урттай 3-аас доошгүй электродтой байхаар хийх ёстой.

Өндөр ба нам хүчдэлийн газардуулгын системүүдийг тусгаарлах

Эрх бүхий байгууллагаас гаргасан "Газардуулгын хамгаалалтыг хэрэгжүүлэх Дүрэм"-д нам болон өндөр хүчдэлийн газардуулгын хосолсон системийн газрын эсэргүүцэл 1,0 Ом-оос багагүй байх эсвэл бусад заасан нөхцөл хангагдаж буй тохиолдолд нам болон өндөр хүчдэлийн газардуулгын системийг нэгтгэн холбож болно гэж тодорхойлжээ.

Гэсэн хэдий ч БГНД системийн хувьд нам хүчдэлийн газардуулгын системийг өндөр хүчдэлийн гүйдэл дамжуулах газардлагын системтэй ямар ч нөхцөлд холбохгүй байхыг зөвлөж байгаа бөгөөд өндөр хүчдэлийн системийн үүсгэсэн газраар тархсан градиент хүчдэл нь нам хүчдэлийн системтэй холилдож давхцан улмаар хэрэглэгчийн байгууламжуудад дамжихаас сэргийлэхийн тулд хооронд нь тусгаарлан холдуулах хэрэгтэй.

Энэхүү тусгаарлалтыг дараах байдлаар хийж болно. Үүнд:

(а) нам хүчдэлийн нейтралийг дэд станцаас алгасалтын тулгуур хоорондын зайнд хийх, эсвэл

(б) дээрх газардуулгын системийг хоёуланг нь дэд станцын тулгуур дээр байрлуулах, гэхдээ 2 системийн хооронд наад зах нь 3 м зай үүсгэхийн тулд хоёр системийн газар доорхи газардуулгын утсанд тусгаарлалтай утас хэрэглэх.

Ердийн тохиолдолд БГНД систем нь хэрэглэгч бүрийг тус тусад нь дэд станцаас тэжээдэг тул нам хүчдэлийн түгээх шугам нь дэд станцын тулгуураас шууд авдаг. Энэ тохиолдолд (б) арга илүү тохиромжтой. Учир нь хэрэглэгчийн гэрийн ойр өөрийнх нь мэдлийн газарт суурилуулна. Хэрэглэгчийн электродод халдашгүй байдал хангагдана. Газардуулгын үзүүрүүдийг тусгаарлах арга болон газардуулгын системийг дэлгэрэнгүйгээр байдлаар зураг төсөлд нь тусгах хэрэгтэй.

Газардуулгын систем ба газардуулгын дамжуулагчууд

Газардуулгын ерөнхий асуудлуудыг эрх бүхий байгууллагын гаргасан "Газардуулгын хамгаалалтыг хэрэгжүүлэх Дүрэм"-д тусгасан байдаг.

Техникийн ажиллагсад болон бусад оршин суугч хүмүүсийг хамгаалахын тулд, полихлорвинил (PVC) сайжруулсан тусгаарлалтай, 250 В-ын хүчдэлийн, 7/2.00 хөндлөн огтлолтой хос зэс дамжуулагчийг өндөр хүчдэлийн газардуулгын дамжуулагчид ашиглах ба газрын түвшнээс 2,4 м хүртэл өндөрт цайрдсан төмөр труба, эсвэл 75 x 75 мм хатуу цул модон хавтан, эсвэл нийлэг эдлэл хавтангаар хийгдсэн механик хамгаалалттай байна.

Өндөр хүчдэлийн газардуулгын систем нь газар хагалах үед гэмтэх гэх мэт эрсдлийг бууруулахын тулд газар дор 0,45 метрийн гүнд байрлуулах ингэснээр газрын гадарга дээрх хүчдэлийн тархалтыг бууруулдаг сайн талтай. Энэ төрлийн байгууламж дээрх өндөр хүчдэлийн газардуулгын системийн хэлхээ задгай байх, эсвэл эсэргүүцэл нь их байвал хүн, малын аль алинд нь ноцтой аюул учруулж болох бөгөөд үүнээс үндэслэн ийм газардуулгын системд гэмтэл гаргахгүй байх талаар алхам бүрдээ маш болгоомжтой хандах хэрэгтэй.

Буцах газардуулгатай нэг дамжуулагч бүхий систем (БГНДС)-ийн аянгийн болон хэт хүчдэлийн хамгаалалт.

Аянгийн хамгаалалт. Зарим эсрэг үзэл баримтлалыг үл тооцож үзвэл БГНД-ийн трансформаторыг аянгийн хамгаалалтгүй суурилуулна гэдэг нь дэндүү гэнэн хэрэг. Хамгаалалтгүй БГНД-ийн трансформаторт учруулах аянгийн аюул үнэхээр их.

Очин завсар. Энэ нь хамгаалалтын хамгийн хямд, энгийн хялбар хэлбэр боловч дутагдалтай тал нь байнгын тасралт гаргахаас зайлсхийхийн тулд автомат давтан залгагчтай таслуурыг нэмж суурилуулах шаардлагатай байдаг явдал юм. Гэсэн хэдий ч үүнийг хэрэглэгчийн нягтшил км тутамд 0,3-аас багагүй, засвар үйлчилгээ хийхээр очиход хүндрэл багатай бол мэлхий болон бусад амьтад бэрхшээл үүсгэхээс сэргийлсэн зохих арга хэмжээ авагдсан нөхцөлд БГНД-ын дэд станцад

аянгын хамгаалалтын үүргээр очин завсрыг хэрэглэхийг санал болгож байна. Очин завсрыг трансформаторын оруулга, гал хамгаалагч, шугамын изолятор, тохиромжтой байрлалд суурилагдсан өөр бусад изолятор зэргийн алин дээр ч суулгаж болно. Очин завсрыг байрлуулахдаа мэдээж БГНД системийн гал хамгаалагчтай зохицуулан холбох шаардлагатай. Трансформатор болон гал хамгаалагчийн суурийг аянганаас хамгаалахын тулд хайлдаг гал хамгаалагч бүхий аянга зайлуулагч хэрэглэх нь зүйтэй.

БГНД системийн очин завсрын тодорхойлолт. Суурилуулах: Цуваа 2 завсрыг ашигла. Оруулга эсвэл таслуурын изолятор дээр суурилуулаагүй бол 22 кВ-ын ганц изолятортай хайлдаг гал хамгаалагч дээр суулгах. 22 кВ-ын хайлдаг гал хамгаалагчийг 12,7 кВ болон 19,1 кВ аль ч системийн хүчдэлд хэрэглэх боломжтой.

Завсрын урт: 12,7 кВ-ын хувьд завсар 25 мм, 19,1 кВ-д 38 мм байх ёстой.

Электрод: Электрод нь бөөрөнхий гууль байх бөгөөд дор хаяхад 8 мм диаметртэй байна.

Угсралтын дизайн: Оруулга, таслуур, изолятор нь хэвийн ажлын байрлалдаа байх нөхцөлд нь босоо тэнхлэгээс 30° өнцгөөр очин завсрыг байрлуулна. Суурилуулалтын тэнхлэгийн дагуу эдгээр 2 очин завсрыг харахад хоорондоо 90°-ээс 180° өнцөг гарган байрласан байна.

Холболтын үзүүрүүд: 7/2.75 хүртэлх хэмжээтэй утсаар шугам болон газартай холбоход зориулагдсан холболтын үзүүрийг гаргаж өгсөн байх хэрэгтэй.

Яндан цэнэг шавхагч (Хамгаалах хоолой). Энэ маягийн цэнэг шавхагчууд нь ихээхэн давуу талтай ч тодорхой хязгаартай байдаг бөгөөд БГНД-ийн системд хэрэглэхээсээ өмнө эрчим хүчний байгууллага нь үүсэх гүйдлийг 20-200 А-ын хязгаарт байгааг тодорхойлж мэдэх хэрэгтэй.

Энэ гүйдэл нь цэнэг шавхагч дотор хангалттай хий үүсгэн улмаар үүссэн нумыг унтраахад шаардлагатай байдаг. 20 А-аас бага гүйдэлд энэ маягийн цэнэг шавхагч нь найдвартай ажиллаж чадахгүй байж болно.

Вентилэн цэнэг шавхагч. 22 кВ ба 33 кВ-ын ердийн газардуулагдсан системд хэрэглэгддэг цэнэг шавхагчыг харгалзан 12,7 кВ ба 19,1 кВ-ын системд хэрэглэхэд тохиромжтой. Тусгаарлах дэд станцын орж байгаа ба гарч байгаа бүх шугам дээр вентилэн цэнэг шавхагч тавих нь зүйтэй юм. Тархай бутархай суурьшилттай газар дуудлагаар алс газарт үйлчилгээ хийхээр явахад гарах зардлын хэмнэлтийг эс тооцвол, өртөг ихтэй тул түгээх дэд станцид ийм цэнэг шавхагч хэрэглэгддэггүй.

Ерөнхий зүйл. Ямар төлийн цэнэг шавхагч хэрэглэх нь чухал биш харин энэ төхөөрөмжийг трансформаторын баканд аль болох шууд холбох нь чухал юм. Аянгын хэт хүчдэлийн давтамжаас шалтгаалан, цэнэг шавхагчыг өөр утсаар эсвэл урт үзүүрээр дамжуулан газартай холбосноор хуурмаг эсэргүүцлийг ихэсгэх тул үйлчлэх үр дүн багатай байдаг.

Хэт ачааллын хамгаалалт. Давтан залгах онцлог бүхий хөдөө нутагт зориулсан таслуур. АНУ-д үйлдвэрлэсэн 22 кВ-ын нэг туйлт давтан залгагчтай таслуурын үнэ нь ойролцоогоор 1200 \$ болдог. Энэ нь 12,7 кВ ба 19,1 кВ БГНД сүлжээний алинд нь ч маш тохиромжтой бөгөөд боломжийн зардлаар сайн хамгаалалт хийх боломж олгодог. Хэт хүчдлийн хамгаалалтын үүргээр очин завсар хэрэглэж байгаа тохиолдолд, давтан залгагчыг хэрэглэснээр хэмнэлт гаргах бөгөөд хэрэв хүсвэл дэд станц дээрхи гал хамгаалагчыг хэрэглэхгүй байж болно. Үүнийг хэдийгээр дагаж мөрдөхийг зөвлөөгүй боловч, гал хамгаалагчыг хэмнэж давтан залгагч

тавьснаар гарах зардлыг багасгах бөгөөд гадагшаа тургиж ажилладаг гал хамгаалагчаас татгалзсанаар хээрийн түймрээс сэргийлэх сайн талтай юм.

Газраар буцах хэлхээнд (фаз-газрын хооронд) холбогдсон ачааллын хэмжээ нь 2 фазын хооронд холбогдсон ачааллаас үлэмж их байгаа нөхцөлд, 2х19,1 кВ-ын хосолсон системийн хувьд таслуурын нээлттэй контакт дээр зөвхөн 19,1 кВ үйлчлэх тул 22 кВ-ын давтан залгагчыг утас бүр дээр (фаз тус бүр дээр бүр дээр) хэрэглэж болно. Энэ тохиолдолд 2 таслуурыг хоорондоо хамааралтайгаар цуг ажиллуулах шаардлагагүй бөгөөд ингэснээр нэг шугам нь гэмтсэн тохиолдолд нөгөө талын тэжээл нь өгөгдөж байх боломжтой юм.

Эдгээр давтан залгагчын тусгаарлага нь 19,1 кВ-ын системийн дотоод шаардлаганд нийцэхээр байгаа боловч гаднаас ирэх импульсийн өндөр хүчдлийг даахгүй. Учир нь 33 кВ-ын системийн хувьд 220 кВ-ын хэмжээтэй импульсийн хүчдэлийг даах шаардлагатай байдаг. Шаардлага хангахуйц үзүүлэлт бүхий цэнэг шавхагчыг нэмж хэрэглэснээр энэ дутагдлыг арилгаж болно. Ийм таслуурыг 19,1 кВ-ын системд ашиглахаар захиалахдаа бие биедээ нийцэн ажиллах боломжтой байхын тулд цэнэг шавхагч ба давтан залгагчыг нэг газраас худалдаж авах хэрэгтэй.

Ямар ч хэмжээтэй БГНД системийг суурилуулж буй Эрчим хүчний байгууллагад зөвлөж хэлэхэд, БГНД шугамыг хамгаалах үүрэгтэй давтан залгагчыг тусгаарлах дэд станц дээр байрлуулах нь зүйтэй юм.

Хайламтгай гал хамгаалагч. Үүнийг ерөнхийдөө хөдөөгийн дэд станцуудад хэрэглэдэг. Гэхдээ хээрийн түймэр гардаг газар оч хаядаггүй гал хамгаалагч тавих хэрэгтэй.

Давтан үйлчлэх гал хамгаалагч. Эдгээр нь 2-3 удаа давтан ажиллах хийцтэй байдаг. Энэ төрлийн гал хамгаалагчийн дутагдал нь давтагч гал хамгаалагч болон дараагийн гал хамгаалагчийн мэдрэх хүрээ бөгөөд дараагийн гал хамгаалагчийн тавил нь эхнийхээсээ ихээхэн илүү байх ёстой. Энэ нь нөөц гал хамгаалагчаар эхний ажиллагааны үеийн гэмтлийн гүйдэл нэвтрэн өнгөрч халснаас таслах чадвар нь өөрчлөгддөгөөс шалтгаална.

Хавчуур маягийн гал хамгаалагч. Энэ нь хөндийрүүлэгдсэн хоолойн дотор хайламтгай тавил байрласан хийцтэй бөгөөд шууд шугаман дээр бэхлэгддэг. Гэмтэл гармагц гал хамгаалагч хайлж, трансформаторын оруулгыг хүчдэлээс чөлөөлж өгдөг. Энэ төрлийн гал хамгаалагчийг ганц утастай системд тусгайлан хийсэн бөгөөд үнэ нь уламжлалт хайламтгай гал хамгаалагчийн үнийн ¼% -тай тэнцдэг. Зарим тохиолдолд доргионы улмаас гэмтэх, хэвийн ажиллагаа нь доголдох үзэгдэл гардаг нь дутагдалтай тал нь юм. Бүх төрлийн хайламтгай тургих гал хамгаалагчид тавигддаг шаардлагын адилаар, хээрийн түймрийн аюултай газарт оч үүсгэдэггүй гал хамгаалагчыг хэрэглэх хэрэгтэй.

Гал хамгаалагчыг аянга зайлуулагчтай хослуулан хэрэглэх. Практикаас харахад 5А-аас бага хэвийн гүйдэлтэй гал хамгаалагч нь аянга цахилгааны үед амархан шатдаг, эмзэг байдаг байна. Өндөр хүчдэлийн гал хамгаалагчыг дэд станцын хөндийрүүлгийн гэмтлийн хамгаалалт болгон хэрэглэж болох юм. Хэт ачааллын хамгаалалтыг нам хүчдэлийн хамгаалалтаар гүйцэтгэх нь зүйтэй юм. Иймээс тухайн системд гарсан гэмтлийг мэдэрч чадахаар бол трансформаторын чадал бага байхаас үл хамааран 5А-аас багагүй хэвийн гүйдэлтэй гал хамгаалагчыг хэрэглэх нь зүйтэй юм. Ийм практик арга хэмжээ авснаар аянгын улмаас гал хамгаалагч шатах үзэгдлийг ихээхэн хэмжээгээр бууруулна. Тухайн

системд гарсан гэмтлийг мэдрэн ажиллаж чадаж байгаа нөхцөлд зарим Эрчим хүчний байгууллага нь 8А-ын гал хамгаалагчыг хэрэглэж байна.

Хамгаалалтын системийн хийц, бүтэц. Түгээх системд тусгаарлагч дэд станц оруулан ашигласан тохиолдолд, дараахи хүчин зүйлсийн улмаас шаардлаганд нийцэхүйц, найдвартай хамгаалалтын системийн зураг төсөл, дизайныг хийхэд хүндрэлтэй байдаг:

(а) гэмтэл гарах үеийн гүйдлийн хэмжээ бага;

(б) хэт нүсэр хамгаалалтын схем дээр нэмж хамгаалалтын хэрэгсэл, тоног төхөөрөмжийг суурилуулах шаардлагатай тул схемийг улам нарийн төвөгтэй, нийлмэл болгодог.

Эндээс харахад БГНД системд гал хамгаалагч ба хэт хүчдэлийн хамгаалалтыг хамтруулан хэрэглэхдээ авч үзэж буй бүх хүчин зүйлсүүдийн харилцан хамаарлыг олж, дунджаар нь зохицуулах хэрэгтэй юм. Асуудлыг шийдэх хамгийн сайн арга бол энэхүү системийн янз бүрийн хэсгүүд дээр газардлагын гүйдлийг тооцох явдал юм. Үүний дараа тавигдаж буй шаардлагуудыг хангаж байгаа эсэх болон ялгаатай талуудыг шалган нягталж үзэх хэрэгтэй.

2.2 Багийн төв, жижиг суурих хэрэглэгчдийг БГНДС-ээр хангах туршилт судалгааны ажлын үндсэн объектийг сонгож авах

Багийн төв, жижиг суурин хэрэглэгчд / багийн төв, аялал жуулчлалын бааз, фермер, хилийн цэргийн застав, газар тариалангийн төвлөрсөн газрууд, үнээ ферм, сүү- тосны цех г.м /- ийг БГНДС-ээр хангахад байгаль цаг уурын онцлогоос хамааруулан хөрсний эсэргүүцлийн судалгааг улс орны хангай хээр, говийн бүсийг төлөөлүүлэн хийж хөрсний бүтэц, эсэргүүцлийн нэгдсэн дундаж үзүүлэлтүүдийг тодорхойлох явдал ихээхэн чухал юм.

Энэ зорилгоор энэхүү судалгааны явцад Хангайн бүсийг төлөөлүүлэн Хөвсгөл аймгийн Жаргалан сумын “Цэцүүх” баг, Хээрийн бүсийг төлөөлүүлэн Баян-Өлгий аймгийн Баян-нуур “Цэцэг” баг, Говийн бүсийг төлөөлүүлэн Увс аймгийн Тэс сумын “Таван Улиас” багийн төвүүдийг дараахи үндсэн шаардлагуудыг харгалзан судалгааны үндсэн объектоор сонгон авсан болно. Үүнд:

1. Багийн төв нь хөрсний бүтэцийн хувьд хангай, говь, хээрийн бүсийн аль нэгийг хамарсан байх ангилалд багтах боломжтой байх
2. Багийн төв нь аль болохоор төвлөрсөн тодорхой хэмжээний сууршилтай, эрчим хүчний байнгын хэрэглээтэй байх
3. Багийн төв нь сумын төв болон эрчим хүчний ямар нэгэн эх үүсгэвэрээс 50 км-ээс холгүй зайд байрласан байх
4. Багийн төв нь тухайн бүс нутгийн жишиг багийн төвийг төлөөлөх чадвартай байх
5. Багийн төв нь цаашдаа өргөжин хөнжих улмаар эрчим хүчний хэрэглээ нь мэдэгдэхүйц өсөх хандлагатай байх

Эдгээр багийн төвүүд нь хөрсний бүтэц, түүний эсэргүүцлийн үзүүлэлтүүд болон жишиг багийн төвүүдийг төлөөлүүлэн авахад бидний дээрхи шаардлагуудыг хангаж байсан болно. Тухайлбал дээрхи багийн төвүүдэд бага сургууль, цэцэрлэг, гэр хороолол, мал эмнэлэг, ахуй соёл үйлчилгээний газар, худаг, дэлгүүр-мухлаг, багийн төвийн контор, улаан булан г.м эрчим хүчний байнгын эх үүсгүүрдтэй юм. Мөн эдгээр багийн төвүүдийн байршлыг сонгон авахдаа “Монгол орны цахилгаан эрчим хүчээр хангах баг, ферм, жижиг суурингийн судалгаа” гэсэн МУИС-ийн дэргэдэх “Бүртгэл эрдэм” нийгэмлэгийн судалгааны ажлын тайлангийн дараахи үндсэн үр дүнг ашигласан болно.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Бүс нутгийн хөгжлийн хөтөлбөрүүд, Засаг захиргааны анхан шатны нэгж “Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”, Аж үйлдвэрийг сэргээх бодлого, “Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөр, Аж үйлдвэрийг сэргээх бодлого, Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр, Рашаан сувилалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, Монгол Улсын эрчим хүчний тогтвортой хөгжлийн стратеги төлөвлөгөө, “Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем” зэрэг бодлогын болон хөтөлбөрүүдээс үзэхэд улс орныг цаашид улам гүнзгийрүүлэн цахилгаанжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь ёсны асуудал болж байна.

Судалгааны ажлын үндэслэл :

1) Монгол Улсын хүн ам харьцангуй цөөн, нутаг дэвсгэртээ таруу байршилтай амьдардаг, төвөөс алслагдсан сум, суурин газар ихтэй, хөдөөгийн малчид нүүдлийн мал аж ахуй голчлон эрхэлдэг тул төв, суурин газраас алслагдсан байдаг нь тэдгээрийг цахилгаан эрчим хүчний эх үүсвэрээр хангахад бэрхшээл үүсгэдэг.

2) Хөдөөгийн хэрэглэгчдийг найдвартай цахилгаан эрчим хүчний эх үүсвэрээр хангах, тэдэнд ажил эрхлэлт, нийгмийн асуудлыг шийдвэрлэх асуудал нь жижиг суурин, баг, ферм, жуулчны бааз, жижиг үйлдвэрлэгчид, хилийн цэргийн пост болон тариалангийн усалгаат системийн цахилгааны эх үүсвэрийг авч үзэх шаардлага тавигдаж байгаа юм.

3) Энэ бүхнийг шийдвэрлэхэд тухайн орчин, нөхцөлд тохирсон өртөг зардал багатай эрчим хүчний эх үүсвэрээр хангах боломж, нөхцлийг судлах зайлшгүй асуудал урган гарч байна.

Судалгааны багийн хамт олноос дээрх удирдлагын баримт бичгийг удирдлага болгож баг, жижиг суурин, ферм, усалгаат систем болон бусад жижиг объектуудыг цахилгаанаар хангах нөөц боломж, давуутай болон дутагдалтай талуудыг илрүүлэн гаргаж тавих, баг суурингийн талаар нэгдсэн судалгааг улсын хэмжээнд нэгтгэх, байршлын тоймыг тогтоох, баг суурийн газрыг БГНДС-ийг ашиглан цахилгаанжуулах боломжуудыг гаргаж ирэхийг зорилоо. Багуудыг цахилгаанаар хангах ажлын ээлж дарааллыг ач холбогдлын түвшин болон эдийн засгийн тодорхой шалгуур тавьж тогтоох, техник-эдийн засгийн үндэслэлийн анхан шатны өгөгдлийг боловсруулах, баг, ферм, жижиг суурингийн цахилгааны хэрэглээ болон хэтийн таацын тоймыг гаргах, тооцоо, судалгааны үндсэнд тулгуурлан цахилгаан хангамжийн эх үүсвэрийн талаар санал дэвшүүлэх явдал байлаа.

Судалгааны ажлыг 2 үе шаттай явуулсан бөгөөд эхний үе шатанд тойм судалгааг хийх, дараачийн шатанд нь тодорхой зэрэглэсэн объектуудыг цахилгаанаар хангахтай холбогдсон мэдээлэл бий болгох, суурь судалгааны асуудлыг авч үзэв. Эрчим хүчний эх үүсвэр/ сэргээгдэх эрчим хүч, ДЦС, эрчим хүчний төвлөрсөн эх үүсгэвэр г.м / , зарим дэвшилтэт техник-технологийн судалгаанд үндэслэн хөрөнгө оруулалтын үр ашгийн шинжилгээний үр дүнгүүдэд харцуулалт хийв.

Багийн судалгааг хийхдээ загвар-маягт боловсруулан зарим сумын Засаг дарга нарт хүргүүлэн тэдгээрээс уг мэдээллийг гаргуулан авч нэгтгэн байршлын тоймыг 1:500 000 зурагт оруулсан судалгааны үр дүнг ашиглав.

Баг, суурингийн зургийг аймаг тус бүрээр гаргаж, холбогдох мэдээлэл, судалгааг баг бүрээр хийсэн судалгааны ажлын тайланг судалгааны ажлын үндсэн объектийг сонгож авахад ашигласан болно. Судалгааны ажилд хамарсан багийн нутаг дэвсгэрт орших бусад объектуудыг мөн дээрх зурагт оруулав.

Судалгааны объект сонгож авах ажилд дараах арга зүйг ашиглав. Үүнд:

- 1) Засаг захиргааны анхан шатны нэгж болох багийн судалгааг гаргахдаа энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн захиргааны төв байгууллагын мэдээллийг иш үндэс болгосны дээр тодотгох багийг сумын Засаг дарга нартай утсаар ярьж тодруулга авсан болно. Багийн байршил, цахилгаан хангамжийн схемийг 1:500 000 хэмжээний зурагт AutoCAD компьютерийн программ ашиглаж

гүйцэтгэв. Зарим нэг онцгой анхаарах объектын тодруулгад хайлтын сансарын системийг ашиглав.

2) Тухай аймгийн багийн онцлог нөхцөл байдалд SWOT шинжилгээний аргын зарчимыг хэрэглэв. Энэ арга нь тухайн багийн аюул занал, боломжийг дотоод давуу болон сул талтай уялдуулан зохицуулахад чиглэгдсэн сиситемтэй үнэлгээ өгөх арга юм.

3) Багийн төрийн үйлчилгээ явуулах ажлын байр ба багийн айлуудын цахилгааны хэрэглээг тооцоходоо тэдгээрийн ашиглах цахилгаан тоног төхөөрөмжийн хүчин чадалд үндэслэсэн болно. Хэрэглээний хэтийн хөгжлийн тооцоог Монта-Карлогийн туршилт шинжилгээний аргаар хийв. Эх үүсвэрийн хүчин чадлын нарийвчлалыг “HOMER” программ хангамжийн тусламжтайгаар тодотгов.

4) Техник-эдийн засгийн үндэслэлийн анхан шатны мэдээлэл, өгөгдөлийг цуглуулахад багуудын байршлын уртраг, өргөргийг тогтоох замаар RETScreen программ хангамж ашиглан тодорхойллоо.

5) Багийн байршлын хүрээнд нар, салхины нөөцийн бүсчилсэн тойм өгөгдлийг гаргав / нар, салхины кадастрийн зураг ашиглав/.

6) Багийг цахилгаанаар хангах боломж, нөхцөл болон өнөө үед туршигдан улс орнуудад нийтлэг байдлаар ашиглаж байгаа цахилгааны эх үүсвэрийн сонголт хувилбарыг санал болгож, төслийн хөрөнгө оруулалтын арга зүйгээр үр ашгийн тооцоог гүйцэтгэсэн болно.

Судалгааны хүрээ:

Монгол Улсын 21 аймгийн 1544 баг, аялал жуулчлалын бааз, хилийн цэргийн застав, фермер зэргийг хамруулах арга хэмжээ авч, судалгааг хийв. Зураг-2.

Эхний ээлжинд баруун таван аймгийн багуудын судалгаа хийв. Багуудын нутаг дэвсгэрт байгаа мал аж ахуйн фермер, тариалангийн зарим усалгаат систем, рашаан сувиллын газрууд болон хилийн цэргийн цахилгааны эх үүсвэр шаардлагатай байгаа газрууд судалгаанд хамрагдав.

Судалгааны үйл явц:

Судалгааг холбогдох мэдээлэл цуглуулах, ажлын хүрээ, даалгаврыг тодотгох, баг, фермер, газар тариалангийн усжуулалт, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр төр, засгаас авч явуулж байгаа бодлого, хөтөлбөр, ХХХААҮЯ, БХЯ, БОЯЖЯ, ЭБЭХЯ-ны холбогдох албан тушаалтан, мэргэжилтнүүдийн санал,

бодолтой танилцах, уулзалт зохиох зэргээр эхэлсэн болно. Зөвлөхүүд нь орон нутгаас багийн судалгааны загвар маягтаар мэдээлэл авах ажил ихээхэн цаг хугацаа зарцуулсан байна.

Мэдээллийг 2-3 эх үүсвэрийг тулган үзэж өгөгдлийг боловсруулсан бөгөөд орон нутгийн цахилгаан хангамж, шугам, сүлжээ, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр зэргийг Эрчим хүчний судалгаа хөгжлийн төв, СЭХҮТ, ЭХЗГ, ДҮТ зэрэг байгууллагуудтай харилцаж судалгааг авсан болно. Загвар болон мэдээлжсэн “жишиг” баг байгуулахаар төлөвлөж байгаа Төв аймгийн Баян сумын “Цант”, Баян-Өнжүүл сумын “Цээл” баг, Бүрэн сумын “Өнжүүл” баг, Эрдэнэсант сумын “Сайхан”, Баргилт баг, Эрдэнэ сумын “Чулуут баг, Хөвсгөл аймгийн Жаргалан сумын “Цэцүүх” баг, Түнэл сумын “Навчилдай” баг, Дундговь аймгийн Адаацаг сумын Ар-Урт баг, Эрдэнэ Ухаа жуулчны бааз, Сайнцагаан сумын “Үнээ ферм”, Хэнтий аймгийн Хэрлэн сумын “Тахилгат” баг-суурин газар, Дорноговь аймгийн Алтанширээ сумын “Тойг” багийн байдалтай газар дээр нь танилцаж дээрхи арга зүйн дагуу судалгаа хийсэн болно.

Судалгааны дүнг нэгтгэх, эхний шатны тайланг боловсруулах асуудал нь тайлангийн агуулга, өгөгдлийн боловсруулалтыг захиалагчид танилцуулан зөвлөмж, саналыг тусгаснаар эхэлсэн болно.

Эхний шатны тайланг хамгаалснаар төслийн санхүүжилтийг олгохоор захиагчтай зөвшилцсөн.

Судалгааны ажлын явцад гарсан хүндрэл бэрхшээл

- Ажлын нилээд төвшилттэй хэсэг нь багийн байршлуудыг тогтоох, түүнийг газрын зурагт оруулах, Энэ нь багийн байршлын кадастрийн зураглал улс орны хэмжээнд хийгдээгүй тэй холбоотой байлаа.

- Сумын Засаг даргад хүргүүлсэн судалгааны маягыг бөглөж ирүүлэх асуудал хангалтгүй байв,

- Хувийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэгдэж байгаа объектуудын талаарх мэдээлэл авах боломж хязгаарлагдмал байлаа.

Судалгааны ажлын онцлог:

Судалгааны ажлын онцлог нь улс орны хэмжээнд баг, фермер, тариалангийн усалгаат систем, хилийн цэргийн анги гэх мэт объектуудын цахилгаан хангамжийн судалгааг эхлүүлж байгаад оршино.

Тайлангийн бүтэц

Эхний тайланд тусгасан жишиг загварын дагуу 21 аймгаар багийн байршлын зураг, тайлбар өгөгдлийг гаргасан бөгөөд эхний ээлжинд цахилгаанаар хангах багуудын жагсаалтыг аймаг нэг бүрээр гаргаж, энэ багтай холбогдсон анхан шатны өгөгдлийг боловсруулан зураг, хүснэгтийн хэлбэрээр гүйцэтгэсэн болно. Дээрх судалгааны загвар ажлын дагуу аймаг бүрээр тайланг гаргасан болно.

2.3 Монгол Улсын байгаль цаг уурын онцлог нөхцөл болон хөрсний эсэргүүцлийг тодорхойлох хэмжилт судалгааны ажлын хэсэгчилсэн арга зүй

Буцах газардуулгатай нэг дамжуулагчийн систем нь Канад, Шинэ Зеланд, Австрали, Өмнөд Африк зэрэг улс оронд ачааллын нягт багатай бага чадлыг алслагдсан хэрэглэгчдэд өргөн хүрээтэй хэрэглэгддэг шугамын систем бөгөөд өнөөдрийн байдлаар дэлхийн улс орнуудад Америкийн болон Австралийн гэсэн 2 стандартыг хэрэглэж байна.

Японы ядуурлыг бууруулах сангийн буцалтгүй тусламжаар Азийн Хөгжлийн банкны “Хөдөөгийн орлого багатай хэрэглэгчдийн эрчим хүчний үйлчилгээг сайжруулах туршилтын төсөл” /JFPR 9139/ энэхүү шугамын системийг Канад улсын Манитоба Хайдро интернэйшнл ХК болон дотоодын зөвлөх компани Мон Энержи Консалт ХХК-тай хамтран хэрэгжүүлж эхлээд байгаа бөгөөд Австралийн стандартыг манай орны нөхцөлд илүү тохиромжтой гэж үзэж байна.

Энэхүү стандартыг Австрали улсын Эрчим хүчний газрын боловсруулсан олон дахин газардуулсан систем /ОДГН/ буюу /MEN/ болон энгийн олон дахин газардуулсан систем /ЭОДГН/ буюу /CMEN/ систем, Шинэ Зеланд улсын ECP35 системийн болон стандарт газардуулгын схем STD-E13/1-үүдийг ашиглан энэхүү судалгааны арга зүйг боловсруулсан болно. Цаашид БГНДС-ийн дүрэм зааврыг зохих шаардлагын дагуу нягтлан боловсруулж гаргах нь зүйтэй.

Газардуулгын системийг цахилгаан түгээх системийн нэгэн хэсэг байдлаар хийдэг.

Газардуулгыг дараах зорилгоор хийнэ. Үүнд:

- А. Газардлагын гүйдэл нэвтрэн өнгөрөхөд хүчдэлтэй болж болох газардуулсан металл эд ангиуд дээр үүсэх потенциалыг хамгийн бага байлгах
- Б. Газардлагын гүйдэлд буцах зам үүсгэх болон энэхүү газардлагын гүйдлийг мэдэрч системээс хоромхон зуур таслах боломжийг бүрдүүлэх
- В. БГНД системд газардлага үүсэх үед, газардуулгын систем дээр мэдэгдэхүйц байнгын хүчдэл үүсгэхгүйгээр буцах газардуулгын гүйдлийг найдвартай замаар хангах

Газардуулгын систем нь олон дахин газардуулсан нейтральный (MEN) болон энгийн олон дахин газардуулсан (CMEN) систем юм. MEN системд Өндөр ба Нам хүчдэлийн газардуулгын систем нь тусдаа байдаг. CMEN системийн хувьд Өндөр хүчдэлийн системийг газардуулж, Нам хүчдэлийн системтэй холбодог.

Олон дахин газардуулсан (ОДГН) буюу (MEN) систем

Газардуулгын олон дахин газардуулсан нейтральный (MEN) системд нам хүчдэлийн нейтральный утсыг газардлагын гүйдлийн бага эсэргүүцэлтэй буцах зам болгон ашигладаг бөгөөд үүний дагуу байрласан олон тооны цэгүүд дээр потенциалын ялгаврыг нэмэгдүүлэхгүйн тулд газарт холбодог. Нейтральный утсыг түгээх трансформатор, хэрэглэгч бүрийн тоног төхөөрөмж, тодорхойлсон тулгуурууд, газар доорх гадас, дэр зэрэг дээр газарт холбодог. Түгээх системийн нейтральный утас болон газрын хоорондох эсэргүүцэл аль ч цэгт 10 Ом-оос хэтрэх ёсгүй.

Өндөр хүчдэлийн газардуулгын систем

Өндөр хүчдэлийн газардуулгын системд түгээх трансформаторын дараах зүйлсийг холбодог. Үүнд:

- Трансформаторын бак
- Өндөр хүчдэлийн таслуур
- Өндөр хүчдэлийн аянга баригч
- Өндөр хүчдэлийн кабелийг оруулах ил металл хийц
- Өндөр хүчдэлийн кабелийн экран

Газардуулгын системийн үүсгэх газрын эсэргүүцлийн тооцооны утга 30 Ом-оос хэтрэх ёсгүй. Эсэргүүцэл бага байх тутам газардлагын гүйдэл их болж, газардлагыг мэдэрч тодорхойлоход хялбар болдог.

Өндөр хүчдэлийн хөндийрүүлэг эсвэл тулгуур гэмтсэнээс ил металл хийц (бетон тулгуурыг оруулан) хүчдэлтэй болж болзошгүй тул газраас 2,4 м-н доош зайтай байгаа ил металл хийц (бетон тулгуурыг оруулан)-д хүрэхэд аюулгүй байх, алхмын хүчдэл үүсэхгүй байхаар эсэргүүцлийг хамгийн багаар тооцож хийх ёстой. Болзошгүй аюулаас зайлсхийх зорилгоор газрын эквипотенциал хавтанг суурилуулж болно.

Хэрэв хүссэн газардуулгын системийг суурилуулахад үнэтэй, эсвэл практикт тохирохгүй тохиолдолд металл хийц болон газрын гадаргын түвшингийн хооронд 2,4 м зайд хөндийрүүлэг хийнэ.

Нам хүчдэлийн газардуулгын систем

Түгээх трансформаторын Нам хүчдэлийн газардуулгыг дараах эд ангитай холбодог. Үүнд:

- Трансформаторын нейтральный төгсгөлийн цэг
- Нам хүчдэлийн аянга баригч

Энэхүү газардуулгын системийн эсэргүүцлийн утгыг нам хүчдэлийн нейтральныйхтай ижил байлгах нь дээр. Хэрэв нам хүчдэлийн нейтраль ба газар хоорондын максимум эсэргүүцэл 10 Ом байгаа тохиолдолд трансформатор дээрх

нам хүчдэлийн газардуулга мөн 10 Ом байх ёстой. Үүний дүнд нам хүчдэлийн нейтраль 10 Ом-той тэнцүү байна гэдэг нь тодорхой болно.

Тусад нь газардуулсан Өндөр ба Нам хүчдэлийн (MEN) систем

Энэ системийг уламжлал ёсоор хөдөө орон нутагт бас зарим хот газарт хэрэглэж байсан бөгөөд одоо ч CMEN системийг практик дээр хэрэглэх боломжгүй үед ашигласаар байна. Түгээх трансформаторуудад 2 тусдаа, өөр өөр газардуулгын систем хоорондоо тодорхой зайтай байрласан байх ёстой. Нэг систем нь трансформаторын бак, аянга баригч зэрэг өндөр хүчдэлд өртөж болзошгүй бүх металл хийцийг газардуулахад ашиглагдана. Хоёр дахь системийг нам хүчдэлийн нейтраль болон нам хүчдэлд өртөж болзошгүй бүх металл хийц, нам хүчдэлийн аянга баригч зэргийг газардуулахад хэрэглэнэ.

Түгээх трансформатораас бусад бүх металл хийц газрын түвшнээс дээш 2,7 м дотор байрласан, өндөр хүчдэлийн дамжуулагч утсаар дамжин хүчдэлтэй болж болзошгүй бүх металл хийцэд хөндийрүүлэг хийнэ. Хот суурингаас алслагдсан газруудад металл хийцийг хэсэгчлэн газардуулах ба хөндийрүүлэг хийх шаардлагагүй.


Хэрэв металл хийц нь зөвхөн нам хүчдэлийн дамжуулагч утсаар дамжин хүчдэлтэй болох нөхцөлтэй байвал эдгээр металл хийцийг газардуулж, нам хүчдэлийн нейтральтай холбох ба хөндийрүүлэх шаардлагагүй.


Энгийн олон дахин газардуулсан (ЭОДГН) буюу (CMEN) систем

CMEN систем нь MEN системийн өргөтгөл бөгөөд нам хүчдэлийн нейтралын утас, үүгээр дамжин нам хүчдэлийн газардуулгын систем өргөсөж, дэд станц, трансформатор, тулгуурын металл хийц зэргээс өндөр хүчдэлд өртөж болох хүчдэлийн газардуулгын системтэй холбогддог. Энэ систем нь өндөр хүчдэлийн газардлагын гүйдлийн хувьд бага хэмжээний бүрэн эсэргүүцэл бүхий металл буцах замтай. Газардуулгын энгийн системийг ашиглах үед түгээх системийн нейтралын утас болон дурын байршлын хоорондын эсэргүүцэл 1,0 Ом-оос хэтрэх ёсгүй.

Буцах газардуулгатай нэг дамжуулагчийн систем (БГНДС)

Фазын дамжуулагч 20Ω





Хэлхээний эсэргүүцэл = $20+10+5 = 35\Omega$

Нам хүчдэлийн нейтрэлийг дараах тохиолдолд доорхи зүйлтэй холбож болохгүй.
Үүнд:

- А. Аянга хамгаалалтын зориулалтаар ашиглаж буй агаарын газардуулгын утсанд
- Б. Өндөр хүчдэлийн тоноглолын металл хийц, эсвэл газардуулгын утсанд

Газардуулгыг хэрхэн зөв хийх вэ?

1. Агаарын шугамын угсралтын дүрмийн “Газардуулга” хэсэгт электрод ашигласан болон гүн булсан газардуулгын байгууламж гэсэн хоёр хувилбар хоёулаа ордог.
2. Стандарт газардуулгын систем болох электрод ашигласан системд 1,5 м урт, 13 мм диаметртэй ган голчтой зэсээр бүрсэн электродыг ашигладаг.
3. Нөгөө нэг систем болох гүн булсан хувилбар нь тогтмол хөрсний чийгшилтэй газарт газардуулга хийснээр удаан хугацааны тогтмол газардуулгын утга үүсгэдэг. Энэхүү газардуулгын систем нь БГНДС-н изолятор суурилуулалтын стандарт бөгөөд стандарт газардуулгын электрод ашигласан нөхцөлд гаргаж авсан утгуудыг тодорхойлоход хүндрэлтэй бусад угсралтын ажилд ашиглах хэрэгтэй. Гүн булсан газардуулгыг хийхэд урьдчилан бэлдсэн өрөмдлөгийн төхөөрөмж эсвэл тусгай зориулалтын хийн болон цахилгаан алхыг ашиглана.
4. Хөрсний хувийн эсэргүүцэл хамгийн бага байгаа газрын гүнийг тодорхойлон, хэмжилт хийж, хөрсний хувийн эсэргүүцэл дээр үндэслэн, аль системийг хэрэглэх шийдлээ гаргана.
5. Тухайн газар нутагт хэрэглэдэг практик туршлага хамгийн үр дүнтэй байж болох юм.
6. Хөрсний хувийн эсэргүүцэл бага байгаа газарт, Дүрэмд заасан эсэргүүцлийн утгыг хялбархан олж болно. Хад чулуутай, эсвэл хуурай элстэй газар шаардлагатай эсэргүүцлийн утганд хүрэхэд хэцүү байж

болно. Ингэвэл 17 ба 18-р хэсэгт заасаны дагуу хөрсний хувийн эсэргүүцэлд хэмжилт хий.

7. Хэрэв хөрс гүн болох тутам дамжуулалт нь ихсэж байвал, газардуулгын электродыг дээрх утга шаардагдах хэмжээнд хүртэл нь гүнд байрлуул.
8. Хэрэв гүнд байрлуулаад ч хөрсний дамжуулалт бага байвал, нэмэлт газардуулгын электродуудыг шаардагдах хэмжээнд хүртэл нь тодорхой зайнд суурилуул. (Агаарын шугамын угсралтын дүрмийн холбогдох газардуулгын зургаас үз.)

Дараах зүйлсийг санаж байхад хэрэгтэй. Үүнд:

А. Ерөнхийдөө электродыг ашиглахдаа хөрсний хувийн эсэргүүцлийг хэмжсэн хэмжилтээр шаардагдах хэмжээнд хүртэл уртасгагч хэсгүүдийг ашиглан чийгшил их бөгөөд тогтмол байх газрын гүн рүү аль болохоор гүн оруул. Нэмэлт газардуулгын электродуудыг 2 газардуулгын электродын уртаас илүү хол зайд суурилуулах хэрэгтэй. Доод үе нь илүү бага хувийн эсэргүүцэлтэй, олон давхар үетэй хөрсний хувьд электрод суулгах гүнийг сонгохдоо хамгийн тохиромжтойг нь тохируулж ав. Зарим тохиолдолд газардуулгын илүү үзүүлэлттэй гүехэн үетэй хөрсөөр булах, эсвэл кабель татах нь илүү ашигтай байдаг. Ялангуяа цул хад чулуун тогтоцтой газар газардуулга хийхэд үүнийг хэрэглэж болно.

Б. 1,0 Ом-н системийн шаардлагыг хангах хэрэгцээтэй үед 1,0 Ом эсэргүүцэлтэй байгаа газрыг шинээр хийж буй газартай холбох боломжийг ашигла.

В. Маш өндөр хөрсний хувийн эсэргүүцэлтэй газарт газрын эсэргүүцлийг хүссэн хэмжээнд нь байлгахын тулд нам хүчдэлийн нейтрэлийг тулгуур/ хавтан бүр дээр газардуул.

Гүн булсан электрод

Г. Гүн булсан электродуудыг хөрсний чийгшил тогтмол утганд хүрсэн эсвэл хөрсний хувийн эсэргүүцлийг хэмжихэд хувийн эсэргүүцэл бага байгаа газрын гүнд суулгах хэрэгтэй. Энэ нь 30 м, түүнээс ч илүү байж болно. Нүхийг өргөн өрөмдөж болохгүй бөгөөд энэ нь ус шингээлтийг ихэсгэж, хөрсний тогтоц, найрлагыг өөрчилж болзошгүй. Бентонит- гипсийн зуурмаг, эсвэл үүнтэй төстэй бодисыг газардуулгын электродтой хамт нүхэнд хийж өгнө. Энэ бодисыг хуурайгаар нь орчны хөрснөөс чийг авч байхаар хийдэг. Иймээс тодорхой хугацааны турш газардуулгын эсэргүүцэл багасч байдаг. Найдвартай газардуулгын үзүүлэлт гаргаж авах үүднээс хэдэн өдрийн өмнө үүнийг хийх шаардлага гарч болно. Хөрсний чийгшил маш бага байгаа тохиолдолд газрын үе давхарганд ус нэмж хийж өгөх нь хангалттай газардуулгын эсэргүүцэл урьдчилан гаргаж авахад нэмэр болно. Харин чийгтэй шавар хийж болохгүй бөгөөд учир нь тухайн үед хангалттай үзүүлэлт гаргаж авах боловч хугацааны турш хатаж, эсвэд тэлэх үзэгдэл явагдсаны улмаас энэ үзүүлэлт өөрчлөгдөх болно. Гүнийг зөв тодорхойлж суулгасан электродуудыг тэдгээрийн потециалын тархалтын чиглэл зонхилох хэмжээгээр бие биетэйгээ давхцахгүй байхаар хангалттай зайд салган өрөмдөж суулгана. Энэ зай нь сайн дамжуулалттай хөрсний хувьд дор хаяхад гүнээсээ 2 дахин их байх бөгөөд ямар ч тохиолдолд 5 м-ээс багагүй байна.

Газардуулгын ерөнхий шаардлагууд

- Бүх төрлийн газардуулга нь цахилгаан системийн дүрмэнд нийцсэн байх ёстой.
- Бүх төрлийн газардуулга хоорондын холболтуудыг экзотермик, химийн цэвэр аргаар С хэлбэрээр нугалсан эсвэл шаантаг байдлаар гагнана.
- Бүх төрлийн газардуулганд 40 мм гүн ухсан газарт зэс бүрээстэй электрод хэрэглэнэ. Шаасан бүх зэс электродыг цахилгаан алхаар тохирсон гүн хүртэл угсарч газарт суулгана.
- Газардуулгын утсанд газрын түвшнээс дээш 2,5 м өндөр пластик хоолой буюу түүнтэй төстэй материалаар хамгаалалт хийнэ.
- Дэд станц, таслуурын бүх төрлийн бэхэлгээ төмөр бетон хийцийг газардуулгын системд холбосон байх ёстой.
- Булсан газардуулгын электродыг зэрэгцээ холбосон утсыг газар дээр ил гаргаж болохгүй бөгөөд тэдгээрийг газрын гадаргаас доош 0,5 м-ээс багагүй гүнд булах хэрэгтэй.
- Газардуулгын утасны хөндлөн огтлолын доод хэмжээ нь байж болох газардлагын гүйдлээс хамаарна. Газардуулгын утсаар гүйх гүйдлийн утга нь газардлага үргэлжлэх 1 секундын турш гүйх гүйдлийн тооцоолсон хэмжээнээс хэзээ ч бага байж болохгүй. Дүрмийн ерөнхий шаардлагыг 35 мм² зэс хангадаг.
- БГНДС-ийн аюулгүй ажиллагааны дүрмэнд доорхи шаардлагыг биелүүлнэ:
 - Газрын гадарга дээр анхны газардуулгын электродыг холбосон зэсэнд ногоон/шар өнгийн пластик хоолой углаж тэмдэглэ.
 - Газар дорхи бүх зэс газардуулгыг нүцгэн утсаар хийнэ.
 - Тоног төхөөрөмж бүрд хийсэн 2 салангид тусдаа газардуулгын системийн туршилтыг тусад нь гүйцэтгэнэ.
- Түгээх сүлжээний газардуулгын системд дараах тоног төхөөрөмжийг холбоно. Үүнд:
 - А. Трансформатор ба автомат таслуур
 - Б. Кабелийн металл экран болон хуяг
 - В. Зөвхөн нам хүчдэлийн нейтраль нь нам хүчдэлийн газардуулгын системд холбогддог, өндөр ба нам хүчдэлийн салангид газардуулгын системээс гадна нам хүчдэлийн нейтраль
 - Г. Аянга зайлуулагч
 - Д. Хүчдэл ирж болзошгүй газраас 2,5 м дотор зайд байгаа аливаа хөндийрүүлэггүй металл хийц
- Гадаслаж суулгасан электродуудыг тэдгээрийн өөрсдийнх нь суусан гүнээс илүү зайд суулгана. Хамгийн чухал нь электродуудын гүн нь электрод хоорондын зайтай тэнцүү байх ёстой. Өөрөөр хэлбэл 3 электродын урт нь 5,4 м. Иймээс суулгах үеийн завсар болон газрын шилжилт хөдөлгөөнийг тооцоод электродуудын хоорондын 6 м утас зөвшөөрөгдөнө.

- Газардуулгын хамгийн бага шин нь эсэргүүцлийн 2 шинээс тогтох бөгөөд тус бүр нь 6 м зайтай суулгасан 3 электродын 2 иж бүрдэлтэй байна.
- Газардуулгын хамгийн бага шин нь хүссэн утганд хүрэхгүй бол нэг зэрэг 3 электрод- гадсаар өргөтөж нэмэх г.м.-ээр аль болох олон тооны электрод- гадас шааж, хүссэн газардлагын эсэргүүцэлд хүрнэ. Хамгийн их газардуулгын электродын тоо нь 9 электрод- гадастай 2 шин байна. Нэмэлт электродыг экзотерм гагнуураар эцсийн электрод-гадсан дээр гагнаж гүйцэтгэх ба нэмэлт утсыг давхцуулж болно. Суулгасан электрод- гадас хамгийн их болсон ч зөвшөөрөгдөх эсэргүүцлийн утга гарахгүй бол сүлжээний инженертэй холбоо барьж зөвшилц.
- Аянга зайлуулагчийн газардуулгын нэг төгсгөл дээр кабелийн экраныг холбох хэрэгтэй бөгөөд нөгөө төгсгөл дээр тоноглолын газардуулгыг холбоно.

БГНД бүхий түгээх сүлжээ

Системийн газардуулгын шаардлага

А. Газардлагын оруулга дээрх 2 холболтыг 2 тусдаа газардлагын 2 өөр трассыг ашиглан холбоосгүй, задардаггүй дамжуулагчаар орлуулан хийнэ. Шаардлагатай газардлагын эсэргүүцэл гаргаж авах зорилгоор нэмэлт газардуулгыг эдгээр газардуулганд холбож болно.

Б. Өндөр хүчдэл /ӨХ/ ба Нам хүчдлийн /НХ/ газардуулгуудыг салангид хийх бөгөөд аль болох зайтай өөр чиглэлд суулгана.

В. БГНД-тай системийн газардуулгын дизайныг хийхдээ заавал шугам сүлжээний инженерийг оролцуул. Дизайн хийх ажил дуусаагүй байхад БГНД-тай сүлжээний хэрэглэгчдэд тооцоог өгч болохгүй. Газардуулгын тооцоо хийх инженерт зөвшөөрөл өгөхдөө Гүйцэтгэгч газардуулга хийх гэж буй газартаа нэг электрод суулгаж туршаад, өгөгдлийг үзүүлнэ.

Хамгийн их газардуулгын эсэргүүцлийн дүрэм

Цахилгаан эрчим хүчний түгээх сүлжээнд холбогдохын өмнө дараах цэгүүд дээр зөвшөөрөгдөх утгуудыг гаргаж авах дүрэм үйлчилдэг. Хүснэг 3

Тоноглолын төрөл	А ба Б-г хослуулсан хамгийн наад захын шаардлага	Тэмдэглэл
БГНД-н тусгаарлагч трансформатор	5 Ом	1
БГНД-н түгээх трансформатор	5 Ом	5
Нам хүчдэлийн БГНД-н түгээх трансформатор	50 Ом	4
Аянга зайлуулагч ба кабелийн төгсгөлүүд (Хосолсон газардуулга)	25 Ом	2
Реклозер	50 Ом	
Тавцан дээр/газарт суурилуулсан	50 Ом	3

трансформатор (НХ-н холбосон нейтральгүй)		
Түгээх трансформаторын нейтраль (НХ-н холбосон нейтральгүй)	50 Ом	4

Тэмдэглэл 1

Шугам сүлжээний инженерийг ЗААВАЛ оролцуул. 5 Ом-оос илүү эсэргүүцэлтэй аливаа тусгаарлагч трансформаторын НХ газардуулгын системийн тооцоог холбохын өмнө заавал шалга.

Тэмдэглэл 2

Хосолсон туршилтыг кабелийн экраны болон олон дахин газардуулсан нейтрэлийн бүх холболт байхад гүйцэтгэнэ.

Тэмдэглэл 3

Тавцан дээр суурилуулсан трансформаторын олон дахин газардуулсан нейтрэлийг аянга зайлуулагчийн газардуулганд холбохдоо зөвхөн кабелийн экранаар дайруулна. Олон дахин газардуулсан нейтрэлийг аянга зайлуулагчийн газардуулганд шууд холбохыг зөвшөөрөхгүй.

Тэмдэглэл 4

Түгээх трансформаторын нейтраль (НХ-н холбосон нейтральгүй) дээрх эсэргүүцэл 50 Ом хүрэхгүй тохиолдолд энэ газардуулгыг шаардлагат утганд хүргэх зорилгоор аянга зайлуулагчийн газардуулганд газар доогуур холбохыг зөвшөөрнө. Ингээд ч зөвшөөрөгдөх эсэргүүцэл 50 Ом-оос дээш байвал сүлжээний инженертэй холбоо барь.

Тэмдэглэл 5

НХ-н олон дахин газардуулсан нейтраль нь тусдаа байх ёстой бөгөөд ӨХ-н туршилтын хэсэг байж болохгүй.

Туршилт

Хүчдэл өгөхийн өмнө бүх газардуулгыг турших ёстой.

Газардуулгын шинийн эсэргүүцлийг турших

Газардуулгын шинийн эсэргүүцлийг туршихдаа дараах журмыг баримтална. Газардуулгын эсэргүүцлийг хэмжихдээ газардлагын потециал үүсэх, хүчдэл дамжихаас сэргийлж хөндийрүүлэх бээлий хэрэглэвэл зохино.

Турших журам

1. Хэмжиж буй газардуулгын шинийн бие биеэсээ хамгийн хол байгаа 2 цэгийн хоорондын зайг хэмж. Хуучин шинийн хувьд энэ зай тодорхой байх ёстой.
2. Энэ зайг ашиглан, турших электродонд шаардлагатай зайнуудыг тодорхойлохдоо дорх хүснэгтийг үз.
3. Турших электродыг холбосон шулуун шугам дээр хэмжих үзүүрээ байрлуул. Турших электродыг хэмжих байрнаас зөв зайд ойролцоогоор 100- 150 мм гүн газарт суулга. Хэмжих тестерийн урт үзүүрийг гүйдлийн төгсгөлд, богино үзүүрийг хүчдэлийг төгсгөлд холбох хэрэгтэй.
4. Хэмжих үзүүрийг туршиж буй газардуулгын шинд холбож, турших товчлуурыг даран хэмжилтийг эхэл. Дүнг бичиж ав.

Газардуулгын шинийн урт (м)	6	12	15	20	25	30	40	50
Хүчдэлийн электрод хүртэлх зай (м)	41	60	67	77	87	95	109	122
Гүйдлийн электрод хүртэлх зай (м)	67	98	110	125	140	153	177	197

Газардуулгын арматурыг туршилтын холболт ашиглан шалгах

Туршилтын холболтын шинд 2 газардуулгын шин холбогдсон газардуулгын системийн хувьд дараах хэмжилтийг хийнэ.

1. Шин А
2. Шин Б
3. А+ Б хосолсон (тоноглол хүчдэлгүй бол)

Газардуулгын шин бүрийн физик хэмжээнээс хамаарч өөрчлөгдөх эсвэл 2 шин хосолсон үед туршиж буй газардуулгын эсэргүүцлийн хувьд турших электродын байрлал зөв эсэхийг шалга.

Тоноглолын хүчдэлийг аваагүй үед, хосолсон эсэргүүцлийг дараах байдлаар тооцоолно.

$$R = \frac{A \times B}{A+B}$$

Бичилтийн дүн

Газардуулгын шинийн хэмжилтийн эцсийн дүнг тоноглол болон трансформаторын “Үндсэн хөрөнгийн өөрчлөлт- Маягт Е” гэсэн бүртгэлийн хуудсан дээр бүх мэдээллийг бөглөн бичиж авах ёстой. Үүнд тоноглол/ трансформаторын дугаар, огноо, байрлал, туршилт хийсэн хүний нарын үсэг байна. Газардуулгын арматурын план зургийг энэ маягтанд хавсаргана.


Удирдах өрөөнд энэхүү газардуулгын туршилтын дүнг хүчдэл өгөхөөс өмнө хүргүүлсэн байх ёстой.

Газардуулгын схем

Хүснэгт 4-д болон зураг 26-ийн а, б, в,с, д, е-д стандарт газардуулгын схем, бүдүүвч зургийг үзүүлэв.


Дугаар	Тайлбар
STD- E01	Тулгуур дээр байрласан трансформаторын газардуулгын хийц
STD- E03	Суурилуулах аянга зайлуулагчийн газардуулгын систем

STD- E05	Суурилуулах таслуурын газардуулгын систем
STD- E07	Суурилуулах жишиг БГНД-н түгээх трансформаторын газардуулгын хийц. ӨХ ба НХ газардуулгын системийг салангид хийх
STD- E10	Кабелийн арматур дээрх аянга зайлуулагчтай өндөр хүчдлийн кабелийн төгсгөл
STD- E11	Суурилуулах БГНД-н тусгаарлах трансформатор дээрх жишиг тоноглол ба газардуулгын хийц.
STD- E13	Газардуулгын шинийн бүтэц



- 1 35 мм-н ПВС бүрээстэй зэс
- 2 35 мм-н нүцгэн зэс
- 3 Халуун гагнуур эсвэл С хэлбэрийн хавчаар
- 4 1,8 м 16 мм бүрээстэй зэс электрод
- 5 Олон тооны 1,8 м зэс электрод
- 6 Холбогч

Электродод халуун гагнуураар холбох
 Нүцгэн утас халуун аргаар холбох



STD-E13

Хамгийн бага газардуулгын шин- 12 электрод

Шин А
6 электрод

Шин В
6 электрод

Гүн нь 5,4 м
/3x 1,8 м/

Газардуулгын утас өөр өөр чиглэлд явна

Зай нь 5,4 м
6 м байж болно

Шин А
9 электрод

Шин В
6 электрод

Тэмдэглэх нь:

1. Хөрсний шилжилт болон суурилалтыг тооцож, электродуудын хооронд 0,5 м завсартай хий.
2. Эхний газар доорх электрод тулгуур эсвэл тоноглолоос 1,5 м-ээс багагүйг зай байна.
3. Эхний электрод руу ПВС бүрээстэй утас явна.
4. Сүлжээний инженерийн тооцсонын дагуу газардуулгын утас нарийн байж болно.
5. Хамгийн олон 18 газардуулгын электрод суулгаад эсэргүүцлийн утга 50 Ом болохгүй бол Сүлжээний инженертэй зөвшилц.

Хэрэв эсэргүүцлийн хүссэн утга Шин А-д 3 электродоор залгаж уртасгаад 4 газардуулгын шинийн хамгийн бага утганд хүрэхгүй бол

Хэрэв эсэргүүцлийн хүссэн утга Шин В-д 3 электродоор залгаж уртасгаад 4 дээрх газардуулгын шинэнд хүрэхгүй бол

Хамгийн их газардуулгын шин- 18 электрод

Шин А
9 электрод

Шин В
9 электрод

Газардуулга Газардуулгын 2 стандарт шинийн бүтэц

STD-E11


Газардуулгын утас:

1 фазын ажлын трансформаторын газардуулга нь трансформаторын ВХ талаас газардуулгын хөлхээ бүрийн эхний 2 электрод руу залгаагүй 2 x 35 мм зэс утсаар холбосон байна.

Нэмэлт электрод руу холбох бүх нэмэлт газардуулгыг 35 мм зэсээр жийнэ.

ВХ талын газардуулгын холболт нь газартай харьцуулсанаар 5 Ом-оос илүүгүй эсэргүүцэлтэй байх бөгөөд газар дээр хүндэлийн потенциал үүсэхээс сэргийлэх зорилготой.

Гүн булсан системийг сүвганд байрлуулж, доор нь байгаа олон тооны электроод холбох нь дээр байдаг. Электродын систем нь наад зах нь кабелийн хайрцаг, барилга, хашаанаас 2 м зайтай байх ёстой.



STD-E10

Бөхний экраныг газардуулгын дорд үзүүртэй хавчиж холбоогийн бага хэмжээтэй 35 мм-н ПВС хэрэглэ


Холболтын тавыг шахаж давтан төгсөвч болон звээрдэггүй болтоор бэхэл

Бөхний экраныг болон жтой бол 2 төгсгөл нь газардуул. 1 судалтай болон 3 судалтай гьд/

Суурилуулсан аянга зайлуулагчийн ба бөхний экраныг түүний газартай олбоно.

Газардуулгын утас:

Динээр хийж газардуулгын хувьд улгуурын дор 15 мм-н зэс хэрэглэ. Дүрмэнд буюу инженерийн зааварт өөрөөр заагаагүй бол 35 мм-н газрын бүх зэс гас нүцгэн байна.



Аянга зайлуулагчийн хувьд стандарт газардуулга суулгасан үед нэмж суулгах ёстой.

Босоо байрлалтай аянга хамгаалагч хэрэглэ

Ка бөхний хамгаалалт металл бол заавал газардуулсан байх ёстой

Модон тулгуурт ка бөхний хамгаалалтыг шрулгээр бөхөл. Бетон тулгуурт 1120 мм-н өндөр бүслүүрээр бөхөл.

Кабель Газардуулгын шинийн бүтцийг үз. 10 Ом-оос бага байх ёстой.

Газардуулга
Аянга зайлуулагчийн
холболт дээрх
кабелийн төгсгөл

Бөхний кабель суурилуулах болж нь трансформаторын шугам дор нүцгэн газардуулгыг үргэлжилсэн кабелиар хийж болох бөгөөд кабелийн экран болон аянга зайлуулагчийн газрын 2 төгсгөл дээр холбоно.


Газардуулгын утас:

1 фазын ажлын трансформторын газардуулга нь трансформаторын ӨХ талаас газардуулгын хэлхээ бүрийн эхний 2 электрод руу залгаагүй 2 x 35 мм зэс утсаар холбосон байна.

Нэмэлт электрод руу холбох бүх нэмэлт газардуулгыг 35 мм зэсээр хийнэ.

ӨХ талын газардуулгын холболт нь газартай харьцуулсанаар 5 Ом-оос илүүгүй эсэргүүцэлтэй байх бөгөөд газар дээр хүчдэлийн потенциал үүсэхээс сэргийлэх зорилготой.

Буцах газардуулгатай системийн хувьд НХ болон ӨХ-н газрыг тусад нь өөр чиглэлд хийх ёстой.



1 фазын буцах газардуулгатай түгээх трансформаторын газар

STD-E05



Тулгуур дээрх бусад газардуулгыг үндсэн газардуулгатай холбо. Бүү тасал. Шахаж давтсан, шаантаг, эсвэл гагнуурын холболт хэрэглэ.

С хэлбэрээр нугалах эсвэл гацдаггүй газардуулгын гарыг үндсэн газардуулгын утас руу

ТГЫН УТАС:
ийх бүх газардуулганд дор 35 мм эс дамжуулагч ирүүлэгтэй/хэрэглэ. инженерийн тооцоолсоноор даж болох юм. инженер дүрмийн дагуу гээгүй бол газар дорх бүх үгэн байх ёстой.

Гацхаас хамгаалагдсан агаарын таслуур дээр холболт хийхдээ шахаж давтсан төгсөвч болон эзвэрдэггүй болт хэрэглэ.

Ажлын гар

Ажлын гарыг шахаж давтсан төгсөвч болон хамгийн бага нь 35 мм богино холбоостой эзвэрдэггүй ган болт хэрэглэн холбо. Наад зах нь С хэлбэрийн холбоос ашиглан 1 ш шахаж давтсан төгсөвчөөр үндсэн газардуулгын утсанд холболт хий.

Газардуулгын хамгаалалт тохирсон диаметртай PVC хоолой түүнтэй төстэй материал. Дор хаяж газраас дээш 2,5 м байна. Бариулыг газардуулахдаа 1,1-д тасал. Хоолойг тулгуурт сайн бэхэлнэ.

ГАЗАРДУУЛГА

АГААРЫН ТАС /
ИЗОЛЯТОР

Газардуулгын эсэргүүцэл 50 Ом-оос бага байх ёстой

Аянга зайлуулагчийн ёзоорын болтон дээр шахаж давтсан бэхэлгээ хэрэглэ

STD-E03



Тулгуур дээрх аливаа газардуулгыг дунд талд нь холбо. Тасалж болохгүй. Шахаж давтах, гагнах, шаантаг г.м. Холболтыг ашигла.

Угсралтын үед газардуулгыг туршихын тулд газардуулгын хамгаалалтнаас дээш 200 мм, аянга зайлуулагчаас 33 мм пластик хоолойг огтол.

Газардуулгын утас:
Шинээр хийх газардуулганд 35 мм-н зэс хэрэглэ. Дүрмэнд буюу инженерийн зааварт өөрөөр заагаагүй бол газар дорх бүх утас 35 мм-н нүцгэн зэс байна


Газардуулгын хамгаалалт
Тохирсон диаметртэй пластик хоолой, эсвэл түүнтэй төстэй материал
Газрын түвшнээс дээш наад зах нь 2,5 м
Хоолойг тулгуурт сайтар бэхэлнэ.

Аянга зайлуулагчийн газардуулга

Тодорхой бус зүйлсийг хэмжих:

Хөрсний гүйдэл дамжуулалт шугаман бус хамааралтай. Иймээс газардуулгын системийн газартай харьцуулсан эсэргүүцэл нь хэмжилтийн хүчдэл, гүйдэл, давтамжаас хамааран ялгаатай байдаг. Энэхүү газардуулгын системийн газартай харьцуулсан эсэргүүцэл нь мөн цаг агаарын нөхцлөөс хамаарч өдөр бүр өөрчлөгдөж байдаг. Эдгээр асуудлаас болж бүх хэмжилтэнд 20% тодорхой бус байдлыг оруулах ёстой.

Газардуулгын системийн эсэргүүцэл



Зураг 27. Газар дорхи электродын зүссэн байдал


Нэг төрлийн хөрсөн дэхь газардуулгын системийн хувьд гүйдлийн урсгал, потенциал тархалт болон градиентын чиглэлийг газардуулгын системээс алс байрласан цэгүүд дээрх ойролцоо тал бөмбөлөг хэлбэрийн электрод гэж үзэж болно. Зураг 2 дээр электродоор дамжих, тал бөмбөлөгтэй төстэй хүчдэлийн байршлыг газрын зүсэлтээр үзүүлэв.

“ ρ ” Ом-метр хувийн хөрсний эсэргүүцэл бүхий нэг төрлийн хөрсөнд, “ r ” радиустай тал бөмбөлөг хэлбэртэй электрод болон гадарга дээр “ P ” метр зайтай байгаа цэгийн хоорондох “ R ” эсэргүүцэл нь:

$$R = \frac{\rho}{2\pi} \left(\frac{1}{r} - \frac{1}{P} \right) \text{ Ом}$$

“ P ” хязгааргүй болоход:

$$R = \frac{\rho}{2\pi r} \text{ Ом}$$



Зураг 28. "P"-зайнаас хамаарсан эсэргүүцэл

"1 м" урттай, "d" диаметртэй электродыг дээр дээрээсээ давхарлан байрласан маш олон тооны бөмбөлөг маягаар загварчилж болно. Газрын ерөнхий масстай харьцах электродын эсэргүүцлийг дорхи байдлаар илэрхийлнэ:

$$R = \frac{\rho}{2\pi l} \left[\ln\left(\frac{8l}{d}\right) - 1 \right] \text{ Ом}$$

Электродыг ижил эсэргүүцэл бүхий тал бөмбөлөгтэй төстэй гэж үзэж, сүүлийн 2 тэгшитгэлийг тэнцүүлэн "r" радиусыг олж болно. Ингээд радиусыг илэрхийлбэл:

$$r = \frac{l}{\ln\left(\frac{8l}{d}\right) - 1} \text{ метр}$$


Эсэргүүцлийг хэмжих

Газардуулгын эсэргүүцлийг хэмжих хамгийн ерөнхий арга бол "потенциалын уналтын арга" юм. Энэ аргаар "E" туршилтан дахь газардлагын системээр хэмжилтийн гүйдэл гүйлгэж ямар нэг "C" зайнд шүпээр гүйх түр гүйдлээр буцаах явдал юм. Туршилтанд байгаа системийн потециалын өсөлтийг 2 гүйдлийн сорьцын хоорондох газар "P" зайд байрлах шүп ашиглан хэмжинэ. Эсэргүүцлийг потециалын өсөлт болон хэмжлийн гүйдлийг ашиглан тооцож гаргана.

“ ρ ” Ом-метр хувийн хөрсний эсэргүүцэл бүхий хөрсөн дэхь “ r ” радиустай тал бөмбөлөг хэлбэртэй электродын системийн хувьд, эсэргүүцлийн тэгшитгэл:

$R = \frac{\rho}{2\pi} \left(\frac{1}{r} - \frac{1}{P} \right)$ Ом болох ба энэ нь бусад гүйдлийн электрод хязгааргүй тохиолдолд ийм байна. ө.х. $C = \infty$. “ C ” хязгааргүй хол зайд байхад дурын “ P ” цэг дээр хэмжсэн эсэргүүцлийн утга:


$$R = \frac{V}{I} = \frac{\rho}{2\pi} \left[\left(\frac{1}{r} - \frac{1}{C-r} \right) - \left(\frac{1}{P} - \frac{1}{C-P} \right) \right] \text{ Ом болно.}$$



Зураг 29. Потенциалын уналтын арга

Тусгаарлагдсан газардуулга бүхий системийн эсэргүүцлийг хэмжих

1. Зураг 5-д үзүүлсэнээр төхөөрөмжийг холбо. Наад зах нь 2,5 мм хөндлөн огтлолтой хэмжих үзүүр ашигла.
2. Гүйдлийн “ C ” щупыг хэмжилт хийх газардуулгын системээс 50 м зайтай байрлуул. Гүйдлийн щупыг явах замтай нь аль болох зөв өнцгөөр газар дорхи кабель, металл хоолой, металл хашаа г.м-ээс хол байрлуул. Орон зайн боломж байхгүй бол “ C ” щупыг 20 м-д байрлуулж болно.
3. Бүх электродыг ойролцоогоор шулуун шугаманд байрлуулж, 300 мм- 500 мм хүртэл гүн булсан эсэхийг шалга. Газартай холбосон эсэргүүцлийг бага байлгахын тулд гүйдлийн щупыг хангалттай гүн хөрсөнд суулгах нь маш чухал.
4. Гүйдлийн “ C ” щуп хүртэлх 50%, 60%, 70% зайд “ P ” щупны потециалыг уншиж эсэргүүцлийн утгыг ав (ө.х. “ C ” 50 м байхад 25м, 30 м, 35 м-д).



Зураг 30. Газардлагын эсэргүүцлийн хэмжилт хийх

Энэхүү 3 утгын зөрүү 10%-иас ихгүй байх ёстой. Хэрэв ийм биш бол "С" щупыг 100 м-д байрлуулахад газардуулгын системийн эсэргүүцлийн орон зай ихсэж, хэмжилт хийхэд бэрхшээлтэй байдаг. (дараахи бүлэгт үз). Потенциалын "Р" щупээр "С" зай хүртэл 50%, 60%, 70% зайд эсэргүүцэл хэмжилтийг давт.


Олон дахин газардуулсан нейтралийн (MEN) системийн эсэргүүцлийг хэмжих

Энэ арга нь тусгаарлагдсан газардуулга бүхий системтэй төстэй бөгөөд гагцхүү дараах өөрчлөлтүүд ордог:

1. Гүйдлийн "С" щупыг замын дагуу илүү хол байрлуулж болох боловч хэрэглэгч, цахилгаан сүлжээ, газардуулгын электрод, металл труба хоолой, төмөр зам, металл хашлага г.м.-ээс алс зайд байрлуулах ёстой. Спортын талбай, хашсан билчээр, хогийн цэг г.м газар байж болно.
2. Гүйдлийн щуп нь наад зах нь 100 м зайтай байна.

Идэвхитэй эсэргүүцэлтэй газрууд

Зур.6-д гүйдлийн "С" щупны "Е" хэмжилтэнд байгаа газардлагын системийн эсэргүүцэлтэй газрыг (нягтарсан үүрнүүд) үзүүлэв. Эсэргүүцэлтэй хэсгүүд давхацсан. Хэрэв хэмжилтийн утгуудыг потенциалын "Р" щупыг "Е" эсвэл "С" рүү чиглүүлэн хөдөлгөж авбал энэ утгууд нь үлэмж ялгаатай болно.



Зураг 31. Эсэргүүцэл нь давхацсан газар

Зураг 32. Эсэргүүцэл нь тусдаа газар

Зураг 32-д “E” хэмжилт хийгдэх газардлагын систем болон “C” гүйдлийн шүп нь эсэргүүцэл бүхий газруудыг давхцуулахгүйгээр хангалттай зайтай байх ёстой. “C” шүп хүртэлх 50%, 60%, 70% зайд байрлуулахад, “P” шүпээр авсан утгууд нь их зөрүүгүй байх ёстой.

Хөрсний хувийн эсэргүүцлийг хэмжих

Нэгж урттай кубын эсрэг талуудын хоорондох эсэргүүцлийг хэмжиж хувийн эсэргүүцлийг тодорхойлох ба үүнийг голдуу ом.метрээр хэмжинэ. Энэхүү хувийн эсэргүүцэл нь чийгний агууламжаас хамаарч өөрчлөгдөх бөгөөд хөрс нь янз бүрийн гүнд хад, чулуу г.м. төрөл бүрийн найрлага бүхий үе давхаргатай нэг төрлийн бус байх нь түгээмэл. Гэсэн хэдий ч ихэнх хөрс бүрэн хуурай үедээ дамжуулагч болдоггүй тул хөрсний хувийн эсэргүүцлийг ерөнхийд нь хөрсөнд байгаа усны хэмжээ болон усны өөрийнх нь хувийн эсэргүүцлээр тодорхойлдог. Хөрсний гүйдэл дамжуулалт нь хөрсөнд байгаа усаар явагдах бөгөөд энэ нь голдуу электролит байдлаар явагдана. Хөрсний хувийн эсэргүүцлийг тодорхойлдог үндсэн үзүүлэлтүүд нь:

- Хөрсний төрөл
- Агууламжинд нь байгаа усанд ууссан давс
- Чийгний агууламж
- Температур
- Нунтагшлийн хэмжээ

Е. Нягтшил даралт

Ихээхэн хэмжээний хөндөгдөж эвдрээгүй хөрсний хувийн эсэргүүцлийг хэмжих хамгийн түгээмэл арга нь 4 цуптэй Виннерийн арга юм. Хүснэг 5

Хөрсний төрөл	Жишиг хувийн эсэргүүцэл (ом метр)
Үнслэг	6- 70
Шавар (нойтон)	14- 30
Шавар (хуурай, шахагдсан)	100- 200
Гранит	2000- 3000
Шохойжсон чулуутай	1000- 5000
Шавар (тунамал устай)	200- 400
Шавар (элс, хайрга)	30- 50
Шавар (чулуулаг)	100- 300
Шавар (чулуулаг, ургамлын үлдэгдэлтэй)	200- 350
Намгархаг хөрс	300- 400
Уулын хад, чулуу (жижиг, гэхдээ хөрс биш)	5- 40
Уулын хөрс (хад, чулуун суурь дээр хатуурсан)	1000- 5000
Уулын хөрс (хад, чулуун суурьтай)	150- 300
Давсан суурьтай	300- 1000
Элс (усны гадарга дорхи)	6- 70
Элс (чийгшилтэй)	60- 130
Элс (хуурай)	1000- 5000
Элс (шүлтэжсэн)	1000- 5000
Элсэрхэг чулуулаг	120- 7000
Наалдамхай зуурмаг	100- 160

Хүснэгт 5: Төрөл бүрийн хөрсний жишиг хувийн эсэргүүцэл

Виннерийн арга




Figure 8 – The Wenner Method

Зур33. Виннерийн арга

Энэ арга нь “a” метрийн тэнцүү интервалтай зайнд, “b” метр гүнд 4 электрод байрлуулна. 4 электродыг шулуун шугаманд байрлуулах ёстой (Зур.8-г үз). Хэмжүүрийн гүйдэл “I”-г гадна талын 2 электродын дундуур өгч дотор талын 2 электродын хооронд “V” потенциалыг хэмжинэ. “V/I” харьцаагаар хоорондын “R” эсэргүүцлийг ом-оор гарган авна.

ρ хувийн эсэргүүцэл бүхий нэг төрлийн хөрсний хувийн эсэргүүцлийн хувьд Виннерийн тэгшитгэл:

$$R = \frac{\rho}{4\pi a} \left[1 + \frac{2a}{\sqrt{a^2+b^2}} - \frac{2a}{\sqrt{4a^2+4b^2}} \right]$$

Эндээс “ ρ ” хувийн эсэргүүцлийг гарган авч болно.

$$\rho = \frac{4\pi a R}{1 + \frac{2a}{\sqrt{a^2+b^2}} - \frac{2a}{\sqrt{4a^2+4b^2}}}$$

Энэ томъёо нь газарт шаасан дамжуулагч электродонд бус “b” гүнд булсан 4 жижиг цэгэн электродонд хэрэглэгдэнэ.

Практикт 4 электродыг голдуу газарт булдаг. Хэрэв электродыг тэдгээрийн зайны 1/20-ээс бага гүнд оруулсан бол (өөрөөр хэлбэл $b < a/20$):

$$\rho = 2\pi a R \quad \text{ом- метр}$$


Гаргаж авсан энэ тэгшитгэлд хөрсийг нэг төрлийн гэж үзэх боловч голдуу энэ нь тийм биш байдаг. Иймээс хөрсний “a” зай бүрд хувийн эсэргүүцэл нь өөрчлөгддөг. Тооцоолсон энэхүү хөрсний хувийн эсэргүүцлийг түүний нэг төрлийн бус хөрсний хувийн эсэргүүцэлтэй учир “a” зайд мэдэгдэж байгаа электродын хувийн эсэргүүцэл гэж нэрлэдэг.

Гүйдлийн нэвчилт нь “a” зайтай электродтой тэнцүү гэсэн санал байдаг. Энэ нь тийм биш гэдгийг үзүүлж болно. Хэдийгээр “a” метр зайтай электродын тодорхой хувийн эсэргүүцлийг “a” метр гүний дундаж хувийн эсэргүүцэл гэж үзвэл, ихэнх тохиолдолд энэ нь хангалттай ойролцоо утга болно.

Хөрсний эсэргүүцэл хэмжих

1. Зур.9-д үзүүлсэнээр төхөөрөмжийг холбо. 4 туйлт газардуулгын эсэргүүцэл хэмжигч нь хоорондын эсэргүүцэл “R”-ийг шууд ом-оор илэрхийлдэг байх ёстой. Хэмжүүрийн үзүүрт дор хаяхад 2.5 мм² хөндлөн огтлолтой утас ашигла.

2. Электродуудыг шулуун шугам дээр, тэнцүү “а” метр зайд байрлуулж, энэ зайн 1/20-ээс ихгүй гүнд суулгасан эсэхээ шалга.
3. Хэмжүүрээ төвд нь байрлуулж байгаад, электродуудын байрлал дээр хэмжилт хий. Электрод хоорондын зай ойролцоогоор тэнцүү байна гэдгийг мартаж болохгүй.




Зураг 34. Хөрсний эсэргүүцэл хэмжих хэмжүүрийг холбох

4. Зай тус бүрд дээр үзүүлсэн тэгшитгэлийг ашиглан хөрсний хувийн эсэргүүцлийг тооцож гарга. Хөрсний хувийн эсэргүүцлийг хэмжсэн гүн нь хоорондын зайн адил ойролцоогоор тэнцүү байх ёстой.


Зураг 35-д тодорхой хөрсний хувийн эсэргүүцлийн жишиг графикийг олон үе бүхий хөрсний хувьд үзүүлэв. Энэ хэсгийн төгсгөлд хэмжилтийн дүнг бичих маягыг үзүүлэв.

2 үетэй хөрс

Тухайн хөрсний
хувийн эсэргүүцэл, ом-м




Тухайн хөрсний
хувийн эсэргүүцэл, ом-м




3 үетэй хөрс

Тухайн хөрсний
хувийн эсэргүүцэл, ом-м





Тухайн хөрсний
хувийн эсэргүүцэл, ом-м




Зураг 35. Тодорхой хөрсний хувийн эсэргүүцлийн жишиг график

Монгол орны хөрсний бүтэцийн эзлэх хувийг графикаар харуулав. Зураг 36.



Монгол орны хөрсний бүтэцийн ерөнхий бүдүүвч Зураг 37.



Хөрсний эсэргүүцэл хэмжих хэмжүүр. Хамгийн их хэрэглэгддэг хэмжүүр бол “ЕТ5” буюу газардуулга хэмжих меггер юм. Энэ меггер нь газардуулгын электродын эсэргүүцэл болон хөрсний хувийн эсэргүүцлийг хэмжихэд хэрэглэгддэг иж бүрдэл төхөөрөмж юм. Дотор нь суурилагдсан цахилгаан генератор мөн иж бүрдэлд байдаг 1.5 В-н элементээс хувьсах гүйдэл гаргана. Хувьсах гүйдэл хэрэглэж байгаа нь элетролизийн үзэгдэл болон хөрсөн дэхь тохиолдлын чанартай тогтмол гүйдлийн шуугианыг дарах зорилготой. Гаралтын гүйдлийн давтамжинд (126 Гц) үндсэн давтамж болох 50, 60 Гц-н давтамж болон хэвийн хэмжилтийн үед хөрсөнд тохиолдлын чанартай тогтмол гүйдлээс гарах шуугиан нөлөөлдөггүй.

Системийн ажиллах үндсэн зарчим нь хувьсах гүйдлийн генераторын гүйдэл хэмжиж буй газардуулгын электродууд болон гүйдлийн электрод дундуур гүйнэ. Хэмжиж буй газардуулгын электродууд болон тусдаа байгаа потенциалын электрод хоорондын потенциалын уналтыг хэмжүүрийн цахилгаан хэлхээ болон гүйдлийн трансформатораар дамжин ирсэн хувьсах гүйдлийн гаралт дээрх хүчдэлтэй тэнцвэржүүлнэ.

Потенциалын ялгавраар үүссэн тэнцвэргүйжилтийн гүйдэл шулуутгагдаж, микроамперметрийн ороомгоор гүйж төвийн “0”-г шилжүүлнэ. Ом-н нарийн утгыг хязгаар сонгох түлхүүрүүдийн байрлалыг хослуулан тавьж, хэмжүүр “0”-г заах үед утгыг тэмдэглэн гарган авна.

“0” төвтэй гальванометрээр гаргасан “0” балансын утга нь эсэргүүцэл хэмжилтийн утганд үйлчлэхгүй болж, потенциалын электрод хооронд гүйдэл гүйхгүйг илтгэж байгаа болно.

Хөрсний эсэргүүцэл хэмжих хэмжүүрийг ашиглах

1. Баттерейг шалгаж шаардлагатай бол соль.
2. Тухайн хэмжилтийг гүйцэтгэхдээ өмнө дурьдсан байдлаар холбо.

3. Хязгаар тохируулах түлхүүрийг х 0.01 байрлалд тавьж, тэнцвэржүүлэх резисторыг 9-рүү эргүүл (жишээ нь 9.99 Ом г.м.)
4. Хэмжих товчлуурыг дарж, гальванометрийн хазайлтыг ажигла.
5. Хэрэв гальванометр “+” талд заавал, хазайлтыг “-” болтол хязгаарын түлхүүрийг х0.1 рүү (эсвэл их рүү) багасга.
6. Хэрэв гальванометр “-” талд заавал, резисторын утгыг зүүн талынхаас эхлэн, эцэст нь баруун талынх хүргэн орон орноор багасганж гальванометрийн зүү голд иртэл нь багасга.
7. Эсэргүүцлийн зөв утга: (Түлхүүр дээрхи утга) х (хязгаарын утга)
8. Өөрсдийн хэмжих багаж SYSCAL R1 PLUS, (Франц)
Ф 4103-М, 1 газардлагын хөрсний эсэргүүцэл хэмжигч, (Орос)

Хөрсний хувийн эсэргүүцлийг хэмжих хүснэгтийн маягт 8.

Огноо: он сар өдөр цаг.....минут

Байршил _____

“а” зай (метр)	“R” Эсэргүүцлийн утга Ом	Харгалзах хувийн эсэргүүцэл $\rho = 2\pi aR$ ом- метр
1		
2		
5		
10		
15		
20		
25		
30		
35		
40		
45		
50		
60		
70		

Харгалзах хувийн эсэргүүцэл (ом- метр)												
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
	Зай (метр)											

2.4 Монгол орны хөрсний эсэргүүцлээс хамааруулан /хангай, говь, хээрийн бүсэд/ чадлын урсгал, газардуулгын тооцоо хийж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг сонгох арга зүй боловсруулах

Энэхүү судалгааны ажлын гол зорилго нь Багийн төв, жижиг суурин хэрэглэгчдийг БГНДС-ээр хангах туршилт судалгааны ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай чадлын урсгал, газардуулгын тооцооны аргачлалыг Монгол орны хөрсний эсэргүүцлээс хамааруулан тодорхой болгоход оршино. Тухайлбал дараахи асуудлуудад онцгой анхаарал тавих ёстой.


А. Газардуулга зайлшгүй чухал.

IEEE Standard 80-2000 болон Хувьсах гүйдлийн дэд станцын газардуулгын аюулгүй ажиллагааны зааварт Газардуулгын зураг төсөлд дараах 2 аюулгүй байдлыг хангасан байх ёстойг заавал тусгасан байдаг.

1. хэвийн болон гэмтлийн үед газраар цахилгаан гүйдэл дамжихдаа болон тоноглол болон түүний ажиллагааг ямар нэг байдлаар хязгаарлах буюу үйл ажиллагаанд муугаар нөлөөлөхгүйгээр хангагдсан байх.
2. Газардуулагдсан тоноглолын ойр хавьд байгаа хүн, мал амьтан цахилгаан гүйдэлд нэрвэгдэх аюулд өртөхгүй байхаар байлгах.

В. БГНД системийн ажиллах зарчим.

Монголын эрчим хүчний түгээх системийн тогтсон хэв маяг нь уламжлалт 3 утаст тэнцвэржсэн систем байдаг бол БГНДС нь газраар дамжих буцах гүйдэл Тусгаарлах трансформаторын эх үүсвэрт эргэж холбогддог.



БГНДС-ийн ажиллах ерөнхий зарчим Зураг 38.

Түгээх болон тусгаарлах трансформатор хоёуланд нь газраар дамжин буцах газардуулгын гүйдэл гүйснээр газартай харьцангуй потенциал (GPR)-ыг бий болгоно. GPR-ийн хэмжээ газардуулгын эсэргүүцэл болон газардуулгаар буцах гүйдлийн үржвэртэй тэнцүү. $GPR=IR$

Өгөгдсөн ачаалал болон эсэргүүцлийн хувьд тухайн системийн ажиллах хүчдэл бага байхад GPR өндөр байна. Жишээлбэл: 20.2 кВ БГНДС-ийн 50кВт БГНДС-ын ачаалал 5 Ом газардуулгын эсэргүүцэлтэй байхад GPR нь 6 кВ байна. Хүснэг 10.

БГНД-ийн хүчдэл	Ачааллын гүйдэл	GPR
6.0 KB	8.3 A	41.5 B
20.2 KB	2.5 A	12.5 B

Тоноглолоор дамжих тоног төхөөрөмжийн газардуулгад GPR –ийн зөвшөөрөгдөх утгыг хүлээн зөвшөөрдөггүй. Энэ тайлангийн гол санаа нь Шинэ Өмнөд Велсийн ЦЭХГ (Австраль) шаардлагаар GPR-ийг БГНДС (SWER)-д бүх төрлийн хөрсөнд (хөлдөлтийг оролцуулан) хамгийн ихдээ 20 В байхаар хязгаарлаж өгсөн байдаг. Энэ нь мал амьтан өртөж болох GPR-г 40 В-оор тооцож авсан бөгөөд 2.0-оос хэтрүүлж болох аюулгүй нөөцийг зураг төсөлд тусгаж болохоор тооцсон. Австралийн практикт Түгээх тр-рийн Дунд хүчдэл, нам хүчдлийн газардуулгыг тусгаарладаг бөгөөд энэ нь хэрэглэгчдийн орчинд тархмал хүчдлийн нөлөөллийн хэмжээг бууруулдаг

С. Хөрсний хувийн эсэргүүцэл.

Газар бол том хэмжээтэй төгс дамжуулагч. Тэр маш их хэмжээний хөндлөн огтлолтой. түүний цөм нь өндөр дамжуулах чанартай хайлмаг шингэн метал байдаг болохоор газрын эсэргүүцэл тэг Ом байна. Газрын гадрагын өнгөн давхарга нь өөр өөр хувийн эсэргүүцэл бүхий олон төрлийн хөрс шорооноос бүрддэг. Энэ газарын гадрагад цахилгаан холбоос үүсгэх газардуулгын хүрээ хийдэг. Газардуулгын хүрээний хэмжээ нь газартай холбоотой боловч түүнтэй ижил том хэмжээтэй биш учир тэг ом байх боломжгүй юм.

Хөрсний эсэргүүцэлд нөлөөлөх дараах 4 хүчин зүйлс байна.

1. Хөрсний бүрэлдэхүүн (Шавар, Элс, Хад чулуу...)
2. Хөрсний чийгшлийн агууламж
3. Хөрсний температур
4. Эрдэс бодис (давс) холимог

Хөрсний хувийн эсэргүүцэлд нөлөөлөх олон хүчийн зүйлээс хамгийн чухал нь хөрсний бүрэлдэхүүн юм. Янз бүрийн хөрсний хувийн эсэргүүцлийн хүрээ дараах байдалтай байна:

Хүснэг 11


Хөрс	Ердийн хувийн эсэргүүцэл /Ом-м/
Шавар	10-150
Шороо	10-200
Элс хайрга	50-100
Хадархаг чулуулаг	1000-5000
Цул хад	10^4 - 10^7

Тухайн хөрс металлаас муу дамжуулагч болохыг энд тэмдэглэгдсэн байх ёстой мөн хөрсний эзэлхүүн их байх үед газарт аюулгүй холболт хийх зураг төсөл хийсэн байна. Ердийн металлуудын хувийн эсэргүүцлийг дараах байдлаар харуулж байна.Хүснэг 12.

Металл	Ердийн хувийн эсэргүүцэл /Ом-м/
Зэс	$1,6 \times 10^{-8}$
Хөнгөн цагаан	$2,5 \times 10^{-8}$

Практикт хөрс нь шавар, элс, хад чулууг янз бүрийн хэмжээгээр агуулах бөгөөд хөрсний гүнээс хамаарч хувийн эсэргүүцэл өөр өөр байна. Энэ шалтгаанаар хөрсний хувийн эсэргүүцлийг хэмжиж, хэмжилтийн үндсэн дээр хөрсний бүтцийг сайжруулах арга хэмжээ авч болно. Хөрсний бүтцийг сайжруулах үүднээс хэрвээ чулуун дэвсгэртэй үе хөрсний гадаргын доод хэсэгт байвал газардуулгын гадсыг гүн суурилуулахыг хориглодог.

Хөрсний чийглэгийн агууламж нь хөрсний хувийн эсэргүүцэлд гол нөлөө үзүүлнэ. Хөрсөөр дамжих цахилгаан нь электролит болох бөгөөд , энэ 2 хүчин зүйл нь хоёулаа дэмжлэг болох буюу цахилгаан урсгалыг хориглох. Хөрсөн доторхи давс, чийглэгийн агууламжийг өсгөхөд хөрсний хувийн эсэргүүцэл буурна. Температур 0°C-аас доошлоход ус хөлдөж, олонхи хөрс хөлдсөн үе давхаргад хөрсний хувийн эсэргүүцэл ихэсдэг. Энэхүү төслийн зорилго нь хөрс хөлдсөн нөхцөлд хөрсний гадаргын 1,5м-т хэмжсэн хувийн эсэргүүцлийг хэрэглэн нэмэгдүүлэх хүчин зүйл тооцох явдал юм. Энэ төсөлд элсэрхэг хөрсний хувьд 10 дахин, шаварлаг хөрсөнд 30 дахин өсгөж хамаарлыг сонгоод байна. хөрсний чийглэгийн агууламж 15.2% байгаа элсэрхэг шавар хөрсөнд эдгээр хүчин зүйлүүдийн хувьслыг дараах муруйгаас харж болно.




Хөрсний хувийн эсэргүүцэлд давс, чийг, температурын нөлөө Зураг 39.

Хөрсний хувийн эсэргүүцлийн хэмжилтийг Франц улсад үйлдвэрлэсэн Syscal R1 Plus багжийг ашиглан хэрэглэн Канад улсын Манитабо Хайдро Интернейшнл ХХК-ийн инженерүүд хөрсний хувийн эсэргүүцэлийг тодорхойлсон байна..



Syscal R1 Plus маркийн хөрсний хувийн эсэргүүцлийн хэмжилтийн багаж. Зураг 40.

Хөрсний хувийн эсэргүүцлийн хэмжилтийг энэхүү төслийн хүрээнд хамрагдах цэнүүдийн тусгаарлах ба түгээх трансформаторуудад Щлумбергерийн 4 цэгийн электродуудын аргаар хийсэн. Энэ багажаар хэрхэн холболт хийж, хэмжснийг доор харуулав.



Щлумбергийн 4 цэгийн электродын аргаар хөрсний эсэргүүцэл хэмжих схем Зураг41.

Төслийн талбар бүрд шулуун шугамд зайг өөрчлөн хэмжилт хийсэн. Эхний ээлжинд, measurements хэмжилтийн гүйдлийн шонгийн зайг 300м хүртэл авч, (space permitting) хүчдлийн шонг 1м хүртэл өөрчлөлттэй авсан. Хэмжилтийн дүнд гүйдлийн шонг 2-300м-ийн хооронд өөрчилснөөр хэмжилтийн параметрууд, хүчдэл, гүйдэл% хөрсний хувийн эсэргүүцэл, хөрсний чанарын коэффициент бичигдсэн. Гүйдлийн шонгийн зай 2 m, 5 m, 10 m, 20 m, 30 m, 40 m, 50 m, 75 m, 100 m, 150 m, 200 m, 250 m and 300 m гэж өөрчлөгдсөн.

Хүчдлийн шин үндсэндээ 1м зайд өөрчлөгдсөн. Энэ зайг 0.5 m, 0.25 m, and 0.1 m гэхчилэн бууруулж авсан. Syscal багажны хэмжилтийн хүчдлийн утга 10 V-оос хэтрээгүй. Tests were repeated along two separate traverses at the majority of test sites to produce a worst case scenario газардуулгын хүрээний зураг төсөлд. Хэмжилт бүрийн үед хөрсний чанарын бичилт хийгдэж байсан. Хэмжилтийн явцад чанарын коэф (Q) өндөр гарсан (greater than 1 or 2%) газрын потенциалын асуудлыг тооцон хэмжилтийг дахин хийж байлаа. хөрсний төлөв байдлыг сайжруулахад бусад

